



# Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа

Судалгааны тайлан



Улаанбаатар  
2021

## Агуулга

Агуулга .....	1
Хүснэгт, зургийн жагсаалт .....	3
Товчилсон үгсийн жагсаалт .....	5
Ашигласан материалын жагсаалт .....	6
Талархал .....	9
<b>ХУРААНГУЙ</b> .....	10
<b>СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	14
Суурь судалгааны зорилго ба хамрах хүрээ .....	14
Судалгааны арга зүй .....	15
Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж .....	17
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН</b> ....	21
1.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт .....	21
1.2. Үндэсний эрх зүйн зохицуулалт .....	23
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ</b> .....	27
2.1 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа .....	27
2.1.1. Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа .....	27
2.1.2 Олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа .....	31
2.1.3. Төрийн бус байгууллагын хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа .....	33
2.2. Хохирогч хамгаалал .....	34
2.2.1 ХХГХ-ийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин .....	34
2.2.2 ХХГХ-ийн хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал .....	41
2.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа .....	46
2.3.1 Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-ийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин .....	46
2.3.2 Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-ийг хянан шийдвэрлэж буй өнөөгийн байдал .....	50
2.4 Хамтын ажиллагаа .....	53
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛ</b> .....	58
3.1 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, зан үйл .....	58
3.1.1 Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага .....	59
3.1.2 Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага .....	61
3.1.3 ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага .....	64

3.1.4 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зан үйл, дадал	67
3.1.5 Мэдээллийн эх сурвалжууд	68
3.2 Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн ойлголт, мэдлэг	70
<b>ДҮГНЭЛТ</b>	<b>75</b>
<b>ЗӨВЛӨМЖ</b>	<b>81</b>
Хавсралт 1. Хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, тэдний үзүүлж буй үйлчилгээ	83
Хавсралт 2. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, түүний төрөл, хэлбэр, хүний нөөц, санхүүжилт, цаашид нэн шаардлагатай үйлчилгээний нэгтгэл	85
Хавсралт 3. Хүний наймаатай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт	89
Хавсралт 4. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	90
Хавсралт 5. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ОУБ-ын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	92
Хавсралт 6. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-ын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	94
Хавсралт 7. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтын асуулт, бодомжуудад зөв хариулсан хувь	96

## Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хэмжих шалгуур үзүүлэлт .....	13
Хүснэгт 2. Суурь судалгааны зорилго, зорилтууд .....	14
Хүснэгт 3. Түүврийн хэмжээ, оролцогч талуудаар .....	16
Хүснэгт 4. Түүврийн хэмжээ, байршлаар .....	17
Хүснэгт 5. Үндэсний эрх зүйн баримт бичгүүд .....	24
Хүснэгт 6. Хохирогч гэж хэн бэ?.....	40
Хүснэгт 7. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнүүд .....	42
Хүснэгт 8. Хамгааллын үйлчилгээ үзүүлсэн ХХГХ-ын хохирогчдын тоон мэдээлэл .....	43
Хүснэгт 9. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дээрх хэргүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын харьцуулалт, хэргийг хүндрүүлэх зүйлчлэлээр .....	48
Хүснэгт 10. Хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бүх талуудын хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээ, оролцогч талуудаар .....	54
Хүснэгт 11. Хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээнд өгсөн тайлбарууд .....	55
Хүснэгт 12. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх оролцогч талуудын хамтын ажиллагаанд өгсөн талуудын үнэлгээ, оролцогч талуудаар .....	56
Хүснэгт 13. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлын үнэлгээний нэгтгэл ...	58
Хүснэгт 14. ХАХЭ-ийн талаарх мэдлэгийн дундаж үнэлгээний харьцуулалт .....	59
Хүснэгт 15. ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх таван бодомжноос дунджаар зөв хариулсан тоо <sup>(b)</sup> , хүйс, нас, зорилтот өрх, байршлын харьцуулалтаар .....	60
Хүснэгт 16. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд.....	61
Хүснэгт 17. Бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаарх мэдлэгийн дундаж үнэлгээ, хүйс, нас, зорилтот өрхийн харьцуулалтаар.....	62
Хүснэгт 18. Бэлгийн мөлжлөг түүний хэлбэрийн талаарх таван бодомжноос дунджаар зөв хариулсан тоо <sup>(b)</sup> , хүйс, нас, зорилтот өрх, байршлын харьцуулалтаар .....	63
Хүснэгт 19. Хүүхдийн бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй гол таван шалтгаан, эцэг эх болон хүүхдийн саналаар .....	63
Хүснэгт 20. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд.....	64
Хүснэгт 21. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ -ийн талаарх мэдлэгийн дундаж үнэлгээний харьцуулалт.....	65
Хүснэгт 22. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх 6 бодомжноос дунджаар зөв хариулсан тоо <sup>(b)</sup> , хүйс, нас, зорилтот өрхийн харьцуулалтаар .....	66
Хүснэгт 23. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд.....	66
Хүснэгт 24. Гэмт хэргийн хохирогчийн талаар мэдэгдэх гол талууд, хамгийн олон санал авсан эрэмбээр .....	68
Хүснэгт 25. Хүүхэд хамгааллын талаарх зорилтот ба зорилтот бус өрхийн эцэг эхийн мэдлэгийн дундаж үзүүлэлтийн ялгаа .....	70
Хүснэгт 26. Эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийн талаарх мэдээлэлтэй байдал	71
Хүснэгт 27. Хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө авч чадна гэсэн хариулт/зорилтот өрхөөр .....	71
Хүснэгт 28. Орчны эрсдлийн түвшин, %.....	73
Хүснэгт 29. Амьдарч буй орон нутагт нь эрх нь зөрчигдсөн, аюултай нөхцөлд амьдарч буй хүүхдүүд байдаг эсэх, %.....	74

Зураг 1. Судалгааны арга зүй, оролцогчид.....	15
Зураг 2. Газар зүйн хамрах хүрээ, түүвэр .....	16
Зураг 3. Судалгаанд оролцогчид, нийгмийн бүлгээр (n=204).....	17
Зураг 4. Судалгаанд оролцогчид, хот хөдөөгийн байршлаар (N=408) .....	17
Зураг 5. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн суварга, (n=408).....	18
Зураг 6.Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж чанар.....	18
Зураг 7. Чанарын судалгаанд оролцогч талуудын ерөнхий шинж .....	19
Зураг 8.Үндэсний хөтөлбөрийн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилт, хөтөлбөрийн дунд шатны үнэлгээний дүн, 2019 .....	28
Зураг 9. Монгол Улсын хилээр 2017-2019 онд нэвтэрсэн хүүхдийн тоо.....	30
Зураг 10. Гүүд Нэйборс ОУТББ-ын Хүүхдийн Эрх Хамгааллын хэлтсээс бэлтгэн гаргасан хүүхдийн эрх, хамгааллын тухай цуврал нэвтрүүлэг .....	32
Зураг 11. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудад тулгамдаж буй хүндрэл бэрхшээл ....	34
Зураг 12. Монгол Улсад хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй механизмын зураглал .....	44
Зураг 13. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн тоо .....	50
Зураг 14. Бүртгэгдсэн гэмт хэрэгт хохирсон насанд хүрээгүй хүний тоо .....	50
Зураг 15.Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэргийн тоо.....	51
Зураг 16.Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо.....	52
Зураг 17. Байгууллагын ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дурдсан бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж буй үнэлсэн байдал, хувиар .....	56
Зураг 18. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх хамтын ажиллагааг цаашид хэрхэн сайжруулж болох вэ? .....	56
Зураг 19. ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэгийн өөрийн үнэлгээ, хувиар .....	59
Зураг 20. ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх таван бодомжид зөв хариулсан хувь .....	60
Зураг 21. Бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэгийн өөрийн үнэлгээ, хувиар .	62
Зураг 22. Бэлгийн мөлжлөг түүний хэлбэрийн талаарх таван бодомжид зөв хариулсан хувь .....	63
Зураг 23. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэгийн өөрийн үнэлгээ, хувиар .....	65
Зураг 24. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх зургаан бодомжид зөв хариулсан хувь .....	66
Зураг 25. Гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээлэх эсэх, эцэг эхийн хувьд .....	67
Зураг 26. Гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээлэх эсэх, хүүхдүүдийн хувьд .....	67
Зураг 27. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авдаг эх сурвалжууд, эцэг эхийн хувьд.....	69
Зураг 28. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авдаг эх сурвалжууд, хүүхдүүдийн хувьд.....	69
Зураг 29. Хүүхэд хамгааллын талаарх эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг .....	70
Зураг 30. Хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учирсан нөхцөл байдлыг мэдвэл, хаана, хэнд хандаж хүүхэд хамгааллын туслалцаа авах талаар .....	72
Зураг 31. Амьдарч буй орчинд хүүхэд тань хэр аюулгүй, хамгаалагдсан гэж үзэх вэ?/байршил, өрхийн байдлаар .....	73

## Товчилсон үгсийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББШ	Баримт бичгийн шинжилгээ
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХЯ	Гадаад хэргийн яам
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний байгууллагын хүүхдийн сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУ	Олон улс
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХЭЗБ	Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОНХХ	Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХАХЭ	Хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлт
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХШҮ	Хяналт шинжилгээ, үнэлгээ
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЯХИС	Японы хүүхдийг ивээх сан



## Ашигласан материалын жагсаалт

### Олон улсын хэм хэмжээ:

1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
2. Хүүхдийн эрхийн конвенц
3. Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол
4. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц
5. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц
6. Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц
7. Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц
8. Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц
9. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц
10. Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх МУ-ын 5-р тайланд ирүүлсэн зөвлөмж
11. Хүний эрхийн төлөв байдлын тайланд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж (UPR)
12. Тогтвортой хөгжил 2030 Засгийн газрын тайлан, Иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн тайлан

### Үндэсний хууль тогтоомж:

13. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012, №7
14. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №7
15. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30
16. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2019, №42
17. Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1999, №30
18. Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2018, №6
19. Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2002, №23
20. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2019, №48
21. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017, №24
22. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1998, №3
23. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1999, №25
24. Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №9
25. Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №9
26. Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040:2009), Стандартчилал, хэмжил зүйн газар, 2009
27. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6418:2013), Стандартчилал, хэмжил зүйн газар, 2013
28. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040:2019), 2019 оны Стандартчилал, хэмжил зүйн газар, 2019
29. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт
30. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт

31. Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт
32. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 25-ны өдийн 01/149 тоот тушаал)
33. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал
34. Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал
35. Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаал
36. Хууль зүйн сайдын 2017 оны А/49 тушаал. Хүүхдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам
37. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал
38. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал
39. Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал,
40. Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал
41. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх" журам.
42. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх" журам
43. Төрийн мэдээллийн эмхтгэл Дугаар 07, 2012
44. Төрийн мэдээллийн эмхтгэл Дугаар 30, 2013
45. Төрийн мэдээллийн эмхтгэл Дугаар 23, 2017
46. Төрийн мэдээллийн эмхтгэл Дугаар 05, 2017
47. Төрийн мэдээллийн эмхтгэл Дугаар 24, 2017

#### **Судалгааны ажил:**

48. Барилгын салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тодорхойлох түргэвчилсэн судалгаа - 2015
49. Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа-2010
50. Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл-2019
51. Зарим хот, хилийн боомтын үйлчилгээний салбарт ажиллаж буй хүүхэд, залуучуудын бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл, үйлчилгээний салбарын гадна биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн судалгаа-2005
52. Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд-2008
53. Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ - 2015
54. Монгол Улсын бодлогын хураангуй: Албадан хөдөлмөр-2016
55. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцын 2014 оны протоколд орох боломжийг тодорхойлох зорилгоор Монгол улсын холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ-2019
56. Өсвөр насны охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудал:Баримтын судалгаа-2017
57. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал - 2018
58. Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл-2017
59. Тээгч эх ба тээгч эхээр тээлгэж төрүүлэх харилцааны талаарх Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт – 2017
60. Хараа хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаарх экспертийн санал асуулгын судалгаа, дүн шинжилгээ - 2011
61. Хаврын хурдан морины уралдаан дахь хүүхдийн эрх - 2016
62. Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх-2015
63. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2015, АНУ-ын Төрийн департамент
64. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2016, АНУ-ын Төрийн департамент



65. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2017, АНУ-ын Төрийн департамент
66. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2018, АНУ-ын Төрийн департамент
67. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2019, АНУ-ын Төрийн департамент
68. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2020, АНУ-ын Төрийн департамент
69. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан-2021, АНУ-ын Төрийн департамент
70. Хүн худалдаалах гэмт хэрэг ба охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг-2007
71. Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх-2008
72. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг үнэлэх судалгааны тайлан-2017
73. Хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага – 2018
74. Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа – 2012
75. Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн
76. Суурь судалгааны хэрэгцээ шаардлага IRIM, 2021
77. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт тайлан, 2019
78. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага-2007
79. “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан, ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ, 2017
80. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгааны тайлан, ХЗДХЯ, АХБ, IRIM, 2020

## Талархал

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгааны тайлан нь Монгол Улс дахь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхэд залуусын мэдлэг ойлголтын талаар ерөнхий дүр зургийг танилцуулах болно. Тус тайланг боловсруулахын тулд олон талын эх сурвалжийн мэдээлэлд үндэслэсэн бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд залуусаас асуумжийн аргаар судалгаа авч, үр дүнг тогтолцооны оролцогч талуудаас цуглуулсан чанарын мэдээллээр баяжууллаа.

Судалгааны багийн зүгээс энэхүү суурь судалгааны ажлыг гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн Хууль зүй дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба (ГХУСАЗЗАА), Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам (ХНХЯ), Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) болон бусад судалгаанд хамрагдсан төр, төрийн бус, олон улсын байгууллагын оролцогчид, үзэл бодол туршлагаа хуваалцсан нийт судалгаанд оролцогчдод талархлаа илэрхийлж байна.

Ялангуяа судалгааны явцад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын болон Азийн сангийн төслийн багийн хамт олонд талархлаа.

### МЭДЭГДЭЛ

Энэхүү суурь судалгааг АНУ-ын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулсан.

Суурь судалгааны тайлан дахь дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд АНУ-ын Төрийн Департамент, ДЗМОУБ, болон судалгаанд хамрагдсан бусад оролцогч талуудын байр суурийг илэрхийлэхгүй болно.

### СУДАЛГААНЫ БАГ

Гүнсэнчоймболын Амаржаргал	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Монхооройн Батбаатар	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Доржинямбуугийн Бямбасүрэн	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Жаргалсайханы Жавхлан	Төслийн зохицуулагч, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач
Болдын Болор	Туслах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач
Алтанхуягийн Очбадрал	Дата шинжээч, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2020 онд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-ний хүрээнд Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллага (ДЗМОУБ) болон Азийн сан хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн суурь судалгааны гүйцэтгэгчээр IRIM судалгааны хүрээлэн 2020 оны 04 дүгээр сараас эхлэн ажиллалаа. Уг судалгааг ажлын даалгаварт туссаны дагуу дараах зорилгын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

**Зорилго 1.** Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох;

**Зорилго 2.** Төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн суурь шалгуур үзүүлэлтийг тодорхойлох үндсэн зорилгын хүрээнд уг судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааг гүйцэтгэхэд тоон болон чанарын мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглан, COVID-19 цар тахлын дэгдэлттэй, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан цахимаар зохион байгуулсан. Төслийн зорилтот орон нутгийн нийт 204 эцэг эх, тэдгээрийн 14-17 насны 204 хүүхдээс асуумжийн аргаар, тогтолцооны гол оролцогч тал болох төр, төрийн бус, олон улсын байгууллагын 33 төлөөллөөс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулж, тайланг боловсруулав.

Судалгааны үндсэн зорилтуудын дагуу суурь судалгааны гол үр дүнг тоймлон харуулбал:

### **Зорилго 1. Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал**

Хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг авч үзэхдээ гэмт хэрэгтэй тэмцэх систем, холбогдох интервенцийг төлөвлөхөд нийтлэг ашиглагддаг 4P-ийн парадигм болох урьдчилан сэргийлэх (prevention), хохирогчийг хамгаалах (protection), хэрэг хянан шийдвэрлэх (prosecution) болон хамтын ажиллагаа (partnership) гэсэн үндсэн 4 дэд бүлгийн хүрээнд судалсан. Эдгээр дэд бүлгийн дагуух судалгааны үр дүнг нэгтгэвэл:

**1.1 Урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Хүүхдийг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын байгууллага (ОУБ), төрийн байгууллага, төрийн бус байгууллага (ТББ)-ын хувьд харилцан адилгүй үйл ажиллагааг (үндсэн чиг үүрэг болон өөрсдийн санаачлагаар) хэрэгжүүлж байна. Хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь зохих хэмжээний хөрөнгө санхүү шаардсан ажил боловч, хүүхдийг нэгэнт хохирогч болсны дараа урт хугацаанд ажиллахаас бага төсөв, зардал шаарддаг болохыг судалгаанд оролцогчид тэмдэглэж байв.

Төрийн байгууллагаас хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй боловч, салбар дундын хамтын ажиллагаагаа сайжруулах, зарим үйл ажиллагаагаа нэгтгэх шаардлагатай байгаа нь ажиглагдаж байв. Мөн хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зардлаа жил бүр байгууллагынхаа төсөвт суулгах, алба хаагч, мэргэжилтнүүдийнхээ мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үе шаттай ажил зохион байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ОУБ-уудаас төрийн бодлого, шийдвэр, хууль эрх зүйн орчныг бий болгох, техникийн зөвлөн туслах үйл ажиллагаанд анхаарч ажиллаж байна. Харин ТББ-аас хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээлэл түгээх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг хийж, хэрэгжүүлж байгаа боловч үйл ажиллагаа нь байгууллагын онцлог, хамрах хүрээ, чадавхаас хамаарч тодорхой нэг төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа онцлог ажиглагдаж байна.

**1.2 Хохирогч хамгааллын чиглэлээр:** Монгол Улсад ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн ХХГХ-ийн хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээ хангалтгүй байна.

Өнөөгийн байдлаар ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдийг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний журмын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдтэй нэг түвшинд авч үзэж байгаа бөгөөд онцгой хамгаалалтад авах, үйлчилгээ үзүүлэх зохицуулалтгүй, бусад хэлбэрийн дарамт, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдтэй ижил түвшинд үйлчлэхээр зохицуулалттай байна. Гэвч ХХГХ-ийн онцлог, насанд хүрээгүй хүүхдэд ирэх урт хугацааны сөрөг нөлөөллийг харгалзвал энэ төрлийн тусгай зохицуулалт Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх холбогдох журмуудад тусгалаа олох зайлшгүй шаардлагатай байна.

ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь төсөл, хөтөлбөрийн хүрээнд ОУБ-ын дэмжлэгтэйгээр ТББ-уудад хэрэгжүүлж байна. ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний зураглалаас үзэхэд ТББ-уудын хохирогч руу чиглэсэн үйлчилгээ нь анхан шат болон нөхөн сэргээх, холбон зуучлах гэсэн төрөлтэй бөгөөд үйлчилгээнд зарцуулж буй хугацаа нь харилцан адилгүй байлаа. Тодруулбал ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр тогтмол үйлчилгээ үзүүлж байгаа нь Талита Ази, ХТЭТ, ХЭҮТ зэрэг байгууллагууд бөгөөд тэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хамгаалах байр ажиллуулдаг байна. Талита Ази ТББ-ын хамгаалах байранд хохирогчийг урт хугацаагаар буюу 3 жил хүртэл байрлуулж байсан туршлагатай. Бусад үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд (*Гүүд нейборс ТББ, Анбаунд Монгол ТББ, Иргэдэд туслах хүний эрх төв, Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээ, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, Лантуу дохио ТББ*) нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдод анхан шат, нөхөн сэргээх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг ба эдгээр байгууллагууд нь ХХГХ-ийн хохирогчийг илрүүлсэн тохиолдолд дагнасан, мэргэжлийн байгууллагууд болох дээрх нэр бүхий байгууллагууд руу холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг байна.

Харин судалгааны хүрээнд төрийн байгууллагын түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), Түр хамгаалах байрны гурван нийгмийн ажилтантай уулзахад Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь төрийн Түр хамгаалах байранд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хоёр хохирогч хүүхдийг байрлуулсан туршлагатай байлаа. Төрийн болон төрийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүд хүүхэд худалдах гэмт хэргийг илрүүлэх, таньж мэдэх, тогтооход ойлголт, мэдлэг, туршлага бага тул энэ чиглэлээр илүү мэргэшүүлэх сургалтад хамрагдах, хүний нөөцийн нэмэгдүүлэх хэрэгцээ их байна. Мөн ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдэд нас сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээг бий болгох, тусгайлсан хамгаалах байртай шаардлагатайг онцлон илэрхийлж байсан.

**1.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:** Цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын статистик мэдээллээс үзэхэд хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах болон, түүнтэй төстэй гэмт хэргийн гаралт, гэмт хэргийн хохирогч болж буй хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд тогтвортой өсөх хандлагатай байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ-ийн тодорхойлолт нь Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (цаашид Палермогийн протокол гэх)-ын тодорхойлолттой агуулгын хувьд нийцсэн боловч ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг (*бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг авах*) бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй, тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байна.

Түүнчлэн төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, холбогдох журам батлагдан гараагүй нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч чадахгүй байх нөхцөл бүрдсэн байна.

**1.4 Хамтын ажиллагааны чиглэлээр:** Хамтын ажиллагааны чадавхын өнөөгийн байдлыг тодорхойлоход нийт 25 байгууллагыг хамрууллаа. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэхэд бүх талуудын хамтран ажиллах сонирхол, санаачилга сайн, ялангуяа энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд талуудын хамтын ажиллагаа харьцангуй сайн байна. Байгууллагуудын хувьд хамтран ажиллах хүсэл, санаачилга жигд өндөр (4-4.3) гэж үнэлсэн нь үндсэн давуу тал болж байна. Тухайлбал, төрийн байгууллагуудын хувьд хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг болон хохирогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд ТББ болон ОУБ-тай хамтран ажиллах байдлаа харьцангуй сайн гэж үнэлсэн. Тэгвэл ТББ-ын төлөөллүүд үүний эсрэг байр суурьтай байсан бөгөөд дурдсан үйл ажиллагаанд бусад оролцогчдын хамтран ажиллах байдал хангалтгүй буюу дунджаас доогуур (2.9) гэсэн үнэлгээ өгсөн нь анхаарал татаж байна.

Ерөнхийдөө илрүүлэх, хохирогчийг хамгаалах, хохирогчид нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлд талуудын хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь ажиглагдлаа. Хамтын ажиллагааны хувьд хэрэг илрүүлэлт, хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл байхгүй, байгууллагууд мэдээллээ солилцох, нэгдмэл бодлого, нэгдсэн төлөвлөгөөтэй, харилцан уялдаатай ажиллах байдал сул байна. Судалгаанд оролцогч байгууллагууд хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх хамтын ажиллагааг сайжруулахын тулд хамтын ажиллагааны гүйцэтгэлээ жил бүр үнэлэх, итгэлцэл дээр суурилсан хамтын ажиллагааны үнэт зүйлийг бий болгох, хамтын ажиллагааны гарах үр дүнг тодорхой болгох, хамтын ажиллагааны нэгдсэн зорилгыг тодорхой болгох зэрэг байр суурийг илэрхийлсэн юм.

**1.5 Олон нийтийн мэдлэг, ойлголтын тухайд:** Эцэг эх, хүүхэд залуучуудын ХХГХ-ийн талаарх мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлохдоо түүний илрэх хэлбэрүүд болох бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн хүрээнд авч үзлээ. ХХГХ, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага нийтээрээ тааруу байна. Ялангуяа хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага хангалтгүй байна. Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг, хандлага дунд түвшинд үнэлэгдлээ. Харин хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг дунд түвшинд үнэлэгдсэн ч уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага эцэг эх, хүүхдийн аль алинд нь хангалтгүй байна.

## Зорилго 2. Төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн суурь шалгуур үзүүлэлт

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Хил хамгаалах ерөнхий газар, үйлчилгээ үзүүлэгч ТББ-тай хийсэн ярилцлага болон статистик мэдээлэл, төслийн зорилтот орон нутгийн өрхүүдээс цуглуулсан асуумж судалгааны үр дүнд үндэслэв (Хүснэгт 1). Эдгээр суурь үзүүлэлтийг тайлбарлах судалгааны дэлгэрэнгүй үр дүнтэй тайлангийн үндсэн бүлгээс танилцах боломжтой.

### Хүснэгт 1. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хэмжих шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлтүүд		Суурь дүн
<b>Хохирогч хамгаалал:</b> ИНБ-ууд кейс менежментийн протокол дээр үндэслэн тайлагнах, лавлагаа өгөх систем, хүүхэд хамгааллын өнөөгийн механизмтай хамтран ажиллах чадавх	Хилийн хяналт, шалгалтаар илэрсэн ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоо	0
	Хилийн хяналт шалгалтаар илэрч үйлчилгээний байгууллагад холбон зуучилсан ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоо	0
	Урт хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо (2017 оноос хойшхи)	15
	Богино хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо (2017 оноос хойшхи)	55
<b>Урьдчилан сэргийлэх:</b> Олон нийт болон хүүхэд залуусын ХХГХ, нэн ялангуяа бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг ойлголт	Бусдын дэмжлэггүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг авч чадна гэж хариулсан зорилтот өрхийн хувь	35.8%



## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

IRIM судалгааны хүрээлэнгийн баг 2021 оны 4 дүгээр сараас эхлэн “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн суурь судалгааг хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны ажлаар Монгол Улсад хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж төр болон иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудыг чадавхжуулахад санал зөвлөмж боловсруулахаар зорьсон.

### Суурь судалгааны зорилго ба хамрах хүрээ

Ажлын даалгаварт өгөгдсөний дагуу судалгааны баг дараах зорилго, зорилтуудын хүрээнд суурь судалгааг гүйцэтгэв. Үүнд:

#### Хүснэгт 2. Суурь судалгааны зорилго, зорилтууд

	Зорилго	Зорилтууд
Нэг	Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох	1. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ЗГ болон ИНБ-уудын хамтын ажиллагааны түвшинг үнэлэх
		2. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн түвшинг үнэлэх
		3. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх хохирогч хамгааллын үйлчилгээний зураглал гаргах
		4. Олон нийтийн ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг үнэлэх
Хоёр	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	1. Хилийн хяналт, шалгалтаар илэрсэн ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоог тодорхойлох
		2. Хилийн хяналт шалгалтаар илэрч үйлчилгээний байгууллагад холбон зуучилсан ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоог тодорхойлох
		3. Урт болон богино хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоог тодорхойлох
		4. Сонгогдсон орон нутаг дахь гаднын ямар нэгэн дэмжлэггүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг авч чадна гэж хариулсан өрхийн хувийг тодорхойлох


Дээрх зорилтуудын хүрээнд суурь судалгааны тайланг үндсэн гурван бүлгийн хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн орчин
2. Монгол Улсад хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн тогтолцооны нөхцөл байдлыг судлахдаа ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр олон улсын конвенц, баримт бичгүүдэд авч үздэг 4P парадигмын дагуу судалгааны үр дүнг боловсруулж шинжилсэн. Үүнд:
  - Урьдчилан сэргийлэх,
  - Хохирогч хамгаалал
  - Хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа
  - Хамтын ажиллагааны хүрээнд тогтолцооны нөхцөл байдлыг авч үзсэн.
3. Олон нийтийн ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлохдоо бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг болон ХХГХ-ийн талаарх эцэг, эх, хүүхдийн мэдлэг ойлголт, хандлага, зан үйлийг тодорхойлох мэдээллийг цуглуулж хооронд нь харьцуулан шинжилгээ хийв.

## Судалгааны арга зүй

Суурь судалгааны зорилтуудад хүрэхийн тулд судалгааны баг тоон болон чанарын аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулан шинжилгээ хийв.

Зураг 1. Судалгааны арга зүй, оролцогчид



**Тоон судалгаа:** Ажлын даалгаварт өгөгдсөний дагуу хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-ийн талаарх олон нийт, тэр дундаа эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхэд залуусын мэдлэг ойлголтыг тодорхойлохдоо сонгогдсон орон нутгийн өрхийн эцэг, эх, асран хамгаалагч, 14-17 насны хүүхэд залуусын төлөөллийг хамруулан тоон судалгааг зохион байгуулсан. Эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдийн мэдлэг ойлголтын ялгаатай байдлыг харах зорилгоор тоон судалгааг нэг өрхийн (1) эцэг эх, асран хамгаалагч (2) хүүхдийн судалгааг авах зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэсэн.

**Чанарын судалгаа:** Чанарын судалгааны хүрээнд Зураг 1.-д харуулсанчлан хоёр төрлийн аргаар мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд баримт бичгийн судалгааг сэдвийн судлах шаардлагатай хууль эрх зүйн баримт бичиг, холбогдох ижил төстэй судалгаа, эрдэм шинжилгээний материалууд болон албан эх сурвалжийн тоон мэдээллүүдийг цуглуулж нийт 80 бичиг баримтыг тайланд ашиглав.

Түүнчлэн хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-ийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ-ууд, тогтолцооны холбогдох (n=33) оролцогч талуудаас ганцаарчилсан ярилцлага, оролцогч талуудын хамтын ажиллагааны өнөөгийн түвшинг үнэлэхээр хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

## Газарзүйн хамрах хүрээ ба судалгааны түүвэр

Суурь судалгааны тоон мэдээлэл цуглуулалтыг төслийн зорилтот орон нутгууд буюу Улаанбаатар хотын Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд, Дорноговь аймгийн Замын-Үүд болон Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумыг хамруулан зохион байгуулав.

Зураг 2. Газар зүйн хамрах хүрээ, түүвэр



Эдгээр зорилтот талбаруудаас судалгааны зорилтод хамаарах мэдээллийг ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны гол оролцогч, үйлчилгээ үзүүлэгч байгууллага<sup>1</sup> болон олон нийтийн төлөөллөөс цуглуулсан. Тоон судалгаанд хамаарах өрхийг сонгохдоо IRIM судалгааны хүрээлэнгийн дотоод мэдээллийн сан болон аймаг, дүүргийн ГБХЗХГ-ын дэмжлэгтэйгээр 14-17 насны хүүхэдтэй<sup>2</sup> өрхийн жагсаалт бүрдүүлж түүврийг хангаж ажиллаа. Судалгаанд оролцогчдын түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3. Түүврийн хэмжээ, оролцогч талуудаар

#	Оролцогч талууд	Судалгаанд хамруулсан төлөөлөл	Арга	Түүврийн хэмжээ
1	Төрийн албан хаагч	ХЗДХЯ-ГХУСАЗЗАА, БШУЯ, ГХЯ, ЭМЯ, ХНХЯ, Шүүх, Прокурор, Цагдаа, ГИХГ, ХХЕГ, ХХҮХ, МХЕГ, ГБХЗХГ	Ганцаарчилсан ярилцлага, асуумж, тоон мэдээлэл	14
2	Үйлчилгээ үзүүлэгч талууд, ТББ, ОУБ	ТББ-ууд, түр хамгаалах байр, НЦҮТ, асрамж халамжийн төв	Ганцаарчилсан ярилцлага, асуумж, тоон мэдээлэл	19
3	Өрх ( эцэг, эх, асран хамгаалагч)	Төслийн зорилтот байршил тус бүрээс	Асуумж	204
4	14-17 насны хүүхэд	Төслийн зорилтот байршил тус бүрээс	Асуумж	204

<sup>1</sup> ХХГХ-ийн хохирогчид нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартын нэр томъёог ашигласан.

<sup>2</sup> Асуудалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгч өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахуйц насны онцлогийг харгалзан сонгосон.

#### Хүснэгт 4. Түүврийн хэмжээ, байршлаар


	Байршил	Улаанбаатар					Дорноговь	Өмнөговь		Нийт
		БЗД	БГД	СБД	СХД	ЧД	Замын-Үүд	Ханбогд	Цогт-цэций	
1	Төрийн албан хаагчдын ярилцлага	12					1	1		14
2	Үйлчилгээ үзүүлэгч талууд, ТББ, ОУБ, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээтэй хийсэн ярилцлага	17					1	1		19
3	Олон нийт (эцэг, эх, асран хамгаалагч)	30	24	23	33	30	32	16	16	204
4	14-17 насны хүүхэд	31	26	22	30	30	31	21	13	204

### Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж


Судалгаанд хамруулсан талуудын ерөнхий тоон мэдээлэл, хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн ерөнхий шинж чанаруудыг нэгтгэн харууллаа.

**Тоон судалгаа.** COVID-19 цар тахлын үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан суурь судалгааны тоон мэдээлэл цуглуулалтыг дуудлагын төвд суурилан зохион байгуулсан. Ингэхдээ IRIM судалгааны хүрээлэнгийн дотоод мэдээллийн сан болон аймаг дүүргийн ГБХЗХГ-ын дэмжлэгтэйгээр өрхийн жагсаалтыг бүрдүүлж нийт 408 оролцогчдыг судалгаанд хамруулсан. Үүнд 204 эцэг, эх, асран хамгаалагч болон 204 нь 14-17 насны хүүхдүүд багтсан болно. Судалгаанд оролцогчдыг байршлаар нь харвал 68.4% нь Улаанбаатар хотоос үлдсэн хувь нь орон нутгаас хамрагдсан байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчид, хот хөдөөгийн байршлаар (N=408)



Зураг 3. Судалгаанд оролцогчид, нийгмийн бүлгээр (n=204)



Судалгааны баг амьжиргааны түвшний хувьд зорилтот өрх болон бусад өрхийн хооронд ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтод ялгаа бий эсэхийг харах зорилгоор нийт түүвэрт өрхийг харьцуулж ажилласан. Суурь судалгааны хүрээнд зорилтот өрхөд амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийг сонгож хамруулсан. Гэвч мэдээлэл цуглуулалтын үр дүнгээс судалгаанд оролцогч өрхийг нийгмийн бүлгээр нь ангилж харвал 35.8% нь зорилтот бүлгийн өрх хамрагдсан байна. Учир нь мэдээлэл цуглуулалтын үеэр судалгааны сэдвийн онцлогоос хамааран эрэгтэй асран хамгаалагч нар ярилцлага өгөхөөс татгалзах хандлага их байв. Судалгаанд хамрагдсан оролцогчдыг нас, хүйсээр нь задалж харвал:

Зураг 5. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн суварга, (n=408)



Зураг 5-аас харвал 36-аас дээш насны эмэгтэй асран хамгаалагч нар түлхүү судалгаанд хамрагдсан байна. Сэдвийн онцлог, нуугдмал байдлаас хамааран судалгааны баг хүүхдүүдийг судалгаанд хамруулахдаа асуудалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгч өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахуйц байдлыг харгалзан 14-17 насны хүүхдүүдийг хамруулахаар төлөвлөж мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэсэн. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг хүйсээр нь харвал эрэгтэй 49%, эмэгтэй 51%-ийн харьцааг барьж мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийт судалгаанд хамрагдсан өрхийн өрхийн тэргүүний (n=204) боловсролын түвшний хувьд талаас дээш хувь нь буюу 59.8% нь бүрэн дунд боловсролтой бөгөөд бага боловсролтой, боловсролгүй оролцогчид бага байна. Хөдөлмөр эрхлэлтийн (n=204) хувьд ойролцоогоор 50% нь байнгын ажил эрхэлдэг. Харин нийт судалгаанд хамрагдсан 204 өрхөөс хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй өрх 6.4%-ийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн ам бүлийн гишүүдийн тоогоор нь харвал 4-6 гишүүнтэй өрхүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 6. Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж чанар



**Чанарын судалгаа.** Чанарын мэдээлэл цуглуулалтын хүрээнд ярилцлагыг ганцаарчилсан болон хагас бүтэцлэгдсэн хувилбаруудаар зохион байгуулсан. Чанарын ярилцлагыг хүүхэд хамгаалал, ХХГХ-тэй тэмцэх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг нийт 33 оролцогч талтай хийсэн (Зураг 7).



## Нэр томъёо, ойлголтын хүрээ

Суурь судалгааг “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” төслийн баримт бичгүүдтэй уялдуулан дараах нэр, томъёо, ойлголтын хүрээнд гүйцэтгэв:

- **Хүн худалдаалах гэмт хэрэг болон хүн худалдаалах гэдэг** нь хүн наймаалагч этгээд хүний хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хууран мэхэлж, эсвэл албадаж аливаа хүнийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл арилжааны сексийн зорилгоор уруу татах, хорих, тээвэрлэх, хүн олж өгөх, эсвэл хүн олж авах үйлдлийн ерөнхий нэр томъёо юм. Албадан эрхшээлдээ оруулах гэдэгт боолчлол, өрийн боол болон албадан хөдөлмөр эрхлэлттэй ойролцоо хүний эрхшээлд боолчлолд өртөх, боолчлол болон ижил төстэй дадал практик багтана. Хүн худалдаалах гэмт хэрэг нь заавал шаардахгүй ч нэг газраас нөгөө газар луу хөдлөх хөдөлгөөнийг багтааж болно. Энэ гэмт хэргийн хамгийн гол хүчин зүйл нь хүн наймаалагч этгээд хохирогчийг мөлжиж, боолчлох зорилготой байх бөгөөд ингэхийн тулд тэд төрөл бүрийн албадах болон хууран мэхлэх арга замыг ашигладаг;
- **Хүүхэд худалдаалах гэмт хэрэг** гэдэгт хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт ашиглах зэрэг багтана;
- **Хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлт** гэдэг нь ХХГХ-ийн нэгэн хэлбэр бөгөөд хүн наймаалагч этгээд хүүхдийг албадан ажиллуулж ашиг олох явдал юм. Албадан хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор хүүхдийг уруу татах, хорих, тээвэрлэх, бусдад хүүхэд олж өгөх болон хүүхэд олж авдаг аливаа этгээдийг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцно. Хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэгт хүүхдийг өөрийн санхүүгийн ашгийн төлөө түүний ойр дотнын гэр бүлийн гишүүдээс бусад этгээд хүүхдээр албадан ажил хийлгэж, эрхшээлдээ байлгах аливаа нөхцөл байдал багтдаг. Түүнчлэн хүүхдийн эцэг, эхийн аль нэг нь хүүхдээ бусдын эрхшээлд хөдөлмөр эрхлүүлэхээр бусдад өгөх нөхцөл байдал энэ гэмт хэрэгт багтана. Албадан хөдөлмөр эрхлэлтээс хохирогч хүүхдэд мөлжлөгийн харилцаа бүхий ажлын нөхцөлийг орхих сонголт гэж байхгүй. Хүүхдийг албадан хөдөлмөр эрхлэлтийн зорилгоор мөлждөг хүн наймаалагч этгээд нь ихэвчлэн хүүхдийг зүй ёсоор асран халамжилдаггүй, сургуульд явуулдаггүй бөгөөд улмаар бие махбод, сэтгэл санааны хувьд хүчирхийлдэг;
- **Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхдийг худалдаалах** нь ХХГХ-ийн нэгэн хэлбэр бөгөөд хүн наймаалагч этгээд нь арилжааны сексийн үйлдэл хийлгэж ашиг олох зорилгоор хүүхдийг уруу татах, хорих, тээвэрлэх, хүүхэд олж авах, бусдад хүүхэд олж өгөх, сурталчлах, эгнээндээ элсүүлэх, халамжилж буй мэт дүр эсгэх, ивээн тэтгэх зэрэг үйлдлийг хэлнэ. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхэд худалдаалах гэмт хэрэгт тооцохын тулд хүч хэрэглэх, албадах, эсвэл хууран мэхлэх зэрэг үйлдэл шаардлагагүй. Хүн худалдаалагч гэмт этгээд нь хүүхдийг арилжааны сексийн үйлдэл, эсвэл бусад бэлгийн харилцааны зүй бус үйлдэл хийлгэж интернетээр бодит цаг хугацаанд бичлэг хийх болон бусад хэрэгсэл ашиглан олон нийтэд цацах үйлдэл нь бэлгийн



мөлжлөгийн зорилгоор үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр бөгөөд үүнийг ихэвчлэн цахим ертөнц дэх хүүхдийн бэлгийн мөлжлөг гэж нэрлэдэг.

- **Хүүхэд** гэж 18-аас доош насны хүнийг хэлнэ.
- **Өрх**<sup>3</sup> гэдэгт Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.
- **Өрхийн тэргүүн**<sup>4</sup> гэдэг нь өрхийн гишүүд хэнийгээ тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Ингэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-аас дээш насны бөгөөд өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүлэгчээр өргөмжилсөн хүн байна. Хэрвээ өрхийн тэргүүлэгчээр тодорхойлж чадахгүй бол тухайн өрхийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа хүнийг өрхийн тэргүүнээр авч болно.

## Судалгааны хязгаарлагдмал тал

Энэхүү суурь судалгааг хязгаарлагдмал хугацаа болон төслийн хэрэгцээнд нийцүүлэн гүйцэтгэсэн тул судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүний агуулгын хувьд тодорхой хүрээнд хязгаарлагдах нь зайлшгүй. Иймд суурь судалгааны хамрах хүрээ дараах хүрээнд хязгаарлагдана:

- **Судалгаанд оролцогчдын насны хязгаар:** Суурь судалгаагаар ХХГХ-ийн талаарх хүүхдийн мэдлэг ойлголтыг тодорхойлохдоо асуудалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгч өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахуйц чадахуйц 14-17 насны хүүхдийг сонгож хамруулсан.
- **Тоон шинжилгээний хүрээ:** Судалгааны хязгаарлагдмал тал нь тоон судалгааны түүврийн хэмжээ нь үндэсний хэмжээг төлөөлөхгүй бөгөөд зөвхөн судалгаанд хамрагдсан сонгогдсон орон нутгийн иргэдийн нөхцөл байдлыг илэрхийлнэ.
- **Бүлгийн ярилцлагын аргыг судалгаанд ашиглахгүй тухай.** Ажлын даалгаварт ИНБ болон олон нийтийн төлөөлөлтэй фокус бүлгийн ярилцлага хийхээр тусгагдсан байсан. Гэвч судалгааны баг COVID-19 цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдал, дотоодын халдварын тархалт ихэссэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, халдварт өвчний тархалтыг хумих зорилгоор авч хэрэгжүүлж буй хязгаарлалтын дэглэм, нэг дор таваас дээш хүн цугларахыг хориглосон, цар тахлын эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлт нөхцөл байдал өндөр хэвээр байна.

(1) Дээрх нөхцөл байдлыг харгалзан олон нийтийн төлөөлөлтэй фокус бүлгийн ярилцлага зохион байгуулахаас татгалзаж буйгаа эхлэлтийн тайланд тусгаж захиалагч талаас зөвшөөрөл авсан. Уг зохицуулалттай холбоотойгоор олон нийтээс 408 асуумжийг цуглуулж судалгааны түүврийн хэмжээг нэмэгдүүлсэн.

(2) ИНБ-аас тодруулах мэдээллийг ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан.

---

<sup>3</sup> Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаал)

<sup>4</sup> Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 1.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсад боолчлол, боолын худалдаа болоод хүний наймааг хориглох анхны алхам нь 1807 онд АНУ, Их Британи улсад боолчлолын эсрэг анхны хууль батлагдсан явдлаар эхэлсэн гэж үздэг. Тэгвэл өдгөө тус гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд нийт 15 олон улсын олон талт гэрээ мөрдөгдөж байгаагийн 13-д нь Монгол Улс нэгдэн орж, улс орныхоо хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна. Олон улсын баримт бичгүүдийн жагсаалттай Хавсралт 3. Хүний наймаатай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалтаас танилцана уу. Тэдгээр баримт бичгээс хүүхдийг ХХГХ-ийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх талаар тусгайлсан заалт бүхий гол баримт бичгүүдийг авч үзвэл:

1. **Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол:** НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан уг протокол (цаашид Палермогийн протокол гэх) нь Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт протокол юм. Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тус конвенц болон түүний нэмэлт протоколд нэгдэн орсон.

НҮБ-ын энэхүү конвенцоор үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдсон нэр томьёо, түүнийг мөрдөн байцаах, шалгах, урьдчилан сэргийлэх болон шүүн шийдвэрлэх, яллагдсан этгээдийг шилжүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан төдийгүй түүний нэмэлт протоколд хүн ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх талаар онцгойлон авч үзсэнээрээ онцлог ба ХХГХ-ийн гол объект болох эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг тусгайлан хамгаалсан чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн гол баримт бичиг болж байна. Уг протоколд насанд хүрээгүй хүний эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэргийг ямар аргаар үйлдсэнийг хамаарахгүй гэдгийг онцолсон байдаг.

2. **Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол:** 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан уг протоколд хүүхдийг худалдах<sup>5</sup>, хүүхдийн биеийг үнэлэх<sup>6</sup> болон хүүхдийг садар самууныг сурталчлах<sup>7</sup> зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил давуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн, хүүхдэд аюултай секс аялал өргөжин үргэлжилж, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртөгсдийн харьцангуй дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгаа, интернет болон бусад дэвшилтэт технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаа зэргийг гол үндэслэл болгосон байдаг. Улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд улс орнуудын эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хуульдаа тусгах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн

<sup>5</sup> хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ;

<sup>6</sup> хүүхдийн биеийг үнэлэх гэж шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг хэлнэ;

<sup>7</sup> хүүхдийг садар самуунд сурталчлах гэж хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ.

дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар зааж өгснөөрөө онцлогтой.

3. **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц:** 2000 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон уг конвенц нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх үндсэн баримт бичиг болох Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны конвенц болон түүний зөвлөмжийг төгөлдөржүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгах асуудлыг үндэсний болон олон улсын хэмжээнд, ялангуяа олон улсын хамтын ажиллагаа, туслалцааг тэргүүлэх чиглэл болгоход чиглэсэн. Ингэхдээ хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр<sup>8</sup>-ийг үр дүнтэй устгах нь суурь боловсролыг үнэ төлбөргүй олгохын ач холбогдол, хүүхдийг дээрх хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нийгмийн амьдралд дасгах болон оруулах, ингэхдээ гэр бүлийнх нь хэрэгцээг анхаарах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн шалтгаан нөхцөлийг судлан шийдвэрлэх зорилтыг оролцогч улсуудад тавьснаараа онцлогтой.

Албан ёсоор олон улсын хэмжээнд батлан, хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан эдгээр гол баримт бичгүүдийг Монгол Улс үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусгасан, нийцүүлж хэрэгжүүлж буй эсэхийг олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлангуудад тусган хүргүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ыг баталсан.<sup>9</sup> 2020 оны 6 сарын байдлаар Монгол Улс нийт 293 олон улсын олон талт гэрээнд нэгдэн орсон боловч дээрх тогтоолын 2 дугаар хавсралтаар нэр бүхий 30 олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан, түүнийг хариуцан гаргах эрх бүхий байгууллагыг тогтоосон. Энэ жагсаалтад ХХГХ-тэй холбоотой асуудлыг авч үзсэн дараах гэрээ конвенцууд багтжээ:

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний нэмэлт протокол,
- Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц,
- Хүүхдийн эрхийн конвенц,
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол

Эндээс үзвэл олон улсад ХХГХ-ийн тэр дундаа хүүхдийг эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мөрдөгдөж буй гол баримт бичгүүдээс Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт протоколын хэрэгжилтийн тайланг бэлтгэн хүргүүлдэг бол Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протокол, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцын хэрэгжилттэй холбоотой бие даасан тайлан өнөөгийн байдлаар боловсруулагдахгүй байгаа бөгөөд Хүний Эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийн төлөв байдлын ерөнхий тайланд дэд хэсэг болгон тайлагнаж байна.

---

<sup>8</sup> “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт:

- боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа;
- хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
- олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
- ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.

<sup>9</sup> <https://www.legalinfo.mn/law/details/12817>

## 1.2. Үндэсний эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилснаар ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд “Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна. Улмаар 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд баталж, хэрэгжүүлж байна.

Хуулийн зорилго нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн. Хуульд *“хүн худалдаалах”* гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ гэж тодорхойлсон нь Палермогийн протоколын агуулгатай нийцэж байгаа юм.

Дээрх хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль бусад хууль тогтоомж нь Монгол Улс эрүүгийн эрх зүйн орчныг шинэчлэх явцдаа ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын агуулгатай нийцүүлэн уялдуулсан болохыг судалгааны тайлангуудад<sup>10</sup> дурдсан байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгасан. Үүнээс гол онцлог зохицуулалт нь Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл ажиллахаар зохицуулж, дэд зөвлөлийн хэрэгжүүлэх эрх хэмжээг зааж өгсөн явдал юм.

Мөн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийн нэр төр, алдар хүнд, аюулгүй байдлыг хангах, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар тусгаснаас гадна ХХГХ-ийн талаар мэдээлэл өгсөн хүнийг хамгаалах асуудлыг орхигдуулаагүй нь сайшаалтай байна.

Тус хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй гол ажил нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр юм. Үндэсний хөтөлбөр нь “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх,

---

<sup>10</sup> ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан, 2017

тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага (ТББ), олон улсын байгууллага (ОУБ)-ын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдэж байна.

Өнөөдрийн байдлаар ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж буй, уялдаж буй үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэн авч үзвэл:

#### Хүснэгт 5. Үндэсний эрх зүйн баримт бичгүүд

Гол эрх зүйн баримт бичгүүд:	Бусад эрх зүйн баримт бичгүүд:
<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</li> <li>- Эрүүгийн хууль</li> <li>- Зөрчлийн тухай хууль</li> <li>- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль</li> <li>- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль</li> <li>- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</li> <li>- Хүүхдийн эрхийн тухай хууль</li> <li>- Хүүхэд хамгааллын тухай хууль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Донорын тухай хууль</li> <li>- Зар сурталчилгааны тухай хууль</li> <li>- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль</li> <li>- Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль</li> <li>- Хөдөлмөрийн тухай хууль</li> <li>- Эрүүл мэндийн тухай хууль</li> <li>- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль</li> <li>- Боловсролын тухай хууль</li> <li>- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн тухай хууль</li> <li>- Прокурорын байгууллагын тухай хууль</li> <li>- Цагдаагийн албаны тухай хууль</li> <li>- Тагнуулын байгууллагын тухай хууль</li> <li>- Авлигын эсрэг хууль</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль</li> </ul>	
<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Хилийн тухай хууль</li> <li>- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль</li> <li>- Гаалийн тухай хууль</li> <li>- Улсын бүртгэлийн ерөнхий хууль</li> <li>- Төрийн хяналт шалгалтын тухай хууль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал</li> <li>- Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөр</li> <li>- Гэрч, хохирогчийг хамгаалах, тусалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр</li> </ul>

Дээрх хууль, эрх зүйн баримт бичгүүдтэй танилцахад ХХГХ-тэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд гарсан ахиц дэвшилттэй заалтууд болон цаашид анхаарах, тодорхой болгох шаардлагатай асуудлууд ажиглагдсаныг дор нэгтгэлээ.

Судалгааны үр дүнгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй одоогийн хууль тогтоомжийн хүрээнд эерэг ахиц дэвшилттэй заалтууд нь:

- Шинэчлэн найруулсан Донорын тухай хууль хэрэгжсэнээр донор болох зөвшөөрлийг нас барахын өмнө өөрөөс нь, нас барсны дараа гэр бүлийн гишүүн, төрсөн эцэг, эх, харгалзан дэмжигчээс нь тус тус авах, донорын зар сурталчилгаа болон зуучлалыг хориглох заалт оруулснаар хүний эд эрхтний наймаанаас сэргийлэх нөхцөл бүрдсэн гэж судлаачид дүгнэж байна. Донорын тухай хуулийн 12 дугаар зүйлд “Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө **ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын** байна. Донорын үйл ажиллагааг ашиг орлогын эх үүсвэр болгох, тулган шаардах, худалдахыг хориглоно” хэмээн заасан.

Донор нь сэтгэцийн хувьд эрүүл, **25 насанд хүрсэн, эс, эд, эрхтнээ өгөх тухай зөвшөөрлөө бичгээр гаргасан байх бөгөөд хүүхдээс ясны хэм, чөмөг, хүйн цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн бичгээр гаргасан зөвшөөрлийг урьдчилан авч донорын амь насанд аюул учруулахгүйгээр эмнэлгийн нөхцөлд эс, эд, эрхтнийг авахаар зохицуулсан.**<sup>11</sup>

<sup>11</sup> Донорын тухай хууль, 2018

Шилжүүлэн суулгах эс, эд, эрхтнийг амьгүй донороос авах бөгөөд хэрэв амьд донороос авах бол эс, эдийн тохироо нь нийцсэн, эмгэг өөрчлөлтгүй, гэр бүлийн гишүүнээс авахаар хуульчилсан нь хүний эд эрхтнийг худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх баталгаа болжээ. Мөн хүүхдээс ясны хэм, үүдэл эс, чөмөг, хүйн цуснаас бусад эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглосон нь хүүхдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах онцлог бүхий зохицуулалт болсон байна.

- Монгол Улсад 2018 оныг хүртэл тээгч эхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байгаагүй бөгөөд шинэчлэн найруулсан Донорын тухай хуульд “эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйг тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрнө” хэмээсэн нь тээгч эхтэй холбоотой хүүхэд худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх бас нэг үндэс болсон байна.
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар заасан. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан гэмт хэргийн улмаас амьг наснаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай байна. Хуулийн энэхүү заалтад Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөг, 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах, 15.3 дугаар зүйлд заасан хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.6 дугаар зүйлд заасан хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогчийг хамааруулсан нь дэвшилттэй зохицуулалт болсон байна.
- Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд “Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан, биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан үйлдлийг биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд тухайлан нэмэлтээр оруулсан нь зохион байгуулалттайгаар, бусдаар биеийг нь үнэлүүлэх явдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ болсон байна. Мөн биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, өөрөөр хэлбэл 18 насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар тайлбарласан байна.
- 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулиар 16 насанд хүрсэн хүн ажил олгогчтой шууд хөдөлмөрийн гэрээ байгуулж хөдөлмөр эрхлэх боломжтой байхаар зохицуулсан. Харин “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д орсноос бусад ажлын байранд 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. Өөрөөр хэлбэл 15-аас доош насны хүнтэй хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсгэх боломжийг хуулиар хязгаарласан байна.
- Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.8 дахь хэсэгт “бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ”-ний төлбөрийг төр хариуцахаар зохицуулсан байна. Энэ зохицуулалт нь бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн улмаас хохирсон иргэний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн, шуурхай хүргэхэд чиглэсэн зохицуулалт болсон байна.

Судалгааны хүрээнд авч үзсэн холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд зөрчилтэй болон шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудлууд нь:

- Эрүүгийн хуулийн 12.3-д Бэлгийн мөлжлөг, 12.6-д Биеэ үнэлэхийг зохион байгуулах, 13.13-д Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.4-д Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6-д Хүүхэд худалдах, 16.8-д Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9-д Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10-д Хүүхдээр тэвчишгүй



хөдөлмөр эрхлүүлэх явдлыг тусад нь бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан. Гэвч эдгээр зүйлчлэлийн агуулга нь Эрүүгийн хуулийн 13.1 Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон ХХГХ-ийн үйлдлийн шинжтэй давхцаж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдал үүсгэх эрсдэлтэй байна. Уг үр дүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 2.3-р бүлэг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлалаа.

- 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан боловч албадан хөдөлмөр гэдгийг *“хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг”* хэлнэ гэж тайлбарласан байна. Гэтэл үүнд илүү цаг, баяр ёслолын өдрүүдэд ажиллах зохицуулалтыг зөрчин ажиллуулах (хөлс бодолт, хязгаарлалт, хориглолтыг зөрчих), цалин хөлсгүй ажиллуулах, хөдөлмөрийн үр дүн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгох, хэд хэдэн ажил гүйцэтгүүлээд нэг ажлын хөлс олгох зэргийг хамруулаагүй нь учир дутагдалтай байна.

Эдгээр үр дүнгээс үзвэл Монгол Улсад ХХГХ, түүн дотроо хүүхдийн эсрэг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах чиглэлд эрх зүйн орчин сайжирч байгаа нь харагдаж байна. Гэвч хууль эрх зүйн баримт бичгүүдэд тодорхой зохицуулагдаагүй, эргэлзээтэй зохицуулалтууд мөн байгаа нь цаашид хуулийг нэг мөр ойлгох асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт зохицуулалт оруулах хэрэгцээ шаардлага бийг харуулж байна.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгааны баг хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны нөхцөл байдлыг авч үзэхдээ 4P-ийн парадигмыг баримталж тайланг боловсрууллаа.

## 2.1 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн гол үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад төвлөрч байгаа бөгөөд энэ чиглэлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ их байгааг тогтолцооны оролцогч талууд бүгд онцлон дурдаж байв.

Өнөөгийн түвшинд хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд тогтолцооны оролцогч байгууллагуудын авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэвэл урьдчилан сэргийлэх ажлын дийлэнх нь **төрийн албан хаагчид уруу чиглэсэн сургалт, олон нийт рүү чиглэсэн сурталчилгаа** хэлбэрээр хэрэгжиж байна. Талуудын оролцоог авч үзвэл, энэ чиглэлд төр, төрийн бус, ОУБ-уудын оролцоо харилцан ижил түвшинд байгаа боловч авч хэрэгжүүлж буй **үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоо дутмаг, нэгдсэн удирдлага зохион байгуулалтгүй, хоорондын хамтын ажиллагаа хангалттай түвшинд явагдаж чадахгүй** байгаагаас энэ төрлийн ажил нь ихэвчлэн тухайн төсөл, хөтөлбөрийн төсөв, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран хязгаарлагдмал хүрээнд, өргөн далайцтай, тогтмол давтамжтай, үе шаттай явагдаж чадахгүй байгааг холбогдох төр, төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагын мэргэжилтнүүд дурдаж байна.

Мөн талуудын онцолж буй өөр нэг чухал үр дүн нь **урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд үнэлгээ хийх, хэмжих ажил хэрэгждэггүй** энэ төрлийн ажлыг хэдэн хүнд, хэчнээн удаагийн сургалт зохион байгуулсан эсэх явцын тоон шалгуураар хэмжихэд хүрч буй нь эцсийн үр дүнг үнэлж, туршлага сургажээ эргэн дүгнэж чадахгүй байх дутагдалтай байна.

Тайлангийн энэ хэсэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтолцооны оролцогч талуудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг талуудаар ангилж, тэдгээр талууд тус бүрд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудлуудыг тодорхойллоо.

### 2.1.1. Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд тодорхойлогдож байна. 2020 онд гүйцэтгэсэн Үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний тайланд хөтөлбөрийн “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” 1-р зорилтын биелэлтийг **84.5%-тай буюу тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэжээ.<sup>12</sup> Урьдчилан сэргийлэх ажилтай холбоотой тус зорилт нь нийт 9 дэд зорилт, 35 нэгж хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас бүрдэж байгаагийн хамгийн ахиц гаргасан зорилт нь “хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр төлөвлөсөн ажлууд (95%) бол хамгийн бага гүйцэтгэлтэй нь ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд тогтмол мониторинг хийж үнэлгээ өгөх (0%) ажил байна (Зураг 8).

Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн үр дүнг хэмжих хяналт шинжилгээ үнэлгээний ажлууд хийгддэггүйгээс энэ чиглэлээрх ажлын үр дүнг бодитой тооцоход хүндрэл тулгардаг болохыг оролцогч

<sup>12</sup> Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны тайлан, Эс Ай Си Эй ХХК, 2020

талууд мөн ярилцлагадаа дурдаж байсан нь урьдчилан сэргийлэх ажлууд нь нэгдсэн удирдлага, нэг бодлогын хүрээнд зохион байгуулагдаж чадахгүй байгааг харуулж байна.

Зураг 8. Үндэсний хөтөлбөрийн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилт, хөтөлбөрийн дунд шатны үнэлгээний дүн, 2019



Эх сурвалж: ХХГХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний тайлан, 21-р тал, "Эс Ай Си Эй" ХХК, 2019

Дээрх үр дүнг харгалзвал хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх төрийн үйл ажиллагааны хэрэгжилт тодорхой ахицтай байгаа боловч, бусад оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үр дүнг харгалзвал талууд урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаагаа нэгтгэх, хамтрах байдал харилцан адилгүй, зарим байгууллагын хувьд төсөв санхүү хангалтгүй улмаас үйл ажиллагаа хязгаарлагдмал, идэвх, оролцоо хамтын ажиллагаа сул байна.

Тус судалгааны хүрээнд Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр үүрэг хүлээсэн 14 байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Эдгээр байгууллагуудын урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн авч үзэхэд Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хамтран ажиллах (ХЗДХЯ-ГХУСАЗЗАА), хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх (ХНХЯ), хохирогчийг олж тогтоох, хохирогчид тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх (ГХЯ, Консулын газар), хамтарсан тушаал гаргах хэрэгжүүлэх (БШУЯ, ГБХЗХГ), мэдээлэл солилцох, тоон мэдээ баримтыг гаргах (ГИХГ), төрийн алба хаагчдад зориулж сургалт зохион байгуулах, хяналт шалгалт хийх (МХЕГ), хүүхэд олон нийтэд хууль эрх зүйн мэдлэг олгох (БШУЯ), журам баталж хэрэгжүүлэх (ХХЕГ), мэргэжлийн удирдлагаар хангах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургагч багш бэлтгэх (ГБХЗХГ) зэрэг ажлуудыг зохион байгуулжээ. Энэ талаар дэлгэрүүлж Хавсралт 4-өөс үзнэ үү.

Хэдийгээр Үндэсний хөтөлбөрт төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон ч тэдгээрийн хэрэгжилтийг хангахад асуудал хариуцсан байгууллагаас бусад төрийн байгууллагуудын оролцоо, анхаарлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд урьдчилан сэргийлэх ажлуудыг уялдуулах чиглэлээр баталсан хуулийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн нэг бодлого, чиглэл, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулах, хяналт үнэлгээг тогтмолжуулж, үр ашигтай хамтран ажиллах байдлыг сайжруулах нь нэн чухал байна.

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын мэргэжилтнүүдийн өгсөн мэдээллээс үзэхэд төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгал сул, төрийн байгууллагуудын дунд ч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн чиглэлээр нэгдсэн мэдээлэл байдаггүй, ихэвчлэн мэдээллүүд нь зөрүүтэй байдгийг онцолсон байна. Мөн тухайн төрийн байгууллага дотооддоо л мэдээллийг ашиглахаас ажил үүргийн шугамаар чиглэл чиглэлээрээ мэдээллээ нууж хаах, мэдээллийн урсгал болон ил тод байдалтай холбоотой асуудал бийг төрийн албан хаагчид мөн ярилцлагадаа дурдаж байв.

**Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх асуудал:** Урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн байгууллагын авч хэрэгжүүлэх гол ажлуудын нэг нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх асуудал. Энэ хүрээнд төслийн суурь шалгуур үзүүлэлтийн дагуу Монгол Улсын агаарын болон газрын 40 хилийн боомт буюу шалган нэвтрүүлэх цэгүүдээр насанд хүрээгүй хүнийг хэрхэн нэвтрүүлдэг, сэжиг бүхий тохиолдол ажиглагдвал хэрхэн ажилладгийг тодруулсан.

Хилийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”<sup>13</sup>-ыг баримтлан ажиллаж байна. 2017-оос 2021 оны хагас жилийн байдлаар нийт Монгол Улсын хилээр нийт 396,449 хүүхэд нэвтэрсний ойролцоогоор 1.6% нь буцаж ирээгүй, хилийн чандад үлдсэн байна. Эдгээр хилээр нэвтэрсэн хүүхдүүд уг журмын 2.1, 2.2 дахь заалтуудад дурдсан шаардлагыг бичиг баримтаар нотолсон буюу, үүнд:

- Өөрийн төрсөн эцэг эхтэйгээ хамт зорчсон
- Эсхүл төрсөн эцэг, эх хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлтэй этгээдтэй зорчсон. Хэрвээ эцэг эх нь гадаадад байгаа бол Гадаад харилцааны яамаар дамжуулсан ирүүлсэн итгэмжлэлтэй байна.
- Олон улсын уралдаан, тэмцээн, урлаг соёлын бусад арга хэмжээнд оролцохоор зорчиж байгаа бол ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын /нэгжийн/ зөвшөөрөлтэй байх зэрэг шаардлагыг хангасан тул хилээр нэвтрүүлсэн.

Ихэнх тохиолдолд эдгээр хүүхдүүд нь гадаад улс оронд суралцах, эцэг эх, асран хамгаалагч дээрээ очих, зорилгоор гадаад улсад үлддэг талаар холбогдох албаны төлөөлөл ярилцлагадаа дурдсан. Энэ тохиолдолд Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын дагуу гадаад улсад байгаа эцэг эх болон бусад хүлээн авсан хүний баримт бичгийн хуулбар, хүүхдийг хүлээн авсан тэмдэглэл, хаяг, холбоо барих утасны дугаар цахим шуудангийн хаягийн мэдээлэл зэргийг авчрах шаардлагыг холбогдох этгээдэд тавьдаг байна.

#### Шигтгээ 1

....Хүүхэд үлдээсэн тохиолдолд хаана, хэнд үлдээсэн гэдгийг маягтын дагуу бөглүүлнэ. Энэ журам дээр орсон бүх зүйлийг шалгах зорилгоор бид бөглөх бланк бэлдсэн байдаг бөгөөд үүн дээрээ бичүүлж авдаг. Үлдээсэн хүний баримт бичгийн хуулбар, тэмдэглэл, хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн мэдээллийг бөглүүлж авна. Жишээлбэл, Эрээнд Монгол хүүхдүүд их сурдаг. Энэ тохиолдолд сургуулиас нь бичиг хийлгээд ирдэг. Энэ хүүхэд нь манай сургуулийн хх-р ангид сурдаг, ххх багшийн хариуцсан ангид сурдаг нь үнэн гэсэн бичиг авдаг.

Хил хамгаалах байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

<sup>13</sup> 2017 оны Хууль зүйн сайдын тушаал А/49, Хүүхдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам

Харин сүүлийн 4 жилийн хугацаанд Монгол Улсын хилээр нэвтрүүлээгүй гэх 483 хүүхдүүд нь тус журмын дагуу бичиг баримтын зөрчилтэй тул хилээр нэвтрүүлээгүй байна.

Зураг 9. Монгол Улсын хилээр 2017-2019 онд нэвтэрсэн хүүхдийн тоо



Эх сурвалж: ХХЕГ, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн суурь судалгааны хүрээнд гаргаж өгөв

ХХЕГ-аас авсан мэдээллээр одоогийн байдлаар хилийн хяналт, шалгалтаар ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй сэжигтэй болон хохирогчоор илэрсэн тохиолдолд цааш холбогдох байгууллагад холбон зуучилсан тоо баримт албан ёсоор бүртгэгдээгүй байна. (Шигтгээ 2).

#### Шигтгээ 2

... Хилийн боомт дээр ажиллаж байгаа албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны чиг үүрэгт нарийн хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгаж өгсөн юм байхгүй. Хууль зүйн сайдын А/49 тушаал Хүүхдийг Монгол улсын хилээр шалган нэвтрүүлэх журмыг л хэрэгжүүлж ажилладаг. Эцэг эхтэйгээ явж байвал эцэг эх нь мөн эсэх, хамаатантайгаа явж байвал цагдаагийн бичиг тодорхойлолтод дээр үндэслэлд хилээр нэвтрүүлдэг. Тухайн иргэн гадаадад хүүхдээ авч гарчхаад буцаад хүүхэдгүй орж ирвэл манай бүртгэлийн программ дээр байдаг учраас тухайн хүнээс тодруулдаг. Шаардлагатай тохиолдолд цагдаагийн газар болон тагнуулын байгууллагад шилжүүлж өгнө. Тус журам дээр гадаад зорчих хүүхдийн нотлох баримт бичгүүдийг хуурамчаар бүрдүүлсэн болон бусад үндэслэлээр хил дамжуулан худалдагдаж болзошгүй сэжиг илэрвэл цагдаагийн байгууллагаар шалгуулахаар шилжүүлнэ гэж заасан байдаг. Боомтоор гарах, орох чиглэлд сэжигтэй тохиолдол илэрвэл, хүүхэд нь сэжиг бүхий байна гэж үзвэл шууд цагдаагийн байгууллагад хандаж шилжүүлэх үүрэгтэй. Гэхдээ ийм тохиолдол ер нь гараагүй, гарч байгаагүй. Сургуульд сурдаг тохиолдолд тэнд сурдаг нь үнэн гэсэн тодорхойлолт авдаг. Эсвэл тухайн сургуулиас энэ хүүхэд сурдаг нь үнэн үү гэсэн лавлагаа авдаг. Ингэж л хяналт тавьж ажилладаг.

Хил хамгаалах байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Түүнчлэн хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр ажиллаж буй албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны чиг үүрэгт ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүргийг тусгасан заалт байдаггүй болох нь дээр ярилцлагаас харагдаж байна. Хил хамгаалах албаны албан хаагчдад ХХГХ-тэй тэмцэх талаар сургалт ордог хэдий ч бодит байдалд төдийлөн энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал үүсдэггүй гэдгийг ганцаарчилсан ярилцлагын үеэр мөн дурдаж байсан. Хэрвээ энэ төрлийн сэжигтэй тохиолдол илэрвэл цагдаагийн байгууллагад дамжуулах үүргийг хүлээдэг баг ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, эрт илрүүлэх, цааш холбогдох байгууллагад холбон зуучлах чиглэлээрх зохицуулалт зөвхөн хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмаар хязгаарлагдаж байна.

## 2.1.2 Олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Судалгаанд нийт таван ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ОУБ-уудын төлөөлөлтэй уулзаж ярилцлага хийсэн. Тэдгээр байгууллагуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нэгтгэн авч үзвэл бэлгийн мөлжлөг, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ОУШХБ, Азийн сан, албадан хөдөлмөр, хөдөлмөр мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ОУХБ зэрэг байгууллагууд зонхилон уг асуудлаар санхүүжилт олгох замаар ТББ-ын үйл ажиллагааг дэмжих, чадавхжуулах, тусгайлсан төсөл хөтөлбөрүүд бие даан хэрэгжүүлэх, судалгааны ажлууд хэрэгжүүлэх замаар бодлогын уялдаа холбоог хангах, эрх зүйн орчныг сайжруулах, бодлогод суурилсан хөтөлбөр боловсруулах чиглэлд анхаарал хандуулан ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд ОУБ-ын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар Хавсралт 5-аас дэлгэрүүлж үзнэ үү.

ОУБ-уудын зүгээс одоогийн хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд бусад оролцогч талуудтай (төр, төрийн бус байгууллагууд) хамтран ажиллах, хамтын ажиллагааны үр ашигтай байдлыг хангахад идэвхтэй анхаарч ажиллаж байна. Гэвч ТББ-ын зүгээс ОУБ-ууд нь төсөл хөтөлбөрөө өөрсдөө хэрэгжүүлэгч болж байгаа нь үндэсний ТББ-ыг чадавхжуулах гэхээсээ илүү нэг ижил түвшний хэрэгжүүлэгч субъект болж, хамтын ажиллагаа нь зөвхөн хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгөх хэмжээнд явагдаж байгаад шүүмжлэлтэй хандах байр суурь илэрхийлж байв (Шигтгээ 3) .

### Шигтгээ 3

*...Ерөнхийдөө манай улсад ганц дутагдалтай тал байгаа нь сүүлийн үед ОУ-ын донор байгууллага өөрсдөө хэрэгжүүлэгч болсон. Анх ТББ-ууд эрчимтэй сайн явж байсан шалтгаан нь НҮБ-ийн хүүхдийн сан, Английн хүүхдийг ивээх сан, Японы хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн зэрэг ОУБ-ууд ТББ-тайгаа санамж бичиг байгуулаад, ТББ-ыг чадавхжуулах, ТББ-уудад түшиглэсэн хамтын ажиллагаа их өргөн явдаг байсан. Гэтэл 2010 оноос хойш, сүүлийн 11 жилд олон улсын байгууллагуудын цар хүрээ багассанаар ОУБ-ууд өөрсдөө төсөл бичиж, санхүүжилтээ босгодог хэлбэр рүү орсон. Гэтэл олон жил энэ салбарт ажилласан ТББ-уудын туршлагыг нэг судалгаанд хамруулах, ярилцлага авах, эсвэл хэрэгжүүлсэн төслийн хаалт дээр урих, суудал бөглөх хэмжээнд болж байна. Сүүлийн үеийн хамтын ажиллагаа ийм болсон.*

Олон улсын байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

ОУБ-ууд сүүлийн 2 жилийн хугацаанд COVID-19 цар тахлын дэгдэлт, түүнээс үүдсэн нийтийн хөл хорионоос шалтгаалан урьдчилан сэргийлэх ажлуудыг цахимаар дагнан зохион байгуулах хэлбэр рүү шилжсэн байна. Тухайлбал, Гүүд Нейборс ОУТББ бүх нийтийн хөл хорионы үед цахимаар хүүхдүүдэд зориулсан жүжигчилсэн тоглолт, хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлын талаар цахим видео хичээлүүд бэлтгэн телевиз, сошиал медиа (Facebook) зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр олон давтамжтай нэвтрүүлэх, түгээх ажлыг зохион байгуулжээ (Зураг 10).





Эх сурвалж: Гүүд Нэйборс ОУТББ-ын албан ёсны Facebook хуудаснаас

Олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, кампанит аян зохион байгуулахдаа энэ төрлийн гэмт хэргийн тодорхойлолт, түүнээс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хаана хэрхэн хандаж туслалцаа авах зэрэг үндсэн агуулгыг хүргэхийг нийтлэг зорьж ажиллаж байна. ОУБ-ын төлөөлүүд урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлууд хэрэгжүүлсэн туршлагадаа үндэслэн ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголт нийтээрээ муу байгааг онцолж байсан. Тодруулбал, ХХГХ гэдэгт хүүхдүүдийг хуурч мэхлэн, эсвэл хулгайлан хил дамнуулан худалдах гэдэг ерөнхий ойлголт түгээмэл бөгөөд хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртүүлэх зорилгоор хуурч мэхлэх зэрэг нийтлэг тохиолдож буй үйлдлүүдийг ХХГХ гэж авч үздэггүй гэж дүгнэсэн нь уг судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үр дүнг давхар нотолж байлаа. Ярилцлагад хамрагдсан ОУБ-ын төлөөллийн хувьд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг цаашид зохион байгуулахдаа гэмт хэргийн төрлүүд, түүний илэрч болох хэлбэрүүдийг бодитой кейс жишээнд тулгуурлан хүргэх, ингэхдээ нэг удаагийн сурталчилгаанаас илүү олон нийтийн хандлага, зан үйлд нөлөөлөхийн тулд тодорхой давтамжтай зохион байгуулах нь үр дүнтэй гэсэн байр суурийг илэрхийлж байв.

#### Шигтгээ 4

...Энэ чиглэлийн мэдээллийг тогтмол хүргэх хэрэгтэй ба хүмүүс олон дахин сонсоод ирэхээрээ мэдлэг мэдээлэл илүү сайжирдаг. Тэгэхээр аль болох тогтмол давтамжтай хүргэх хэрэгтэй. Мөн ямар насны хүнд ямар төрлийн ойлголтыг өгөх гэж байгаагаас шалтгаалаад тухайн хүнийхээ нас, сэтгэхүйн онцлогт таарсан байдлаар хүргэх шаардлагатай. Магадгүй, бид нар хүүхдүүдтэй ярилцахаар өсвөр насны хүүхдүүд яг юу яриад байгааг ойлгохгүй байж болно. Иймд яг энэ насны хүүхдүүдэд тухайн болсон кейсийг маш нууцлалтайгаар, овог нэр гэх мэт бүх зүйлийг нь нууцалж байгаад бодит жишээнүүд, кейсүүдийг танилцуулах нь зүйтэй. Үүний хамт кейс дээр тулгуурлаж байгаад ямар мэдээллийг ямар хүнд хүргэх гэж байгаагаа илүү сайн төлөвлөж байгаад олон нийт рүү мэдээллээ цацах юм бол энэ чиглэлийн ойлголт түгэх болно.

Олон улсын байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Мөн одоогийн ХХГХ-ийг таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллүүдийг бэлтгэх, тархаахдаа иргэдийн нас, хүйс, бүлгийн онцлог, тусгай хэрэгцээ зэргийг харгалзах байдал хангалтгүй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэр дундаа сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд бэрхшээлийнхээ онцлогоос шалтгаалан бүх төрлийн мэдээ мэдээллээс хоцрох эрсдэл өндөр, улмаар

мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан гэмт хэргийн хохирогч болох, хохирсон ч тусламж дэмжлэг авч чадахгүй байх тохиолдлууд гардаг. Тухайлбал, 2020 онд ХЗДХЯ, АХБ-аас гүйцэтгэсэн судалгаа<sup>14</sup>-ны үр дүнгээр сонсголын бэрхшээлтэй иргэдийн ойлголт мэдлэг бусад төрлийн бэрхшээлтэй иргэдээс даруй 2 дахин бага байгаа үр дүн гарсан. Уг тайланд дурдсанаар сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, харилцааны сувгийг зөвхөн дохионы хэлээр хязгаарлах нь учир дутагдалтай бөгөөд телевизийн сувгийн дохионы хэлмэрчийн дүрс тайлбарын хэмжээг томруулахаас гадна, цөөн энгийн үг хэллэг, текст ашигласан видео контент бэлтгэх, мөн ижил бэрхшээлтэй хүмүүсийн дунд сургагч багш нарыг бэлтгэх зэрэг олон нийтэд түшиглэсэн аргууд илүү үр дүнтэй талаар зөвлөмждөө дурдсан байна.

### 2.1.3. Төрийн бус байгууллагын хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээрх ихэнх ИНБ-ууд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хариу үйлчилгээг үзүүлж байна. Судалгаанд хамрагдсан 10 гаруй ИНБ-уудын хувьд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээлэл түгээх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг хийж, хэрэгжүүлж байгаа боловч үйл ажиллагаа нь байгууллагын онцлог, хамрах хүрээ, чадавхаас хамаарч тодорхой нэг төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна.

Тухайн чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй ТББ-уудын хувьд эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг илрүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэдээлэл түгээх, холбон зуучлах, хамтрах, сургалт зохион байгуулах (Тухайлбал, Анбаунд Монгол ТББ), үндэсний арга хэмжээ, аян зохион байгуулах, брошюр, гарын авлага боловсруулж, түгээх (Тухайлбал, ХЭҮТ), сургалт хөтөлбөр хэрэгжүүлэх, кампанит ажил зохион байгуулах, төрийн байгууллагын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, баримтат кино нэвтрүүлэг бэлтгэх (Тухайлбал, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ ТББ г.м), анимейшн хийх, гар утасны аппликэйшн хөгжүүлэх, үндэсний хэмжээнд сургалт зохион байгуулах (Тухайлбал, Хөөрхөн зүрхнүүднүүдийн аян ТББ), олон улсын туршлага судлах, видео контент бэлтгэх (Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ ТББ) зэрэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлж иржээ. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-оос үзнэ үү.

Эдгээр байгууллагуудаас ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд Анбаунд Монгол ТББ нь илүү олон нийт рүү чиглэсэн сургалт, сурталчилгаа, олон нийтийн нөлөөллийн ажлуудыг идэвхтэй зохион байгуулдаг. Тус байгууллагын 2018 оноос хойш хэрэгжүүлж буй “Дамжин өнгөрөх ажиглалт” төсөл нь урьдчилан сэргийлэх чиглэлээр ИНБ-ын хэрэгжүүлж буй ажлаас онцлох үр дүнтэй бөгөөд сайн туршлага бүхий үйл ажиллагаа байв. Тус төсөл нь ХХГХ-т өртөж болзошгүй охид, эмэгтэйчүүдийг хилээр дамжин өнгөрөхөөс өмнө олж тогтоон, урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилго бүхий төслийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтод хэрэгжүүлж, 16-40 насны нийт 3,601 охид, эмэгтэйчүүдээс асуулга судалгаа авч, ХХГХ-т өртөх эрсдэлтэй 205 эмэгтэйг тогтоон, 38 охид, эмэгтэйчүүдэд ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах талаар зөвлөгөө өгснөөс 24 эмэгтэй гадаад улс руу гарахаас татгалзсан тул гэр бүлд нь аюулгүй буцаасан.

Тус үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх чиглэлээр зонхилон хэрэгжиж буй сургалт, сурталчилгааны ажлаас илүү эрсдэлт бүлгийн хүн ам уруу шууд чиглэсэн үйл ажиллагаа, мөн төслийн үр дүнд эрсдэл бүхий төчнөөн тооны эмэгтэйчүүдийг илрүүлэн, зөвлөгөө мэдээлэл өгч, гэр бүлд нь аюулгүй буцаасан үр дүнтэй байгаагаараа ТББ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудаас ихээхэн онцлог, сайн туршлага бүхий ажил болсон байна.


---

<sup>14</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгааны тайлан, ХЗДХЯ, АХБ, IRIM, 2020

ТББ-уудын хувьд тодорхой хугацааны төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж байгаа хэдий ч эдгээр байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн арга барилыг харгалзвал илүү олон талын туршлагыг хуримтлуулж чадсан байгаа тул амжилттай сайн хэрэгжсэн төсөл хөтөлбөрийг давтан хэрэгжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах замаар тогтвортой байдлыг хангахад анхаарах хэрэгтэй.

Тус бүлгийн үр дүнг нэгтгэн урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, ТББ болон ОУБ-дад тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг нэгтгэн авч үзвэл:

**Зураг 11. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудад тулгамдаж буй хүндрэл бэрхшээл**



## 2.2. Хохирогч хамгаалал

Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн мэдээлснээр ХХГХ-ээр сүүлийн гурван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн статистикийг харахад нийт 38 хэрэгт 131 хохирогч тогтоогдсоны 35% нь насанд хүрээгүй 14-18 насны хохирогч байна.<sup>15</sup> Гэмт хэргийн хохирогч болсон эдгээр хүүхдүүдийг төр хамгаалалдаа авах, тусламж дэмжлэг үзүүлэх хууль эрх зүйн орчин хэр бүрдсэн, үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлыг уг бүлэгт тодруулахыг зорилоо.

### 2.2.1 ХХГХ-ийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин

Монгол Улс нь Хүүхдийн эрхийн конвенцыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн орнуудын нэг.<sup>16</sup> Гэвч одоогийн байдлаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль нь Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах тухай конвенц болон үндэсний хууль тогтоомж болох Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуультай хэр нийцтэй эсэхийг нарийвчлан судалсан ажил хийгдээгүй байна.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр 2015 онд шинэчилсэн Эрүүгийн хуульд<sup>17</sup> хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн

<sup>15</sup> Суурь судалгааны хэрэгцээ шаардлага IRIM, 2021 он

<sup>16</sup> Монгол улс нь 1990 оны 1-р сарын 26нд гарын үсэг зурж, 1990 оны 07-р сарын 05-д соёрхон баталсан.

<sup>17</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2016 он, Дугаар 07

хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд<sup>18</sup> хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг тус тус хуульчилсан. Эрх зүйн шинэчлэлийн дүнд хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулийн хүрээнд баталгаажуулснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон улс болсон.<sup>19</sup> Гэтэл эдгээр хууль тогтоомжид ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдийг хэрхэн илрүүлэх, хамгаалах, хүүхэд хамгааллын хариуг үйлчилгээг яаж үзүүлэх талаарх тусгайлсан зохицуулалт хангалтгүй байлаа.

2012 онд батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд<sup>20</sup> хохирогчийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрийг хуульчилсан байдаг. Хуулийн 12-р зүйлд зааснаар Монгол Улсад хохирогчид дараах таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр тусгажээ. Үүнд:

12.1.1	12.1.2	12.1.3	12.1.4	12.1.5
Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ	Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ	Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах	Хууль зүйн туслалцаа	Гадаад улсад Монгол Улсын консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах

Эдгээр үйлчилгээг үзүүлэхэд тусгайлсан журам гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих үүргийг төрийн захиргааны төв байгууллагуудад хүлээлгэсэн байна.

1. Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээтэй холбоотой журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх үүрэгтэй<sup>21</sup>. Харин энэ журам<sup>22</sup> нь Гэрч хохирогчийг хамгаалах хуулийн хүрээнд батлагдан гарсан ба энэ нь ХХГХ-ийн хохирогчдод мөн адил үйлчлэх зохицуулалтай байна.
2. Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээний журмыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн<sup>23</sup> ба тус журам нь 2015 онд батлагджээ<sup>24</sup>. Энэ журмын хүрээнд хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, хүсэлт гаргасан хүнд төрийн байгууллагын зүгээс хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгажээ. Хохирогчийн гаргасан хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий газар нь Хүн худалдаалахтай тэмцэх Дэд зөвлөл байна.
3. Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам<sup>25</sup>-ыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргах үүрэг хүлээсэн. Мөн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам<sup>26</sup>-

<sup>18</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 он, Дугаар 05

<sup>19</sup> Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, хуудас 1.

<sup>20</sup> Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2012 он, Дугаар 07

<sup>21</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэг

<sup>22</sup> Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх" журмыг баталсан байна.

<sup>23</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг

<sup>24</sup> Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх" журмыг баталсан байна.

<sup>25</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг

<sup>26</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дэх хэсэг

ыг Улсын ерөнхий прокурортой хамтран Хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах бөгөөд тус журам өнөөг хүртэл батлагдаагүй байна.

4. Гадаад улсад Монгол Улсын Консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэх<sup>27</sup> бөгөөд тус журмыг 2013 онд батлан гаргажээ<sup>28</sup>. Журмын хэрэгжилтийг хангах санхүүжилтийн эх үүсвэр нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн төрөл болох Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас<sup>29</sup> гаргах зохицуулалттай байна. Тайлангийн хүрээнд ганцаарчилсан ярилцлагын явцад эх нутагт нь хохирогчийг эргүүлэн авчрах үйлчилгээг олон улсын байгуулалгаас НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас Хүйсийн тэгш эрх төв нь холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хохирогчдийг аюулгүйгээр эх нутагт нь авчирдаг байна.

#### Шигтгээ 5

*ОУШХБ нь 2010 оноос хойш 8000 орчин иргэн эх нутагтаа авчирсан. Үүнээс 3/1 нь хүүхдүүд эзэлдэг. 2010 оноос өмнө хүүхэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж байгаагүй. Харин 2010 оноос хойш хохирогчоор илэрч эхэлсэн. 2018 оны зун Турк улсад хөдөлмөр мөлжлөгт өртсөн монгол ээжийг 17 настай хүүхдийн хамт авчирсан. Хүүхэд нь хөдөлмөр мөлжлөгт давхар өртсөн. ОУШХБ нь хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг эх оронд нь авчрах, буцаах ажлыг тогтмол хийдэг. Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэг өртсөн Украин улсын иргэн нэг, Филиппин улсын иргэн нэг, Мьянмар улсын 3 иргэнг эх нутаг руу нь буцааж байсан. Эдгээр хүмүүсийг эх нутагтаа очоод эргэн суурьшихад нь туслах хөтөлбөрт хамруулдаг. Хохирогчийг эргүүлэн авчрах, буцаахтай холбоотой зардлыг цэвэр ОУШХБ-р дамжуулан Засгийн газарт өгдөг.*

Олон улсын байгууллагын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан хохирогчдод үзүүлэх үйлчилгээтэй холбоотой журмуудад хүүхдэд үзүүлэх үйлчилгээний зохицуулалт мөн адил байхгүй байлаа. Иймд хуулийг даган гарсан журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар нэмэлт, өөрчлөлт оруулах, улмаар хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний тусгайлсан зохицуулалтыг тусгах шаардлага бий болсон байна.

**2013 онд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнд тавигдах наад захын жишиг стандартыг батлан гаргажээ.** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг боловсруулан батлуулах ажлыг санаачилсан байна. Энэ хүрээнд Дэлхийн банкны төслөөр 2013 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6418:2013)-ийг баталжээ. Тус стандартын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар тус үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн. Стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудад хамаарах зохицуулалттай. Энэ стандартын онцлог нь хамгаалах байрны үйлчилгээг дөрвөн төрөл хуваан үзсэн ба эдгээр байраар үйлчлүүлэх тохиолдолд тус бүртээ өөр өөрийн хугацаатай. Тухайлбал,

1. **Яаралтай тусламж үзүүлэх хамгаалах байр** нь хохирогчид эрүүл мэнд, аюулгүй байдал болон бусад яаралтай тусламж, үйлчилгээг дараагийн шатны буюу түр болон урт хугацааны

<sup>27</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэг

<sup>28</sup> Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91-р тушаал "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх" журмыг баталсан байна.

<sup>29</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2019 он, Дугаар 48



хамгаалах байр болон өөр бусад үйлчилгээнд шилжүүлэхээс өмнө 7 хүртэлх хоногоор байрлуулах газрыг;

2. **Дамжих байр** нь хохирогчийг 5 хүртэл хоногоор байрлуулан, аюулгүй байдлыг хамгаалж, энэ хугацаанд түүнд дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий газрыг;
3. **Түр хугацааны хамгаалах байр** нь хохирогчийг 3 хүртэл сар байрлуулж, түүний аюулгүй байдлыг хамгаалж, улмаар эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх газрыг;
4. **Урт хугацааны хамгаалах байр** нь удаан хугацаагаар үйлчлүүлэх шаардлага бүхий хохирогчид 3-6 сарын хугацаанд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх газрыг ойлгоно гэжээ.

Эндээс үзэхэд хамгаалах байрны төрлөөс хамаарч хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хугацаа зохицуулагдаж байна. Мөн түүнчлэн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын хувьд хамгаалах байрны үйлчилгээ үзүүлж байгаа Талита-Ази, ХТЭТ, ХЭҮТ-ийн хамгаалах байрууд нь түр болон урт хугацааны хамгаалах байрны статусаар хохирогчийг хүлээн авснаас эхлээд гурван сараас дээш хугацаагаар үйлчилгээ үзүүлдэг байна. Эдгээр байруудад ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдийг насны хязгаартайгаар байрлуулдаг ба 16 наснаас дээш хохирогч хүүхдийг эцэг, эхийн зөвшөөрөлтэйгээр байрлуулж байсан талаар ганцаарчилсан ярилцлагын явцад илэрхийлж байсан.

Стандартад зааснаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хохирогчид үзүүлэх нийтлэг үйлчилгээнд

1. Хохирогчийг хүлээн авах, тодорхойлох, яаралтай үйлчилгээ үзүүлэх
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх
3. Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө боловсруулах
4. Хохирогчийн түүхийг хаах
5. Хохирогчоос утсаар мэдээлэл авах, зөвлөгөө өгөхийг багтаажээ.

Харин хохирогчид үзүүлэх үндсэн үйлчилгээнд

1. Зөвлөгөө өгөх
2. Эрүүл мэндийн үйлчилгээ
3. Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ
4. Хууль зүйн туслалцаа
5. Хөгжлийг дэмжих
6. Тусгай хэрэгцээг хангах үйлчилгээ гэсэн үйлчилгээг тусгажээ.

Стандартад тусгагдсан эдгээр үйлчилгээг үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (Хавсралт 2) үзүүлж байгаа хэдий ч яг тухайн стандартад заагдсан хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний орчин, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийх замаар сайжруулах арга хэмжээ авах шаардлага ажиглагдаж байлаа. Түүнчлэн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түүнд үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр тус бүрт зарцуулах хугацааг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

2019 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг <sup>30</sup> боловсруулан Стандарт, хэмжил зүйн газраар батлуулжээ <sup>31</sup>. Тус стандартын гол зорилго нь хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй айдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоон мөрдүүлэхэд оршино. Стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг хүний эрхэд суурилан зохион байгуулах,

<sup>30</sup> 2009 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6040:2009 стандартыг хүчингүй болгож улмаар шинэчилсэн стандартыг 2019 онд батлан гаргажээ.

<sup>31</sup> Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6040 : 2019)



төлөвлөх, хэрэгжүүлэх, үйлчилгээний явц, чанар, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд хяналт тавих, үнэлэх, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ гэжээ.

Дээрх хоёр төрлийн стандартын баримт бичгээс харахад тухайн стандартын хэрэгжилтэд хэн хяналт тавих, хохирогчдод үзүүлж буй үйлчилгээг дүгнэх, үнэлэх аргачлал зэрэг мэдээлэл дутуу байгаа нь стандартын хэрэгжилт хангалтгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэх талтай.

**Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн**<sup>32</sup> 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед энэ хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд<sup>33</sup> заасан гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд орох хүсэлтийг гаргах эрхтэй.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтад нийт 11 арга хэмжээг хуульчилахын зэрэгцээ хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах дөрвөн төрлийн үзүүлэх туслалцаа үзүүлэх зохицуулалттай байна.

1. Хууль зүйн туслалцаа
2. Сэтгэл зүйн туслалцаа
3. Эрүүл мэндийн туслалцаа
4. Нийгмийн бусад туслалцааг<sup>34</sup> үзүүлэхээр хуульчилсан байна.

Эдгээр үйлчилгээнээс хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ. Харин нийгмийн бусад туслалцааг үзүүлэх үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх зохицуулалттай.

Тус хуулийн хүрээнд хохирогч, гэрч нарт үзүүлэх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт хяналт тавих чиг үүргийг холбогдох байгууллагуудад хүлээлгэсэн байна. Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг даган гарсан дараах журмууд байна.

- Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам<sup>35</sup>,
- Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам<sup>36</sup>,
- Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам<sup>37</sup>

Дээрх баримт бичгүүдэд насанд хүрээгүй хохирогчийн нас сэтгэхүйн онцлогийг үйлчилгээнд харгалзах, тусгайлсан зохицуулалт хийх талаар заалт огт дурдагдаагүй нь ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар тусгайлсан зохицуулалт дутмаг гэж дүгнэх үндэслэл болов.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлд хүүхэд ХХГХ-ийн хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авах зохицуулалттай. Хэрэв хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд

<sup>32</sup> Төрийн мэдээллийн эмхтгэл, 2017 он, Дугаар 23

<sup>33</sup> Төрийн мэдээллийн эмхтгэл, 2013 он, Дугаар 30

<sup>34</sup> Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн тайлбарт Нийгмийн бусад туслалцаа гэж хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгоно.

<sup>35</sup> Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал

<sup>36</sup> Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал

<sup>37</sup> Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал, Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал

түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилж, хохирогч хүүхдийг хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна. Хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцах зохицуулалттай. Гэвч уг хуульд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хэрхэн илрүүлэх, илрүүлсний дараах үйлчилгээний үе шат, тус бүрийг хэн, хэрхэн үзүүлэхтэй хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг хамгааллын үйлчилгээнд харгалзахтай холбоотой зохицуулалтууд мөн тодорхой дурдагдаагүй байв.

#### Шигтгээ 6

*...Ерөнхийдөө хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж байна, түүн дотроо ХХГХ-т өртсөн хүүхдийг хамгаалах нарийн зохицуулалт байхгүй. ХХГХ-т өртсөн хүүхдийн онцлог хэрэгцээнд уялдуулсан үйлчилгээ, хамгаалалт байхгүй.*

*...Хамгаалах байр нь насны хязгаартай байдаг. Хүүхэд авдаггүй. Бүр хүүхэдтэй эмэгтэйг байрлуулах хамгаалах байр олдоггүй.*

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

Харин Хүүхэд хамгааллын тухай хуульд хохирогч хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээний үе шатыг зааж оруулсан байна. Тус хуулийн 10 дугаар зүйлд<sup>38</sup> зааснаар эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

1. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх
3. Аюулгүй байдлыг хангах
4. Дэмжих, холбон зуучлах
5. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх
6. Гэр бүлд нь эргэн нэгтгэх

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлдэг. Үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэхээр заасан. Энэ нь хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний үе шатыг зааж оруулсан боловч ямар төрлийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ хэн үзүүлэх талаарх тусгайлан зохицуулалт хангалтгүй байна. Мөн бодит байдалд эдгээр үйлчилгээг мэргэжлийн хүний нөөцөөр хүргэж чадахгүй байгаа нь үйлчилгээний үр дүнд нөлөөлдөг гол асуудал байна.

#### Шигтгээ 7

*...Хүүхэд хамгааллын тухай хуульд мэргэшсэн хүний нөөцтэй байна гэдэг боловч бодит байдал дээр мэргэшсэн ажилтан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхгүй байна. Тухайлан орон нутагт мэргэжлийн бус ажилтан хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна. Үүнийг дагаад нөхөн сэргээх үйлчилгээний үр дүн мөн хангалтгүй байдаг.*

Үйлчилгээ үзүүлэгч ТББ-тай хийсэн ярилцлагаас

#### Шигтгээ 8

*...Бүгд л мэдэж байгаа улс төрийн томилгоогоор одоог хүртэл "Хүүхэд хамгааллын" салбар явж л байгаа. Яг салбарын асуудлаар нарийн тогтолцооны талаар тодорхой мэдлэг мэдээлэлгүй учраас нарийн тэр үйлчилгээний менежментийг сайжруулах тал дээрээ илүү сул гэж хардаг. Улс төрийн томилгоотой холбоотойгоор тэр аймаг дүүрэг, хороо, баг дээр ажиллаж байгаа мэргэжилтнүүд мэргэжлийн бус хүмүүс бас цөөнгүй байдаг.*

<sup>38</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, Дугаар 09

ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэгчид, зуучлагч эсвэл хүлээн авагчдын зүгээс ирэх бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон улмаар тарчлаах үйлдлийн хохирогч болсон байдаг нь дээрх төрлийн гэмт хэргийн хохирогчдод тусгайлан хамгаалуулах, урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, шаардлагатай хэрэгцээг нь хангах онцгой шаардлага тулгардаг тул ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдүүдэд хохирогч хамгааллын тусгай бодлого, зохицуулалтыг бий болгох нэн шаардлагатай байна.

**Хохирогч хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчинтой холбоотой шийдвэрлэх шаардлагатай удаах гол асуудал нь хэнийг “хохирогч” гэж авч үзэх тодорхойлолт хууль тогтоомжид нэгдсэн бус, зөрүүтэй байна.** Үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдийг авч үзвэл хохирогчийн талаарх тодорхойлолт эрх зүйн баримт бичгүүдэд ялгаатай байдлаар туссан нь хохирогчийг тодорхойлсон хуулийн заалт хооронд агуулгын зөрүү (gap) байгааг илтгэж байв. Улмаар уг нөхцөл байдал нь хохирогч хуулийн байгууллагаар албан ёсоор хохирогчоор тогтоогдсон эсэхээс хамааран зарим тохиолдолд тусламж дэмжлэг авч чадахгүй байхад хүргэж байна.

**Хүснэгт 6. Хохирогч гэж хэн бэ?**

Холбогдох хууль тогтоомж	Тодорхойлолтууд
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль <sup>39</sup>	3.1.2. Хохирогч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ.
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль <sup>40</sup>	4.1.1. “Гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль <sup>41</sup>	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль <sup>42</sup>	3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг өргөн хүрээнд тодорхойлсон байдаг бөгөөд хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шууд хандан хохирогчоор бүртгэгдэж болохоор заасан нь хохирогчдод ээлтэй зохицуулалт болсон гэж үзэх талтай. Гэтэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хохирогчоор тогтоогдсон хүн хамаарагдахаар заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хохирогч” гэдэгт гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно гэж заасан. Тус тодорхойлолт нь “хохирогч”-ийн ойлголтыг хэт ерөнхий тодорхойлохын зэрэгцээ сэтгэхүйн гэмтэл авсан, сэтгэл зүйн шаналалд өртсөн эсэх агуулгыг хуулийн аль ч тодорхойлолтод тусгаагүй байна (Хүснэгт 6).

**Шигтгээ 9**

*...Хохирогчийн эрх ашиг хамгаалагдах асуудал маань төвөгтэй, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс бол хуульд заасны дагуу л ажил үүргээ гүйцэтгэнэ. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухайн хуульд хохирогчоо тогтоосноос үл хамаараад хохирогчийн асуудал яригдаж байгаа, бусад тохиолдолд бол хамгаалалтын асуудал төвөгтэй хэвээр байна. Хохирогчид хамгаалагдаж чадахгүй л байгаа.*

<sup>39</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2012 он, Дугаар 07

<sup>40</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2013 он, Дугаар 30

<sup>41</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 он, Дугаар 23

<sup>42</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017 он, Дугаар 24

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хамгааллын үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай журам батлагдан гараагүй байна. Тухайлбал, ХХГХ-ийн хохирогчид “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, “Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох” аргачлалыг яаралтай батлан хэрэглээнд нэвтрүүлэх шаардлагатай байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд хохирогч нь сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй ба сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх асуудлыг нэхэмжлэх шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэм хэмжээг харгалзан шүүх тогтооно гэж заасан. Гэвч сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох аргачлал өнөөдрийг хүртэл батлагдаагүй нь хохирогч сэтгэл санааны хохирлоо нэхэмжилдэг ч түүнийг шүүх хангах боломжийг хязгаарлаж байна.

## 2.2.2 ХХГХ-ийн хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг тодорхойлсон хэдий ч түүний хэрэгжилт хангалтгүй байгаа талаар дээр дурдсан.

Суурь судалгааны хүрээнд хохирогчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлыг судлах зорилгоор үйлчилгээ үзүүлж буй 10 ТББ-ын төлөөлөл болон төрийн дэргэдэх Гэмтэл согог судлалын үндэсний төв дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв, Өмнөговь, Дорноговь аймгийн Түр хамгаалах байрны мэргэжилтнүүд, “Өнөр бүл” хүүхдийн асрамжийн газартай тус тус уулзаж мэдээлэл цуглуулан хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг тодрууллаа.

Үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын төлөөлөлтэй ярилцах явцад ХХГХ-ийн хохирогчдод анхан шатны туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай байдаг бөгөөд тус туслалцаанд сэтгэл зүйн зөвлөгөө, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнүүд багтдаг байна. Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зөвхөн хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр тусгасан ба анхан шатны үйлчилгээг хэн үзүүлэх, хаана хандах талаар зохицуулалт орхигдсон болохыг ярилцлагадаа дурдаж байв. Уг орон зайг ТББ-ууд нөхөж ОУБ-ын дэмжлэгтэйгээр өнөөг хүртэл хохирогчдод нэн шаардлагатай анхан шатны үйлчилгээг үзүүлж байна.

Судалгаанд хамрагдсан ТББ-ууд нь хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр таваас дээш жил ажилласан туршлагатай ба тэдний үзүүлж буй үйлчилгээг нэгтгэн авч үзвэл (1) анхан шатны дэмжлэг туслалцаа, (2) нөхөн сэргээх (3) холбон зуучлах гэсэн үндсэн гурван түвшинд үйлчилгээг үзүүлж байна. Байгууллага тус бүрийн үзүүлж буй үйлчилгээний дэлгэрэнгүй Хавсралт 2-оос танилцана уу.

Хүснэгт 7. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагаас хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнүүд

Тусалцаа, дэмжлэг	Анхан шатны тусалцаа				Нөхөн сэргээх				Холбон зуучлах	
	Байрлуулан хамгаалах	Сэтгэл зүйн зөвлөгөө	Хууль зүйн зөвлөгөө	Бусад	Сэтгэл засал	Өмгөөлөл	Боловсролыг дэмжих	Орон гэртэй болгох	Төрийн байгууллаа	Төрийн бус байгууллага
Гүүд Нэйборс ОУТББ		✓								✓
Анбаунд Монгол ТББ		✓	✓	✓					✓	✓
Иргэдэд туслах хүний эрхийн төв			✓		✓					✓
Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ		✓	✓	✓	✓	✓			✓	✓
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг Үндэсний сүлжээ		✓								
Хүүхэд хамгааллын Үндэсний сүлжээ		✓	✓				✓			
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Талита Ази ТББ	✓	✓		✓	✓				✓	
Лантуу дохио ТББ	✓	✓	✓	✓	✓	✓	✓		✓	
Хүйсийн тэгш эрх төв	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Гэмтэл согог судлалын үндэсний төв дэргэдэх НЦҮТ <sup>43</sup>	✓	✓	✓	✓					✓	✓
Өмнөговь аймгийн Түр хамгаалах байр	✓	✓	✓	✓					✓	✓
Дорноговь аймгийн Түр хамгаалах байр	✓	✓	✓	✓					✓	✓
"Өнөр бүл" хүүхдийн асрамжийн газар	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	

Дээр дурдсан байгууллагуудаас Гүүд Нэйборс ОУТББ-ийн Сайхан сэтгэл төв, ГССҮТ-ийн НЦҮТ, Өмнөговь аймгийн Түр хамгаалах байр, Лантуу дохио ТББ-аас бусад нь ХХГХ-ийн хохирогчдод шууд үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байсан. Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хугацаа нь байгууллага бүрийн хувьд харилцан адилгүй. Талита Ази ТББ-ын хувьд хохирогчийг хүлээн авснаас хойш 3 жил хүртэл хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлдэг байхад төрийн байгууллагын Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр нь 1-7 хоногийн хугацаанд байрлуулан ТББ-д холбон зуучлах эсвэл гэр бүлд нь нэгтгэх үйлчилгээ үзүүлдэг байна. Хохирогч хамгаалал, тэд рүү чиглэсэн үйлчилгээний хувьд тогтмол байдлаар үйлчилгээ үзүүлж байгаа нь Талита Ази, ХТЭТ, ХЭҮТ ТББ-ууд байна. Эдгээр байгууллагын хамгаалах байранд сүүлийн 4 жилийн хугацаанд урт болон богино хугацаанд үйлчилгээ авсан хохирогчдын тоог Хүснэгт 8-д харууллаа.

<sup>43</sup> 24-72 цаг байрлуулдаг.

Хүснэгт 8. Хамгааллын үйлчилгээ үзүүлсэн ХХГХ-ын хохирогчдын тоон мэдээлэл

№	Үзүүлэлт	2017		2018		2019		2020		2021/6	
		БМ*	ХМ**	БМ	ХМ	БМ	ХМ	БМ	ХМ	БМ	ХМ
1	Үйлчилгээ үзүүлсэн хохирогчдын тоо	28	0	36	0	33	0	22	1	13	1
2	Үүнээс хохирогч хүүхдийн тоо	16	0	7	0	25	0	16	0	5	0
3	Урт хугацааны хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо (3-аас дээш сар байрласан) <sup>44</sup>	2	0	3	0	3	0	3	0	4	0
4	Богино хугацааны хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо (1-3 сарын хугацаанд байрласан)	14	0	5	0	22	0	13	0	1	0

\*Бэлгийн мөлжлөг


\*\*Хөдөлмөрийн мөлжлөг

Дээрх үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнд үндэслэн Монгол Улс дахь ХХГХ-ийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээний механизмын зураглалыг харуулбал:

<sup>44</sup> Монгол Улсын стандарт, ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6418 : 2013)1.4.6 "урт хугацааны байр" гэж удаан хугацаагаар үйлчлүүлэх шаардлага бүхий хохирогчид 3-6 сарын хугацаанд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх газрыг;



Зураг 12. Монгол Улсад хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй механизмын зураглал



Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуульд заагдсан үйлчилгээний үе шатны дагуу хүрдэг бол ХХГХ-ийн хохирогч хүүхдэд үйлчилгээг үзүүлдэг байгууллага тус бүр өөрсдийн дотооддоо мөрддөг үйлчилгээний баримт бичигт тулгуурлан үзүүлдэг байна. Тухайлбал ХТЭТ нь эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг үйлчлүүлэгч тус бүрд боловсруулж, түүнд тусгагдсан үйлчилгээг хохирогчдод үзүүлдэг.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-с харна уу.

Үйлчилгээнд суурилсан байгууллагуудын хувьд хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнд дараах хүндрэл бэрхшээлүүд тулгардаг талаар судалгаанд оролцогчид онцолж байв: Тодруулбал,

1. Хамгаалах байрны үйлчилгээ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг 7 хоногоос эхлэн 3 сар хүртэлх байрлуулдаг бөгөөд Талита Ази ТББ нь урт хугацаанд буюу гурван жил хүртэлх хугацаанд хохирогчийг байрлуулж байсан. Эдгээр хамгаалах байр нь зөвхөн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийг насны хязгаартайгаар байрлуулдаг. Бага насны хүүхдийг байрлуулах байр байхгүй.

#### Шигтгээ 10

*...Монголд байгаа хамгаалах байр хохирогч болсон хүнийг л авдаг. Яг өндөр эрсдэлт байгаа тэр хүүхдүүдийг авах боломжгүй. Төрөөс энэ тал дээр анхаарах хэрэгтэй. Зөвхөн хохирогч болсон гэхээсээ илүү өндөр эрсдэлтэй байгаа хүүхдүүдийг эрсдэл нь буурахаар буцаагаад гэр бүлд нь нэгтгэх ажил хэрэгтэй байна. Заримдаа бид түрээсийн байр, зочид буудалд төлбөрийг нь төлөөд байлгах, тийм үе шатаар зохицуулдаг.*

Төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагын хэсгээс

2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн байх тохиолдолд сүүлийн жилүүдэд нэлээн өсөх хандлагатай байна. Тиймээс бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчдод руу чиглэсэн урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ чухлаас гадна сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэх зайлшгүй шаардлагатай байлаа. Мөн хохирогч таньж илрүүлэх чиглэлээр мэргэжлийн бүлэгт чиглэсэн сургалтыг зохион байгуулах хэрэгцээтэй байна.
3. ХХГХ-т өртсөн хохирогчдыг нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээг үзүүлэхэд урт хугацаа шаардагддаг тул хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд тулгардаг гол бэрхшээл нь санхүүгийн асуудал болдгийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллүүд мөн илэрхийлж байв. ТББ-ууд нь ОУБ-ын дэмжлэгтэй төсөл хөтөлбөрийн хүрээнд л Хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд хохирогч хамгааллын үйлчилгээ тогтвортой хүргэх нөхцөл бүрдээгүй, санхүүжилтээс шалтгаалан үйлчилгээ тасалдах эрсдэлтэйг илтгэж байлаа.

#### Шигтгээ 11

*...Үйлчилгээний журам дээр хохирогч хүүхэд болон тэдний гэр бүлээс ямар ч төлбөр авахгүй гэж заасан. Харин хохирогч хүүхдэд гарч байгаа зардлыг хүүхэд хамгааллын зардлаас төрөөс нэхэмжлэх байдлаар тухай аймаг, дүүргийн агентлаг, газруудтай гэрээ байгуулж, хамгааллын магадлан итгэмжлэлээр гэрээлэн ажиллахыг зорьдог. 2018 онд 10 кейс дээр ажиллах тендерт оролцож, зардлыг авч байсан. 2019 оноос хойш 2 жил гарган хугацаанд үйлчилгээ үзүүлсэн 200 гаруй кейс байлаа гэхэд 10-15 хувь нь л аймгуудтай гэрээлж хүүхэд хамгааллын зардлаас авч байсан. Үлдсэн зардлыг Канад сангийн дэмжлэгтэйгээр, тасралтгүйгээр одоог хүртэл авч байна.*

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хийсэн ярилцлагаас

4. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд шаардлагатай үйлчилгээнд хамруулахаар цогц үйлчилгээ үзүүлдэг, мэргэшсэн байгууллагууд руу үйлчлүүлэгчээ холбон зуучилдаг. Бусад байгууллагууд руу шилжүүлсэн кейс шийдвэрлэлтийг лавлан асуух, үр дүнгийн талаар эргэн мэдээлэх ажил маш хангалтгүй байдаг.

## Шигтгээ 12

*...Кейс шилжүүлсэн тохиолдолд цагдаа, шүүх, бусад эмнэлгийн байгууллагууд эргэн мэдээлэх ажил байдаггүй. Хувь хүний нууц гэдэг. Тухай хүнд үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээллийг асуухад нууц гэдэг.*

Төрийн болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хийсэн ярилцлагуудаас

Энэ бүгдээс дүгнэхэд төрөөс хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж буй туршлага одоогоор байхгүйн зэрэгцээ энэ төрлийн үйлчилгээнд тусгайлсан төсөв тавигдсан, зарцуулагдсан туршлага байхгүй байна. Харин 2019 онд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах<sup>45</sup> зорилгоор ХЗДХЯ-с Хүйсийн тэгш эрх төв ТББ-д “Хохирогч хамгааллын үйлчилгээг тогтмолжуулах” зөвлөх ажил үйлчилгээний төслийн хүрээнд 20,000,000<sup>46</sup> сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ нь ХХГХ-т өртсөн 15 хохирогчийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдсан туршлага байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн<sup>47</sup> хүрээнд зөвлөх үйлчилгээ буюу төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээ гэдэгт багтаж хэрэгжсэн байна.

Эдгээр үр дүнг харгалзвал ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах ээлтэй тогтолцоо Монгол Улсад бүрдсэн эсэхэд эргэлзээтэй нөхцөл байдлууд хууль эрх зүйн орчны хүрээнд болон практик түвшинд аль алинд нь ажиглагдлаа. Хохирогч хамгааллын асуудлаар хууль эрх зүйн орчинд цөөнгүй хийдэл (gap), алдаа байхаас гадна зохицуулагдаагүй үлдсэн асуудлууд байна. Наад зах нь төрийн институтийн хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдээгүй, тус үүргийг ИНБ-ууд дангаар гүйцэтгэж байна. Тухайлбал, ХХГХ-ийн хохирогчийг хамгаалан байрлуулах анхан шатны үйлчилгээг зөвхөн ТББ-ууд үзүүлж, бусад шаардлагатай сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцааг тодорхой хугацаатай төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохицуулж байна. Үүнээс үзэхэд хохирогчид үйлчилгээ үзүүлэх үе шатыг онцгойлон авч үзэх, ингэхдээ хохирогчдод туслалцаа үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг судлах, тэдгээрийн цаашдын тогтвортой байдлыг хангах, улмаар улсын төсвөөс хохирогч хамгааллын анхан болон нөхөн сэргээх үйлчилгээнд зориулж төсөв хуваарилдаг болох хэрэгцээ байна. Мөн түүнчлэн хохирогч хүүхэд үзүүлэх үйлчилгээний тусгайлсан бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна.

### 2.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор, прокурор, шүүхийн 4 оролцогч талтай ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж, холбогдох тоон мэдээллийг цуглуулсан. Уг үр дүнд үндэслэн хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-ийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин болон түүний хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тус бүлэгт авч үзлээ.

#### 2.3.1 Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-ийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин

Монгол Улсын 2008 онд нэгдэн орсон Палермогийн протоколд “ХХГХ гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрөлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан ХХГХ

<sup>45</sup> АНУ-ын Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан илтгэл 2020-д Монгол Улсын Засгийн газар Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 509 сая төгрөг зарцуулсан гэжээ.

<sup>46</sup> ХЗДХЯ, Эс Ай Си Эй “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” тайлан, 2019

<sup>47</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл, 2005 он, Дугаар 48

үйлдсэн гэж үзэхээр заасан. Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр ХХГХ-т тооцно” гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд мөн ХХГХ-ийг хуульчлахдаа бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтнийг авах зэрэг үйлдлийг ХХГХ-т тооцох, хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байх нь хамааралгүй байхаар зохицуулсан. Гэвч уг судалгааг гүйцэтгэх явцад оролцогч талуудтай хийсэн ярилцлага болон баримт бичгийн судалгааны үр дүнд **Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь хуулийн зүйл заалтын давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй, тодорхойгүй байдал үүсгэж буй** байдал ажиглагдсан. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ХХГХ-ийг зүйлчилсэн хэдий ч мөн хуулийн дараах зүйл заалтын агуулга, шинж нь ХХГХ-ийн шинжийг агуулсан байна. Үүнд:

- 12.3 дугаар зүйлд Бэлгийн мөлжлөг,
- 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах,
- 13.13 дугаар зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйлд Хүүхдээр гуйлга гуйлгах,
- 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдах,
- 16.8 дугаар зүйлд Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах,
- 16.9 дугаар зүйлд Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах,
- 16.10 дугаар зүйлд Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх

Дээр дурдсан заалтуудын хувьд дараах үндэслэлүүд нь ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг Эрүүгийн хуульд давхардуулан хуульчилсан гэж үзэхэд хүргэж байна. Үүнд:

- **Нэгдүгээрт**, Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 12.3.4 дэх хэсэгт “энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж, ашиг олох зорилгоор бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн” бол оногдуулах ялыг хүндрүүлж оногдуулахаар заасан. Гэвч мөн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийг ашиг олох зорилгоор бэлгийн мөлжлөгт өртүүлсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 эсхүл 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн аль нь болох талаар өрсөлдүүлсэн хэм хэмжээг бий болгосон нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд саад учруулж байна.
- **Хоёрдугаарт**, Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохоор заасан. Гэвч тус заалтын зүйлчлэлийн агуулга нь<sup>48</sup> Эрүүгийн хуулийн 13.1 ХХГХ-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжтэй давхцаж байна.
- **Гуравдугаарт**, Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн сайшаалтай хэдий ч дээр дурдсан заалтууд нь мөн л ХХГХ-ийн шинжтэй давхардаж байгаа юм. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн бол ямар аргаар хэрхэн үйлдсэн эсэхийг үл харгалзаж ХХГХ гэж үзэхээр заасан ч хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүлэгт хамаарах гэмт хэргүүдийн үндсэн шинж нь ХХГХ-ийн шинжтэй давхцаж буйгаас хэрэг хянан

---

<sup>48</sup> хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн”

шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсэх буюу аль зүйл заалтаар хэргийг шийдвэрлэх эсэхийг шийдэхэд хүндрэл тулгарахаар байна.

- **Дөрөвдүгээрт, Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа "хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтнийг авсан" бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл буюу ХХГХ-ийн агуулга нь "...хүний эд, эрхтнийг авах..." үйлдлийг мөн хамарсан байна.**

Ийнхүү ХХГХ-ийн төрөл хэлбэр тус бүрийг бие даасан гэмт хэрэг гэж тооцох нь энэ төрлийн гэмт хэргийг бусад гэмт хэргээр зүйлчилж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх явцад нийтлэг тохиолдолд гэмт хэрэг үйлдэгчийн субъектив санаа, сэдлийг тодорхойлох боломжгүй нөхцөлд түүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтаар буюу бага ялтай зүйл ангиар шийдвэрлэх зарчим үйлчилдэг билээ.

Эрүүгийн хуульд заасан дээрх гэмт хэргүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг харьцуулж үзвэл ХХГХ-т оногдуулах ял нь бусад хэргээс илүү өндөр байна (Хүснэгт 9). Гэтэл эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрлүүдтэй төстэй гэмт хэргийн шинжийг хуульчлахдаа хэргүүдийн ялгааг сайн гаргаагүй, энэ талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхээс гаргаагүй зэрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж байна.

**Хүснэгт 9. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дээрх хэргүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын харьцуулалт, хэргийг хүндрүүлэх зүйлчлэлээр**

Хэсэг Зүйл	1 дэх хэсэг	2 дахь хэсэг	3 дахь хэсэг	4 дэх хэсэг
13.1. Хүн худалдаалах	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих	
12.3 Бэлгийн мөлжлөг	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял
13.13. Албадан хөдөлмөрлүүлэх	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих			
15.3. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	
16.4. Хүүхдээр гуйлга гуйлгах	нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих			
16.6. Хүүхэд худалдах	торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих			
16.8. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих			

16.9. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	торгох, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих	торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял		
16.10. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих			

13.1-р зүйлд ХХГХ-ийг насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хохих ял оноохоор заасан. Эдгээр ял шийтгэл нь хангалттай чанга бөгөөд хүнд заалт болсон гэж үздэг. Харин Эрүүгийн хуулийн 12.3-р зүйл Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт 14-18 хүртэлх насны хүүхдийн биеийг үнэлүүлэх зорилгоор бэлгийн мөлжлөгт өртүүлсэн бол 2-8 жилийн хорих ял, 14-өөс доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол 12-20 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Гэсэн ч өмнөх жилүүдийн нэгэн адил эрх бүхий байгууллагаас заримдаа хүн худалдаалах гэмт хэргийг яллахдаа хөнгөн ялаар зүйлчлэх<sup>49</sup> явдал байгаа нь өмнө дурдсан хуулийн зүйл заалтын тодорхойгүй байдалтай холбоотой байх эрсдэлтэй байна.

**Ярилцлагын явцад ажиглагдсан өөр нэг чухал үр дүн нь насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлоо хамгаалуулах эрх зүйн орчин хангалтгүй байгаа явдал юм.** Монгол Улсын Их Хурлаас 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргасан. Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам өнөөг хүртэл батлагдаагүй учир хуулийн байгууллагад хандсан төлбөрийн чадваргүй насанд хүрээгүй хохирогч өмгөөллийн туслалцаа авч чадахгүй нөхцөл байна.

Төр ийнхүү төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг орхигдуулсныг үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд нөхөж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд мэргэшсэн өмгөөлөгч хөлсөлж байгаа нь ажиглагдаж байна. Эдгээр байгууллагуудаас жишээ дурдахад Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ-аас 2017-2020 онд 10 орчим ХХГХ-ийн хохирогчид өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлсний хоёроос гурав нь хүүхэд байжээ. Мөн Хүйсийн тэгш эрх төв ТББ нь ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд хүний эрх, хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомжийн талаарх мэдээллийг өгөх, эрх зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, хуулийн байгууллагад хандсан хохирогч нарын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг ажиллуулдаг. Энэ бүх тохиолдлуудад хохирогчдын өмгөөллийн хөлсийг хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөсөө санхүүжүүлсэн талаар тэдний өгсөн ярилцлагад дурджээ.

### Шигтгээ 13

*...Өмгөөлүүлэх эрхээр хангагдах асуудал дутагдалтай байна. Сайн дурын үндсэн дээр хэрэг, маргаанд оролцох өмгөөлөгч дутмаг, санхүүгийн асуудлаа шийдвэрлүүлсний үндсэн дээр хэрэг маргаанд оролцох сонирхол ихтэй байна. Хэдийгээр эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч оролцож байгаа боловч зайлиггүй тохиолдолд өмгөөлөгчийн асуудал хүндрэлтэй байна.*

Цагдаагийн байгууллагатай хийсэн ярилцлагаас

ЭХХШТХ-ийн 9.5 дугаар зүйлд хууль ёсны төлөөлөгчийн эрх зүйн байдлын талаар заасан. Өөрөөр хэлбэл мөрдөгч, прокурор нь өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр томилно. Арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр

<sup>49</sup> АНУ-ын ЭСЯ-ны 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан <https://mn.usembassy.gov/mn/2021-trafficking-in-persons-report-mn/>



тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно гэж заасны дагуу насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилж, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах боломжийг бий болгосон байна. Гэвч энэ нь мөн л бодит байдалд хэрэгжихэд төвөгтэй байгаа нь тус судалгааны үр дүнгээс ажиглагдсан.

#### Шигтгээ 14

...Дан ганц ХХГХ-ийн хохирогчоос гадна насанд хүрээгүй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын хууль ёсны төлөөлөгчийн асуудал өнөөдөр төвөгтэй хэвээр байна. Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, эсвэл эцэг эх тухайн хүүхдийг гэмт хэргийн хохирогч болоход ашиг сонирхлын зөрчилдөөнтэй зэрэг шалтгаанаар ГБХЗХГ-аас хууль ёсны төлөөлөгчийг тогтоох асуудал түгээмэл байдаг. Гэхдээ хууль ёсны төлөөлөгчөөр ордог хүмүүсийг тодорхой хэмжээгээр бэлдэх хэрэгтэй гэж бодож байна. Асуудлуудаа тодорхой зөв тавьж чаддаг, үнэхээр хүүхдийн төлөө байж, хүүхдийн төлөө гаргаж чадах асуудлуудыг тавьж чадах, тодорхой хэмжээний мэдлэгтэй, түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хамгаалах асуудал дутагдалтай байна. Зарим хүмүүс чинь ажил төрлөөсөө гарах, өөрчлөгдөх тохиолдол байна, тэр тохиолдолд тун хурдан хугацаанд хууль ёсны төлөөлөгчийг дахин томилохгүй бол хэрэг нь цагдаагийн газар ч юм уу, прокурор дээр хянагдаж байгаад хэрэгсэхгүй болгоод хаагдчихдаг. Тэгээд нөгөө ээж аав нь мэдэх боломжгүй, хэрэгт оролцох эрхгүй байдаг. Нөгөө хууль ёсны төлөөлөгчид хэлэх гэхээр хууль ёсны төлөөлөгч нь холбогдохгүй байдаг. Тэгээд хэрэг нь хэрэгсэхгүй болоод хаагдах ийм нөхцөл байдлууд гарч байна.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

### 2.3.2 Хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-ийг хянан шийдвэрлэж буй өнөөгийн байдал

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээллээс үзвэл 2017-2020, мөн 2021 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг болон хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн гаралт өсөхийн зэрэгцээ хохирогч хүүхдийн тоо мөн тогтвортойгоор өсөх хандлагатай байна (Зураг 13).

Зураг 13. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн тоо




Ялангуяа хүүхдэд садар самууныг сурталчлах, түүнд татан оруулах замаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болгох, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдал сүүлийн 4 жилийн хугацаанд өссөн дүнтэй байгаа нь дээрх судалгаанаас ажиглагдаж байна. Харин 2019 онд хүүхэд худалдах гэмт хэрэг 1, хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэрэг 1, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн ч одоогоор шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.

Зураг 14. Бүртгэгдсэн гэмт хэрэгт хохирсон насанд хүрээгүй хүний тоо



Мөн хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт өртөж хохирч буй хүүхдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Ялангуяа хүн худалдаалах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэгт хүүхэд хохирох явдал нэлээдгүй байна.

Зураг 15.Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэргийн тоо



Цагдаагийн байгууллагын дээрх мэдээллээс үзэхэд ХХГХ-ийн гаралт жил тутам өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхий нийтээр тархсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор улсын хилээс гадна дотоодын зорчих хөдөлгөөнийг хязгаарласан нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар хүн худалдаалах гурван гэмт хэрэг бүртгэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж болох ч энэ нь гэмт хэргийн гаралт багасаж байна гэж үзэх үндэслэл биш юм (судлаач).

ХХГХ-ийг хүүхдийн эсрэг үйлдсэн аргыг авч үзвэл гадаадад хэлний бэлтгэлд зуучлах, сургуульд тэтгэлгээр суралцуулах, өндөр цалинтай ажилд зуучлах зэргээр зар гаргаж, хуурч мэхлэн гадаад улсад гарган биеийг үнэлүүлж, хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд гарсан байна. Мөн хүүхдээр гуйлга гуйлгах, хулгай хийх болон хурдан морь унуулах, мал маллуулах, эсвэл хогийн цэг дээр хог түүлгэх, барилга зэрэг салбарт албадан хөдөлмөр эрхлүүлэх явдал нэмэгдэж байна.

Мөн цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа “хүчиндэх” гэмт хэргийн тоо сүүлийн 3 жилийн хугацаанд огцом өсөж, хохирогчдын 80% орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, үүний 46.8% нь 8-17 насны охид байна. АНУ-ын Төрийн департаментын 2020 оны тайлан<sup>50</sup>д “...Япон, БНСУ-ын жуулчид насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг” талаар дурдсан

<sup>50</sup> 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан | Монгол Улс дахь Америкийн нэгдсэн улсын элчин сайдын яам (usembassy.gov)

байгаагаас үзэхэд Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, хохироох байдал улам даамжирч буй нь харагдаж байна.

Зураг 16. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо



Шүүхийн статистикийн мэдээллийг цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдаж байгаа хэргийн тоон мэдээлэлтэй харьцуулан үзвэл шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй байна. Тодруулбал, 2017-2020 онд хүн худалдаалах 69, бэлгийн мөлжлөгийн 16, албадан хөдөлмөрлүүлэх тав, хүүхдээр гуйлга гуйлгах нэг, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 55, хүүхэд худалдах нэг, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах нэг, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх 25 гэмт хэрэг бүртгэгдсэн ч шүүхээс хүн худалдаалах 13, бэлгийн мөлжлөг хоёр, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах долоон хэргийг шийдвэрлэсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо цөөн байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цар хүрээ, түүнд зарцуулж буй хугацаа, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлсэн эсэх, хохирогчдыг бүрэн тогтоосон байдал зэргээс гадна шүүхийн ачаалал зэргээс хамааралтай юм. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт мэдлэг сул, боловсон хүчний тогтвор суурьшилгүй байдал нь нөлөөтэй болохыг оролцогч талууд ярилцлагадаа дурдаж байв.

Дээрх тооны хэргийн илрүүлэлт, хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны бүтцийг авч үзвэл Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг ЭЦА-ны зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд 5 хүний орон тоотой байгуулсан. Уг хэлтэс нь Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар “Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар дараах гэмт хэргүүдийг харяалан шалгахаар үүрэг хүлээсэн байна. Үүнд:

- 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг,
- 13 дугаар бүлгийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах,
- 13.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Хүн хулгайлах,
- 13.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Хүн барьцаалах,
- 13.4 дүгээр зүйл Хүнийг хүчээр алга болгох,
- 15.3 дугаар зүйл Хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах,
- 15.4 дүгээр зүйл Хүний цус, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах,
- 15.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах,

- 16.8 дугаар зүйл Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах,
- 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самуун сурталчлах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэргийг шалгах харьяаллыг тогтоосон.

Харин Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/316 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны бүтцэд Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг шинээр байгуулан ажиллаж байна. Энэ хэлтэс нь Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.8 дугаар зүйл Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самуун сурталчлах гэмт хэргээс бусад хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж эхэлсэн.

Хэдийгээр цагдаагийн байгууллагын эрүүгийн болон мөрдөн байцаах албаны бүтцэд ХХГХ болон хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөх нэгж, Прокурорын байгууллагад бага насны хүүхэд хохирсон болон өсвөр насны хүүхэд холбогдсон хэрэгт хяналт тавих дагнасан прокурор ажиллаж байгаа ч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад ийм албан тушаалтан байхгүй, шүүхийн байгууллагад ч дагнасан шүүгч байхгүй нь гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх болон мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх явцад хэргийн зүйлчлэл өөрчлөгдөх, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх асуудал гарсаар байгаа нь талуудын өгч буй мэдээллээс тодорхой харагдаж байв. Тухайлбал, Цагдаагийн байгууллагын Гэмт хэргийн нэгдсэн сангийн ХХГХ-ийн сүүлийн 3 жилийн статистикийн мэдээллээс үзвэл 2018 онд 10 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс зургаа, 2019 онд 14 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс долоо, 2020 онд 14 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс дөрвөн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

#### Шигтгээ 15

*...Манай хэлтсээс ЭХ-ийн 13.1 дүгээр зүйл ХХГХ-т насанд хүрээгүй хүүхэд өртөж хохирсон асуудлыг Нийслэлийн прокурорын газартай ойлголцож нэг цонхоор харж олон хэргийг шүүхээр амжилттай шийдвэрлүүлсэн. Гэвч дүүрэг, орон нутагт цагдаа, прокурор нэгдсэн ойлголтод хүрээгүй энэ ажил хангалтгүй байсаар байна. Тухайлбал насанд хүрээгүй хүүхэд хохирсон хэрэгт биеэ үнэлэхийг зохион байгуулах эсхүл бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэж зүйлчлэх хандлага байдаг.*

Цагдаагийн байгууллагатай хийсэн ярилцлагаас

Эдгээр үр дүнгээс үзэхэд хууль сахиулах, шүүх байгууллагын албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн ХХГХ-тэй холбоотой заалтуудын талаар мэдлэг, ойлголт дутмаг байгаа нь зарим хэргүүдэд хөнгөн ял шийтгэл оногдуулахад хүргэж байх тал байгаа нь харагдаж байгаа ба уг нөхцөл байдлыг нотлох үр дүнгүүд бусад ижил төстэй судалгааны тайлангуудад дурдагдсан<sup>51</sup> байгаагаас үзэхэд хуулийн заалтыг нэг мөр ойлгох байдлыг сайжруулах, төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг тогтвор суурьшил багатай төрийн албаны онцлогийг харгалзан тогтвортой, системтэй явуулахад анхаарах шаардлагатай зүй ёсоор байна.

## 2.4 Хамтын ажиллагаа

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн өөр нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр төр, төрийн бус болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах явдал билээ. Энэ хүрээнд оролцогч

<sup>51</sup> “Төрийн албан хаагчдын дунд зөвхөн охид, эмэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болдог гэх нийтлэг ташаа ойлголт байдгаас үүдэн эрэгтэй хохирогчтой хүн худалдаалах гэмт хэргийг 13.1, 12.3-р зүйл ангиар бус харин илүү хөнгөн ялтай зүйл ангиар яллаж байна”, Хүний наймааны төлөв байдлын тухай тайлан, АНУ-ын төрийн департамент, 2020 он

талуудын хамтын ажиллагааны түвшинг тэдгээр талуудын үнэлгээнд үндэслэн тодорхойлох зорилготой бүтэцжүүлсэн асуумж боловсруулан тогтолцооны оролцогч нийт 25 байгууллагаас (төрийн-12, ТББ-7, ОУБ-6)<sup>52</sup> мэдээлэл цуглуулан уг бүлэгт үр дүнг нэгтгэн харууллаа.

Хамтын ажиллагааны түвшинг үнэлүүлэхдээ оролцогч тал тус бүрээр ХХГХ-тэй тэмцэх чиглэлээрх ажлуудад бусад байгууллагуудтай хэр хамтарч ажилладаг, хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг 1-5 хүртэлх тоон шкалаар үнэлүүлж, дундаж үзүүлэлтийг тооцсон (Хүснэгт 10).

Ерөнхий дундаж үзүүлэлттэй танилцвал талууд **урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд хоорондоо хамтарч ажиллах байдлаа харьцангуй сайн** гэж үнэлсэн бол эсрэгээр хамтын ажиллагаа сул явагддаг үйл ажиллагаа нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон **хохилогч байж болзошгүй хүмүүсийг эрт илрүүлэх чиглэлд хамтын ажиллагааг хангалттай биш** гэж үнэлсэн байна.

**Хүснэгт 10. Хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бүх талуудын хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээ, оролцогч талуудаар<sup>53</sup>**

	Нийт түүвэр	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Олон улсын байгууллага	Дундаж
Урьдчилан сэргийлэх	25	4.00	3.33	3.50	3.71
Илрүүлэх	25	3.27	2.50	3.00	3.00
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	25	3.20	2.80	3.20	3.10
Хохилогчийг хамгаалах	25	3.75	2.86	2.83	3.28
Хохилогчид нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх	25	3.58	3.20	2.83	3.30
Нөлөөллийн үйл ажиллагаа	25	3.50	3.14	3.50	3.40

Оролцогч талуудаар нь авч үзэхэд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг авч үзэх талуудын ойлголт, хүлээлтэд ялгаатай байр суурь ажиглагдсан. Тухайлбал, төрийн байгууллагуудын хувьд хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг болон хохилогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд ТББ болон ОУБ-тай хамтран ажиллах байдлаа харьцангуй сайн гэж үнэлсэн бол ТББ-ын төлөөллүүд яг эсрэгээр эдгээр ажлууд дахь бусад талуудтай хамтран ажиллах байдал хангалтгүй сул явагддаг гэж үзэж байна.

Олон улсын байгууллагуудын хувьд урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудад нийт талуудын хамтын ажиллагааг дунджаас дээгүүр үнэлсэн байгаа бол хохилогчийг хамгаалах чиглэлд хамгийн сул гэж үнэлжээ. Оролцогч талуудаас дээрх үнэлгээг өгсөн шалтгааныг тодруулахад:

<sup>52</sup> Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 12% (3) нь орон нутгийн түвшинд, 64% (16) үндэсний түвшинд, 24% (6) олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулж байна.

<sup>53</sup> Хамгийн өндөр оноо=5 буюу маш сайн, хамгийн бага оноо=1 буюу маш муу, дундаж оноо=3 буюу дунд зэрэг

Хүснэгт 11. Хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээнд өгсөн тайлбарууд

	Тааруу буюу муу гэж үзэж буй шалтгаан	Сайн гэж үзэж буй шалтгаан
Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хэрэг илрүүлэлт, хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл байдаггүй.</li> <li>✓ Шүүх эмнэлэг, цагдаагийн газар хамтран ажилладаг хэдий ч шийдвэр гаргалт муу.</li> <li>✓ Иргэд олон нийт рүү чиглэсэн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаарх нөлөөллийн ажил дунд. Жишээ нь олон нийт ХХГХ-ийн талаар мэдлэг байхгүй. Бэлгийн мөлжлөг эсвэл хөдөлмөрийн мөлжлөгт өртөөд байгаа хэр нь өөрийгөө өртөөд байна гэдгээ мэддэггүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгааллын ажиллагаа сайн.</li> <li>✓ Салбар дундын зохицуулалт нэлээн сайжирсан. ГХУСА33-д тухайн жил ямар чиглэлийн ажлыг ямар байгууллага хамтарч хийх тухай саналыг нээлттэй олгодог. ГХУСА33-ийн хурал нээлттэй болдог тул төлөвлөлт гаргах процессоос эхлээд байгууллагууд тайлангаа хэлэлцэж үр дүнгээ тооцно. Салбар дундын хамтын ажиллагаа сайжирч байна.</li> <li>✓ 2017 оны 12 сард ХНХ-ын дэд сайдаар ахлуулсан Хүүхдийн хөгжил хамгааллын байнгын ажиллагаатай салбар дундын баг байгуулагдсан. Энд 40 гаруй баг салбар дундын бүлэгт ажилладаг. Хүүхэдтэй холбоотой асуудал салбаруудын хоорондын уялдаа холбоо, төлөвлөлт сайжирч байна.</li> <li>✓ МУ-ын ЗГ болон байгууллага, иргэд хүүхэд хамгааллын чиглэлд хүчээ нэгтгэх, хүүхдийн эрхийн зөрчлийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэх, хүүхэд хамгаалах чиглэлээр тодорхой хувь нэмэр оруулж байна.</li> </ul>
Төрийн бус байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хууль тогтоомжийн ойлгомжгүй байдлууд нөлөөлж байна. Ойлгомжтой хууль тогтоомжийн хэсэг байгаа хэдий ч хэрэгжүүлэхгүй байна. Энэ талын мэдлэг мэдээлэл хуульчдад, хүмүүст нэг түвшинд болоогүй байна.</li> <li>✓ Хохирогчийг хамгаалах – Эрүүгийн хуульд хохирогчийг хамгаалах зүйл заалтууд тусгагдсан байдаг хэдий ч хангалттай хэрэгжүүлэхгүй байна. Жишээ нь: Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хохирогчийн байгаа газар очихгүй байх, холбоо тогтоохгүй байх зэрэг зохицуулалтууд байдаг ч хэрэгжидгүй.</li> <li>✓ Салбар хоорондын ойлголт нэг түвшинд биш. ОУ-ын туршлага судалдаггүй.</li> <li>✓ Нэгдсэн судалгаа мэдээллийн сан байдаггүй. Үндэсний хөтөлбөр төсөвгүй.</li> <li>✓ Хүний нөөц хангалтгүй, сүүлийн үеийн техник, технологи хангалтгүй.</li> <li>✓ Урьдчилан сэргийлэх механизм муу. Урьдчилан сэргийлэх бүх зүйлийн суурь гэдгийг мэддэггүй. Хүлээн зөвшөөрдөггүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ ХЗДХЯ дээр хэрэгждэг төслийн хүрээнд сургах, хүмүүсийн ойлголт хандлагыг, прокурор, цагдаа, хуулийн байгууллагын албан хаагчдыг сургах тал дээр ахиц гаргаж байна.</li> </ul>
Олон улсын байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>✓ Салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул, тодорхой төсөл хөтөлбөрөөр хязгаарлагдаж байна.</li> <li>✓ Хүүхэд рүү чиглэсэн ХХГХ-ээс сэргийлэх тусгай хөтөлбөр, төсөл байдаггүй.</li> <li>✓ Механизм байхгүй учраас хамтын ажиллагаа бүрдэж чадахгүй байна.</li> <li>✓ Тогтвортой бүтэц, нарийн зохицуулалт, мэргэшсэн хүний нөөц байхгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэхэд дэмжиж ажилладаг. Тиймдээ ч ТБ, ТББ-тай хамтарч байнгын хамтарч, урт хугацааны үр дүнд чиглэж, чадавхыг бэхжүүлэхэд чиглэж ажилладаг.</li> </ul>



Дээрх үр дүнгээс гадна ХХГХ-тэй тэмцэх чиглэлд бүх талуудын хамтран ажиллах хүсэл, санаачилга сайн байгаа нь нэг талаар давуу тал байсан бол мэдээллээ солилцох, харилцан уялдаатай ажиллах байдлаа бүх талууд багаар үнэлж байна (Хүснэгт 12).


Хүснэгт 12. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх оролцогч талуудын хамтын ажиллагаанд өгсөн талуудын үнэлгээ, оролцогч талуудаар<sup>54</sup>

Үзүүлэлт	Нийт түүвэр	Төрийн байгууллага (12)	Төрийн бус байгууллага (7)	Олон улсын байгууллага (6)	Дундаж
Хамтран ажиллах хүсэл, санаачилга	25	4.33	4.00	4.20	4.19
Хамтран ажиллах төлөвлөгөө гаргах байдал	25	4.00	3.33	3.60	3.70
Төлөвлөгөөний дагуу хамтран ажиллах байдал	25	4.11	2.86	3.40	3.52
Мэдээллээ солилцох, харилцан уялдаатай ажиллах	25	3.60	3.29	3.20	3.41
Бодлогын хувьд уялдаа холбоотой ажиллах байдал	25	3.60	3.50	3.40	3.52

Төрийн байгууллагуудын хувьд хамтран ажиллах, төлөвлөгөө гаргах байдлыг өндрөөр үнэлсэн байхад ТББ-ууд төлөвлөгөөний дагуу хамтарч ажиллах байдлыг дундаас доогуур буюу 2.86 гэж үнэлсэн нь анхаарал татаж байна.

Мөн хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг байгууллага тус бүрээр нь үнэлүүлсэн. Үр дүнг нэгтгэхэд бүх талуудын хувьд ОУБ-ын бусад талуудтай хамтран ажиллах байдлыг сайн гэж нийт оролцогчдын 80%, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг 68%, ТББ-ын хамтын ажиллагааг 64%, харин иргэд, олон нийттэй хамтран ажиллах байдал хамгийн бага буюу 44%-ийн үнэлгээтэй байна (Зураг 17).

Зураг 17. Байгууллагын ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дурдсан бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж буй үнэлсэн байдал, хувиар



Цаашид талуудын хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэхийн тулд санал болгох, анхаарах асуудлыг тодруулахад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр талууд хамтын ажиллагааны гүйцэтгэлээ жил бүр үнэлж байх нь ихээхэн чухал ихэнх оролцогчид дэмжсэн байна (Зураг 18).

Зураг 18. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх хамтын ажиллагааг цаашид хэрхэн сайжруулж болох вэ?

<sup>54</sup> Хамгийн өндөр оноо=5 буюу маш сайн, хамгийн бага оноо=1 буюу маш муу, дундаж оноо=3 буюу дунд зэрэг



Дээрх хариултуудын зэрэгцээ төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, ХХГХ гарсан тохиолдолд тухайн кейстэй ажиллах механизм, тогтолцоо, зохион байгуулалтыг системтэй болгоход анхаарч, бүх талуудын оролцоо чиг үүргийг тодорхой болгох байдлаар хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зарчмыг бодлогын түвшиндөө анхаарах нь чухал болохыг оролцогчдын яриа харуулж байлаа.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тогтолцооны оролцогч талуудын хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг төр, ТББ, ОУБ-ын төлөөллөөс цуглуулсан үнэлгээнд тулгуурлан дүгнэхэд хамтын ажиллагааны үр дүнтэй байдлын талаар бүх талуудын дүгнэлт, байр суурь ялгаатай байгаа нь дээрх үр дүнгүүдээс харагдаж байна. ХХГХ-тэй тэмцэх чиглэлд илрүүлэлт болон хохирогч хамгааллын үйлчилгээн дэх хамтын ажиллагааг сайжруулахад илүү анхаарал хандуулах шаардлагатайг бүх талуудын хариулт харуулж байсан.

Мөн байгууллагуудын үйл ажиллагааны түвшинд хамтран ажиллах санаачлаг, хүсэл эрмэлзэл бүх талуудын дунд харьцангуй сайн байдаг боловч бодлогын түвшинд үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээллийн урсгал, тогтмол мэдээлэл солилцох байдал сул байна. Мөн хамтын ажиллагааны үр дүнтэй байдлаа тодорхойлохын тулд оролцогч талууд гүйцэтгэл, оролцоо, хамтын ажиллагаагаа жил бүр үнэлж дүгнэх, хамтын ажиллагаанаас гарах үр дүнг тодорхойлж, хүлээлтээ нэгтгэхэд анхаарах зэрэг асуудлуудыг онцлон үзэж байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛ

Уг бүлэгт Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн логик хүрээ дэх суурь шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилтын хүрээнд (1) Хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг тодорхойлох, (2) Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг тодруулах зорилтуудын үр дүнг танилцуулж байна. Дээрх шалгуур үзүүлэлтийг тодорхойлохын тулд төслийн зорилтот орон нутаг дахь өрхийн эцэг эх болон хүүхэд залуучуудыг хамруулсан нийт 408 түүврийн хэмжээнд цуглуулсан тоон мэдээлэлд тулгуурлан уг бүлгийг боловсрууллаа.

## 3.1 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, зан үйл

Эцэг эх, хүүхэд залуучуудын ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлохдоо түүний илрэх хэлбэрүүд болох бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр тус бүрийн талаар зөв зохистой ойлголт бий эсэхийг тодруулахыг зорьсон. Ингэхдээ судалгааны эхлэлтийн шат дахь баримт бичгийн судалгааны үр дүн болон оролцогч талуудтай ярилцлага хийх явцад олон нийтийн дунд ХХГХ-ийг зөвхөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлж хил дамнуулан худалдах гэдэг ерөнхий ойлголт түгээмэл байдгаас бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх зэрэг үйлдлийг ХХГХ-ийн хэлбэр болох, түүний илэрч болох үйлдлийн талаар ойлголт дутмаг байгааг холбогдох мэргэжилтнүүд дурдаж байсан. Иймд эцэг эх, хүүхэд залуучуудын ХХГХ-ийн талаарх мэдлэг ойлголтыг:

- Бэлгийн мөлжлөг
- Хүүхдийн албадан хөдөлмөр эрхлүүлэлт (ХАХЭ)
- Хүн худалдаалах гэмт хэрэг гэсэн 3 ойлголтын хүрээнд тодруулахын сацуу эдгээр талуудын мэдээлэл авч буй гол эх сурвалжийг тодруулахыг зорилоо.

Судалгааны үр дүнг нэгтгэн доорх хүснэгтэд харууллаа.<sup>55</sup> Ерөнхийд нь дүгнэвэл эцэг эх, хүүхдүүдийн ХХГХ-ийн талаарх мэдлэг, хандлага нийтээрээ тааруу байна. Ялангуяа эцэг эх, хүүхдүүдийн бэлгийн мөлжлөгийн талаарх мэдлэг, хандлага бусад ХХГХ-ийн төрлөөс хамгийн бага байна. Эцэг эх, хүүхдүүд хоёулангийнх нь хувьд ХАХЭ-ийн талаарх мэдлэг дунд түвшинд үнэлэгдсэн бөгөөд мэдлэгээ дагаад хандлага ч ижил түвшинд байгаа үр дүн гарчээ. Харин хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг дунд түвшинд үнэлэгдсэн ч уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага эцэг эх, хүүхдийн аль алинд нь хангалтгүй байна.

Хүснэгт 13. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлын үнэлгээний нэгтгэл

Төрөл	Эцэг эх			Хүүхэд		
	Мэдлэг <sup>(a)</sup>	Хандлага <sup>(b)</sup>	Дадал <sup>(c)</sup>	Мэдлэг <sup>(a)</sup>	Хандлага <sup>(b)</sup>	Дадал <sup>(c)</sup>
ХАХЭ	Дунд	Сайн	Дунд	Дунд	Дунд	Дунд
Бэлгийн мөлжлөг	Муу	Муу	Сайн	Муу	Муу	Сайн
Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн

Эх сурвалж: Өрхийн болон хүүхдийн асуумж судалгааны үр дүнд үндэслэсэн судалгааны багийн үнэлгээ

<sup>(a)</sup>Нийт бодомжид зөв хариулсан хувиар: 50%-иас доош=Муу; 51%-75%=Дунд; 76%-аас дээш=Сайн

<sup>(b)</sup>Нийт бодомжид санал нийлэхгүй байгаа хувиар: 50%-иас доош=Муу; 51%-75%=Дунд; 76%-аас дээш=Сайн

<sup>(c)</sup> Хохирогчийн талаар мэдэгдэх эсэх асуултын "заавал мэдэгдэнэ" гэсэн хариултын хувиар: 50%-иас доош=Муу; 51%-75%=Дунд; 76%-аас дээш=Сайн

Судалгааны үр дүнг дараагийн дэд бүлгүүдэд гэмт хэргийн төрөл тус бүрээр нарийвчлан танилцууллаа.

<sup>55</sup> Энд дадлын түвшинг зөвхөн нэг асуултаар тодорхойлсон тул мэдлэг, хандлагын нэгдсэн үр дүнтэй харьцуулаагүй болно.

### 3.1.1 Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага

#### Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, ойлголт:

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд ба хүүхдүүдийн талаас дээш хувь нь ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх мэдлэгээ “хангалтгүй” гэж үнэлж байна. Эцэг эхчүүдийн 20%, хүүхдүүдийн 15% ХАХЭ-ийн талаар өөрсдийгөө хангалттай мэдлэгтэй гэж дүгнэсэн бол эцэг эхчүүдийн 26%, хүүхдүүдийн 34% энэ талаарх ойлголтоо дундаж хэмээн үзжээ. Харин ХАХЭ-ийн талаар мэдээлэл байхгүй, энэ талаар ойлголтгүй гэж хариулсан хувь нь эцэг эхчүүдийн дунд 53%, хүүхдүүдийн 51%-ийг эзэлж байна (Зураг 19).

Эцэг эх ба хүүхдийн ХАХЭ-ийн мэдлэгийн өөрийн үнэлгээг харьцуулахад<sup>56</sup> уг хоёр бүлгийн хувьд статистикийн ач холбогдол бүхий, мэдэгдэхүйц ялгаа байхгүй бөгөөд эцэг эх, хүүхдүүд ХАХЭ-ийн талаарх мэдлэгээ бараг ижил түвшинд үнэлсэн байна. Тодруулбал, эцэг эхийн өөрийн үнэлгээ дунджаар 2.63 оноо<sup>57</sup>, хүүхдүүдийнх дунджаар 2.56 оноо байна.




Эцэг эхчүүдийн ХАХЭ-ийн талаарх мэдлэгийн өөрийн үнэлгээг тэдгээрийн хүйс, нас, зорилтот өрхөд хамаарагдах эсэх, байршил зэрэг үзүүлэлтээр харьцуулахад хүйс, зорилтот өрх, байршлын хувьд статистик ач холбогдол бүхий мэдэгдэхүйц ялгаа ажиглагдсангүй. Харин эцэг эхийн ХАХЭ-ийн талаарх мэдлэг насны бүлгээр ялгаатай бөгөөд нас ахих тусам эцэг эхийн мэдлэг нэмэгдэж байна. Ялангуяа 56 ба түүнээс дээш насны эцэг эхчүүд ХАХЭ-ийн талаарх мэдлэгээ дундаас дээгүүр үнэлсэн нь насны бүлгүүд дотроос хамгийн өндөр үнэлгээ аж (Хүснэгт 14).

Хүүхдүүдийн ХАХЭ-ийн талаарх мэдлэгийн үнэлгээний хувьд нас болон зорилтот өрхөд амьдардаг эсэхээс хамаарсан статистик ач холбогдол бүхий ялгаа байхгүй бол хүйсийн хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдлаа. Охидууд ХАХЭ-ийн талаарх мэдлэгээ хөвгүүдээс ялимгүй өндрөөр үнэлсэн байна (Хүснэгт 14).

<sup>56</sup> Хоёр бүлгийн хоорондох харьцуулалтыг нэг талт вариацийн шинжилгээгээр (ANOVA) хийв. Нэг талт вариацийн шинжилгээ нь тухайн хувьсагчийн дундаж утга өөр нэг хувьсагчийн категори (бүлэг) бүрд ялгаатай эсэхийг шалгадаг.

<sup>57</sup> Хамгийн өндөр оноо=5, хамгийн бага оноо=1, дундаж оноо=3

Эцэг эх, хүүхдүүдийн ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх анхан шатны мэдлэг дунд түвшинд байна. Өөрийн мэдлэгийн үнэлгээнээс гадна эцэг эх, хүүхдээс ХАХЭ-ийн талаарх анхан шатны мэдлэгийг шалгах зорилгоор таван бодомжоос<sup>58</sup> хариултыг сонгуулахад эцэг эхийн 66%, хүүхдүүдийн 57% 4-5 асуултад зөв хариулсан байна (Зураг 20). Эцэг эх ба хүүхдийн нийт зөв хариулсан дундаж асуултын тоогоор нь харьцуулахад эцэг эх таван бодомжоос дунджаар 3.46 (нийт бодомжийн 69%)-д зөв хариулсан бол хүүхдүүд дунджаар 3.31 (нийт бодомжийн 66%)-д зөв хариулжээ.<sup>59</sup> Асуулт бүрээр авч үзвэл эцэг эх, хүүхдийн олонх албадан хөдөлмөр эрхлэлтийг зөв тодорхойлсон бол харин хүүхдийн хөдөлмөр эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн насны талаар эцэг эх, хүүхдийн олонх буруу мэдээлэлтэй байдаг аж. Тухайлбал, эцэг эхийн дөнгөж 15%, хүүхдүүдийн 23% энэ талаар зөв хариулсан байна.



Хүснэгт 15-д ХАХЭ, түүний хэлбэрийн талаарх таван бодомжоос зөв хариулсан дундаж тоог судалгаанд оролцогчдын хүйс, нас, зорилтот өрхөд хамаарагдах эсэх, байршил зэрэг үзүүлэлтээр харьцуулахад байршлаас бусад үзүүлэлтүүдийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Харин хотын эцэг эхчүүдийн ХАХЭ-ийн талаарх мэдлэг хөдөөний эцэг эхчүүдийнхээс ялимгүй илүү байна. Хэдийгээр статистикийн хувьд ач холбогдолгүй ч ХАХЭ-ийн талаарх мэдлэг эцэг эх, хүүхдүүдийн наснаас хамаарч тодорхой зөрүүтэй байна. Тухайлбал, 56 ба түүнээс дээш насны эцэг эх, 17 настай хүүхдүүд ХАХЭ-ийн талаарх илүү олон асуултад зөв хариулжээ.

**Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн хандлага:** Эцэг эх, хүүхдүүдийн хандлагыг тодорхойлохдоо ХАХЭ-ийн ялгаатай хэлбэрүүдийг харуулсан дөрвөн сөрөг агуулга<sup>60</sup> бүхий бодомж асуухад эцэг эхчүүд дунджаар 3.11 (нийт бодомжийн 78%)-тай нь санал нийлэхгүй байгаа бол хүүхдүүд дунджаар 2.38 (нийт бодомжийн 60%)-тай нь санал нийлэхгүй байгаага илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл эцэг эхчүүдэд хүүхдээ албадан хөдөлмөр эрхлэлтэд өртөх эрсдэлээс хамгаалах хандлага суусан бол хүүхдүүдэд энэ талаарх хандлага төдийлөн хангалттай биш байна.

<sup>58</sup> Бодомж бүрийн зөв хариултын хувийг Хавсралт 7-оос харна уу.

<sup>59</sup> Гэхдээ энэхүү зөрүү нь вариацийн шинжилгээгээр статистикийн ач холбогдолгүй болох нь тогтоогдсон тул эцэг эх, хүүхдүүдийн ХАХЭ-ийн талаарх анхан шатны мэдлэгийг ижил түвшинд байна хэмээн дүгнэж болно.

<sup>60</sup> Сөрөг агуулга бүхий бодомжтой санал нийлэхгүй бол ХАХЭ-ийг дэмждэггүй хандлагатай гэж үзнэ.

Хүүхдүүдийн 72% сурахынхаа хажуугаар хөдөлмөр эрхэлж орлого олох сонирхолтой бөгөөд тэдгээрийн 58% нь 14-15 насныхан байна. Энэ нь тэдний хүүхдийн хөдөлмөр эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн насыг мэддэггүйтэй холбоотой юм.

Түүнчлэн дөрвөн хүүхэд тутмын нэг нь албадан хөдөлмөр эрхлэлтэд өртөх эрсдэлтэй байна. Тодруулбал, хүүхдүүдийн 22% өрхийн амьжиргаанд нэмэр болох үүднээс эрсдэлтэй байсан ч хөдөлмөр эрхэлнэ, 8% шаардлага гарвал эцэг эхэд мэдэгдэлгүйгээр цалин хөлсгүй ажиллана гэжээ<sup>61</sup> (Хүснэгт 16). Эдгээр эрсдэлт хүүхдийг нарийвчлан авч үзвэл эрэгтэй хүүхдүүд (56%), 14-15 насныхан (63%), зорилтот өрхийн хүүхдүүд (64%), хотод оршин суудаг хүүхдүүд (65%) давамгайлж байна. Түүнчлэн эдгээр хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг хэр байсныг эргэн харвал бүгд ХАХЭ-ийн талаар мэднэ гэж өөрийгөө үнэлэхийн сацуу олонх (73%) нь 3-аас дээш бодомжид зөв хариулжээ. Иймд эдгээр хүүхдийг ХАХЭ талаарх анхан шатны мэдлэгтэй ч энэ талаарх хандлага суугаагүй буюу албадан хөдөлмөр эрхлэх эрсдэлд орох магадлалтай хэмээн дүгнэж болохоор байна. Нөгөө талаас нийт хүүхдүүдийн ихэнх (65%-69%) амьдарч буй газар, орчинд нь албадан хөдөлмөр эрхлэх эрсдэл байхгүй гэж боддог бөгөөд энэ нь тэдний бодит эрсдэлд орох магадлалыг өсгөж болох юм.

Хүснэгт 16. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд

ХХГХ-ийн төрөл	Бодомж	Санал нийлж буй (%)		Санал нийлэхгүй хувь (%)	
		Эцэг эх	Хүүхэд	Эцэг эх	Хүүхэд
ХАХЭ	Хүүхэд өөрөө чадаж байвал багаасаа хөдөлмөр эрхлэх нь зөв	38	59	62	40
	Хэрэв хүүхэд чадаж байвал сурахын хажуугаар хөдөлмөр эрхэлж орлого олох нь зөв.	37	72	61	28
	Өрхийн амьжиргаанд нэмэр болж байвал эрсдэлтэй байсан ч хөдөлмөр эрхэлж болно.	6	22	93	78
	Өрхийн хэрэгцээнд мөнгө зээлсэн, таньдаг хүн гуйвал хүүхдийн/эцэг эхийн саналыг харгалзахгүйгээр цалин хөлсгүйгээр ажиллуулна/ажиллана.	4	8	95	92
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж оноо <sup>(a)</sup>			3.11	2.38
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж хувь			78	60

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)

Тэмдэглэгээ: <sup>(a)</sup>боломжит дээд оноо=4

### 3.1.2 Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага


**Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, ойлголт:** Судалгаанд хамрагдсан эцэг эх, хүүхдүүдийн олонх нь бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаарх мэдлэгээ дунд ба түүнээс доогуур үнэлжээ. Эцэг эхчүүдийн 21%, хүүхдүүдийн 29% бэлгийн мөлжлөгийн талаар өөрсдийгөө хангалттай мэдлэгтэй гэж дүгнэсэн бол эцэг эхчүүдийн 34%, хүүхдүүдийн 39% энэ талаарх ойлголтоо дундаж хэмээн үзжээ. Харин судалгаанд хамрагдсан эцэг эхийн 45%, хүүхдүүдийн 40% бэлгийн мөлжлөгийн талаар мэдэхгүй гэжээ (Зураг 21). Эцэг эх ба хүүхдийн өөрийн үнэлгээг хооронд нь харьцуулахад уг хоёр бүлгийн хувьд статистикийн ач холбогдол бүхий мэдэгдэхүйц ялгаа байхгүй бөгөөд эцэг эх, хүүхдүүд бэлгийн мөлжлөгийн талаарх мэдлэгээ бараг ижил түвшинд үнэлсэн байна. Тодруулбал, эцэг эхийн өөрийн үнэлгээ дунджаар 2.75 оноо<sup>62</sup>, хүүхдүүдийнх дунджаар 2.73

<sup>61</sup> Эдгээр хүүхдийн тоо нийтдээ 52 буюу судалгаанд хамрагдсан хүүхдийн 25% юм.

<sup>62</sup> Хамгийн өндөр оноо=5, хамгийн бага оноо=1, дундаж оноо=3



оноо байгаа бөгөөд ХАХЭ-ийн өөрийн үнэлгээтэй харьцуулахад эцэг эх ба хүүхдийн дундаж үнэлгээ харгалзан 0.12 ба 0.17 оноогоор тус тус өсжээ.




Эцэг эх ба хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх мэдлэгийн өөрийн үнэлгээг тэдгээрийн хүйс, нас, зорилтот өрхөд хамаарагдах эсэх, байршил зэргээр харьцуулахад бүх үзүүлэлтийн хувьд статистик ач холбогдол бүхий мэдэгдэхүйц ялгаа ажиглагдсангүй. Харин тоон утгаар нь авч үзвэл эцэг эхийн түүврийн хувьд эмэгтэйчүүд, 46-аас дээш насныхан, зорилтот бус өрхийн гишүүд мэдлэгээ харгалзах бүлгүүдээс өндрөөр үнэлжээ. Харин хүүхдүүдийн хувьд 15 настай хүүхдүүд, зорилтот бус өрхийн хүүхдүүд, хөдөөний хүүхдүүд мэдлэгээ харгалзах бүлгүүдээс өндрөөр үнэлсэн байна (Хүснэгт 18).

**Эцэг эх, хүүхдүүдийн бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаарх анхан шатны ойлголт хангалтгүй байна.** Эцэг эх, хүүхдээс бэлгийн мөлжлөгийн талаарх анхан шатны мэдлэгийг нь шалгах зорилгоор таван бодомжоос<sup>63</sup> хариултыг сонгуулахад эцэг эхийн 11%, хүүхдүүдийн 15% нь нэг ч асуултад зөв хариулаагүй бол эцэг эхийн 70%, хүүхдүүдийн 74% нь 1-2 асуултад л зөв хариулжээ (Зураг 22). Эцэг эх ба хүүхдийн нийт зөв хариулсан асуултын тоогоор нь харьцуулахад эцэг эх таван бодомжоос дунджаар 1.65 (нийт бодомжийн 30%)-д зөв хариулсан бол хүүхдүүд дунджаар 1.52 (нийт бодомжийн 33%)-д зөв хариулжээ. Эцэг эх (59%), хүүхдийн (61%) олонх бэлгийн мөлжлөгийг хүчиндэх гэмт хэрэгтэй адилтгаж ойлгодог байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн тэн хагас нь, хүүхдүүдийн 64% нь бэлгийн мөлжлөгийг ХХГХ-ээс тусдаа ойлголт хэмээн үздэг аж. Харамсалтай нь эцэг эхийн 45%, хүүхдүүдийн 47% нь бэлгийн мөлжлөгийг биеэ үнэлэх явдалтай адилтгаж байна.

<sup>63</sup> Бодомж бүрийн зөв хариултын хувийг Хавсралт 7-оос харна уу

Зураг 22. Бэлгийн мөлжлөг түүний хэлбэрийн талаарх таван бодомжид зөв хариулсан хувь



Хүснэгт 18. Бэлгийн мөлжлөг түүний хэлбэрийн талаарх таван бодомжноос дунджаар зөв хариулсан тоо<sup>(b)</sup>, хүйс, нас, зорилтот өрх, байршлын харьцуулалтаар

Үзүүлэлтүүд		Эцэг эх	Хүүхэд
Хүйс	Эр	1.46*	1.60
	Эм	1.73*	1.46
Нас <sup>(a)</sup>	24-35  14	1.95	1.71*
	36-45  15	1.65	1.30*
	46-55  16	1.53	1.71*
	56+  17	1.57	1.51*
Зорилтот өрх эсэх	Зорилтот өрх	1.66	1.40
	Зорилтот бус өрх	1.66	1.69
Байршил	Хот	1.77*	1.51
	Хөдөө	1.41*	1.57

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)  
Тэмдэглэгээ: <sup>(a)</sup>арын баганад хүүхдийн насыг тэмдэглэв. <sup>(b)</sup>хамгийн өндөр =5, хамгийн бага=0, дундаж=2.5  
\* p<0.1 буюу ач холбогдлын түвшин 0.1 үед статистикийн ач холбогдолтой

Хүснэгт 18-д бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаарх таван бодомжоос зөв хариулсан дундаж тоог судалгаанд оролцогчдын хүйс, нас, зорилтот өрхөд хамаарагдах эсэх, байршил зэрэг үзүүлэлтээр харьцуулахад эцэг эхийн хүйс ба байршил, хүүхдийн насны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа байна. Тодруулбал, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгийн талаарх үнэн зөв ойлголт эрэгтэйчүүдээс арай илүү, хотын эцэг эхчүүдийн мэдлэг хөдөөгийн эцэг эхчүүдээс ялимгүй илүү ажээ. Хүүхдүүдийн хувьд энэ талаарх мэдлэг наснаас хамаарч бага зэргийн ялгаатай байна. Статистикийн ач холбогдолгүй ч бусад бүлгийн дундаж зөв хариулсан тоог харьцуулахад 35-аас доош насны эцэг эх бусад насныхнаас арай олон асуултад зөв хариулсан бол хөвгүүд, зорилтот бус өрхийн хүүхдүүдийн зөв хариултын тоо харгалзах бүлэг дотроо үл ялиг өндөр байна. Гэхдээ аль ч бүлгийн хувьд дундаж зөв хариултын тоо хоёроос бага байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болох хүчин зүйлсийн талаар асуухад эцэг эхчүүд гэр бүлийн болон санхүүгийн хүчин зүйлсэд санал нэгдэж байсан бол хүүхдүүд найз нөхөд, цахим орчны нөлөөг илүүтэй онцолж байна. Тухайлбал, эцэг эх гэр бүлийн хараа хяналт сул байх нь хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртөхөд хамгийн ихээр нөлөөлнө гэсэн бол хүүхдүүд буруу хүнтэй найзлах нь хамгийн өндөр эрсдэл дагуулна гэж үзжээ. Доорх хүснэгтэд эцэг эх болон хүүхдээс хамгийн олон санал авсан бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болох таван хүчин зүйлийг эрэмбэлэн жагсаав.

Хүснэгт 19. Хүүхдийн бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй гол таван шалтгаан, эцэг эх болон хүүхдийн саналаар

Эрэмбэ	Эцэг эхийн санал	Хүүхдийн санал
I	Гэр бүлийн хараа хяналт сул байх	Буруу хүмүүстэй нөхөрлөх
II	Санхүүгийн хувьд эмзэг ядуу өрхийн хүүхэд байх	Өөрийн нууц мэдээллээ танихгүй хүнтэй хуваалцах Гэр бүлийн хараа хяналт сул байх
III	Буруу хүмүүстэй нөхөрлөх	Цахим орчинд танихгүй хүнтэй найз болох
IV	Хойд эцэг, эхтэй байх	Цахим орчинд өөрийн хувийн зураг, мэдээллээ ил тавих;
V	Цахим орчин дахь дарамт, сүрдүүлэгт өртөх	Цахим орчин дахь дарамт, сүрдүүлэгт өртөх

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)  
Тэмдэглэгээ: <sup>(b)</sup>боломжит дээд оноо=5

**Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх эцэг эх, хүүхдийн хандлага:** Эцэг эх, хүүхдүүдийн бэлгийн мөлжлөгийн талаарх анхан шатны ойлголт хангалтгүйгээс энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага мөн суугаагүй байна. Эцэг эх, хүүхдүүдийн бэлгийн мөлжлөгийн талаарх хандлагыг тодорхойлохдоо таван сөрөг агуулга<sup>64</sup> бүхий бодомж асуухад эцэг эхчүүд дунджаар 0.4 (нийт бодомжийн 8%)-тай нь санал нийлэхгүй байгаа бол хүүхдүүд дунджаар 0.5 (нийт бодомжийн 10%)-тай нь санал нийлэхгүй байгаагаар илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл эцэг эх, хүүхдүүдийн аль алинд бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг бодитоор үнэлэх хандлага байхгүй байна.

Эцэг эх, хүүхдүүдийн бараг 90 орчим хувь нь тодорхой бүлэгт хамаарагддаг хэсэг хүмүүсийг л бэлгийн мөлжлөгт илүү өртөнө гэсэн хандлагатай байна. Тодруулбал, эцэг эхийн хараа хяналт сул, эмзэг ядуу өрхөд амьдардаг, биеэ үнэлдэг хүн л бэлгийн мөлжлөгт өртдөг хэмээн тэд үзэж байна. Хэдийгээр эдгээр нь бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлт хүчин зүйл мөн ч тухайн хүний амьдралын түвшин, санхүүгийн нөхцөл байдлаас үл хамааран хэн ч өртөх боломжтой гэсэн хандлага оролцогчдын дунд төдийлөн бүрдээгүй байна. Харин бэлгийн мөлжлөгт зөвхөн эмэгтэй хүн л өртдөг гэж эцэг эхчүүдийн 28%, хүүхдүүдийн 22% үзжээ. Энэ нь нөгөө талаас судалгаанд оролцогчдын олонход хүний хүйснээс үл хамааран бэлгийн мөлжлөгт өртөж болно гэсэн хандлага байгааг илэрхийлж байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд

ХХГХ-ийн төрөл	Бодомж	Санал нийлж буй (%)		Санал нийлэхгүй хувь (%)	
		Эцэг эх	Хүүхэд	Эцэг эх	Хүүхэд
Бэлгийн мөлжлөг	Бэлгийн мөлжлөгт зөвхөн эмэгтэй хүн л өртдөг	28	22	71	77
	Бэлгийн мөлжлөгт эцэг эхийн хараа хяналт сул, эмзэг ядуу өрхийн хүүхдүүд л өртдөг.	90	86	10	14
	Биеэ үнэлдэг хүн л бэлгийн мөлжлөгт өртдөг.	88	86	8	12
	Биеэ үнэлэх нь хувь хүний ухамсар, төлөвлөөс хамаарна	88	88	11	11
	Бусдын ятгалга, сүрдүүлгээр биеэ үнэлэх явдал байдаг	88	86	11	13
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж оноо <sup>(b)</sup>			0.4	0.5
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж хувь			8	10

### 3.1.3 ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, хандлага

**Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголт:** Судалгаанд хамрагдсан эцэг эх, хүүхдүүдийн олонх хүүхдийн эсрэг үйлдэгдсэн ХХГХ, түүний хэлбэрийн талаарх мэдлэгээ дунд ба түүнээс доогуур үнэлжээ. Эцэг эхчүүдийн зөвхөн 8.5%, хүүхдүүдийн 11% хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаар өөрсдийгөө хангалттай мэдлэгтэй гэж дүгнэсэн бол эцэг эхийн 61%, хүүхдүүдийн 49% энэ талаар тодорхой ойлголт, мэдээлэлгүй, мэдэхгүй гэсэн хариулт өгчээ (Зураг 23). Эцэг эх ба хүүхдийн өөрийн үнэлгээг хооронд нь харьцуулахад статистикийн ач холбогдол бүхий мэдэгдэхүйц зөрүү ажиглагдсан бөгөөд хүүхдүүд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ талаарх мэдлэгээ эцэг эхээсээ өндөр түвшинд үнэлсэн байна. Тодруулбал, эцэг эхийн өөрийн үнэлгээ дунджаар 2.40 оноо<sup>65</sup>,

<sup>64</sup> Сөрөг агуулга бүхий бодомжтой санал нийлэхгүй бол бэлгийн мөлжлөгийн эрсдэлийг үнэн зөвөөр үнэлэх хандлагатай гэж үзнэ.

<sup>65</sup> Хамгийн өндөр оноо=5, хамгийн бага оноо=1, дундаж оноо=3

хүүхдүүдийнх дунджаар 2.57 оноо байгаа бөгөөд ХАХЭ ба бэлгийн мөлжлөгийн өөрийн үнэлгээтэй харьцуулахад эцэг эх ба хүүхдийн дундаж үнэлгээ тус тус буурсан байна.<sup>66</sup>



Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэгийн өөрийн үнэлгээг судалгаанд оролцогчдын хүйс, нас, байршил, зорилтот өрхөд хамаарагдах эсэхээр харьцуулахад зөвхөн эцэг эхийн насны бүлгүүдийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдлаа. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэгээ 56 ба түүнээс дээш насны эцэг эх хамгийн өндрөөр, харин 35 ба түүнээс доош насныхан хамгийн багаар үнэлжээ (Хүснэгт 21).


Эцэг эх, хүүхдүүдийн олонх хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх анхан шатны мэдлэг дунд түвшинд байна. Эцэг эх, хүүхдээс хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ талаарх анхан шатны мэдлэгийг нь шалгах зорилгоор зургаан бодомжоос<sup>67</sup> сонгуулахад эцэг эхийн 80.9%, хүүхдүүдийн 82.8% нь 4 ба түүнээс дээш асуултад зөв хариулжээ (Зураг 24).

Эцэг эх ба хүүхдийг нийт зөв хариулсан асуултын тоогоор нь харьцуулахад хүүхдүүд эцэг эхчүүдээс арай олон асуултад зөв хариулсан байна. Эцэг эх зургаан асуултаас дунджаар 4.08 (нийт бодомжийн 68%-д зөв хариулсан бол хүүхдүүд дунджаар 4.26 (нийт бодомжийн 71%-д зөв хариулжээ. Хэдийгээр нийт судалгаанд оролцогчид хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн төрлүүдийг зөв тодорхойлсон ч тэдгээрийн олонх (72%) "хүчээр бэлгийн харилцаанд орох" гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-д хамаарна хэмээн үзжээ.

<sup>66</sup> Эцэг эхийн үнэлгээ ХАХЭ-ээс 0.23-аар, бэлгийн мөлжлөгөөс 0.35-аар тус тус буурчээ. Хүүхдийн үнэлгээ ХАХЭ-ээс 0.01-ээр өссөн бол бэлгийн мөлжлөгөөс 0.16-аар буурчээ.

<sup>67</sup> Бодомж бүрийн зөв хариултын хувийг Хавсралт 7-оос харна уу

Зураг 24. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх зургаан бодомжид зөв хариулсан хувь



Хүснэгт 22. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх 6 бодомжноос дунджаар зөв хариулсан тоо<sup>(b)</sup>, хүйс, нас, зорилтот өрхийн харьцуулалтаар

Үзүүлэлтүүд		Эцэг эх	Хүүхэд	
Хүйс	Эр	4.14	4.23	
	Эм	4.06	4.29	
Нас <sup>(a)</sup>	24-35	14	4.05	4.12
	36-45	15	4.07	4.16
	46-55	16	4.14	4.53
	56+	17	4.00	4.38
Зорилтот эсэх	өрх	Зорилтот өрх	4.03	4.35
		Зорилтот бус өрх	4.11	4.20
Байршил	Хот	4.06	4.26	
	Хөдөө	4.14	4.26	

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)  
Тэмдэглэгээ: <sup>(a)</sup>арын баганад хүүхдийн насыг тэмдэглэв. <sup>(b)</sup>хамгийн өндөр =6, хамгийн бага=0, дундаж=3

Хүснэгт 22-д хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаарх зургаан бодомжоос зөв хариулсан дундаж тоог судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулахад бүх үзүүлэлтийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа байхгүй байна.

**Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага:** Эцэг эх, хүүхдүүдийн олонх ХХГХ-т мөн л тодорхой бүлэг хүмүүсийг өртдөг гэсэн хандлагатай байна. Эцэг эх, хүүхдүүдийн ХХГХ-ийн талаарх хандлагыг тодорхойлохдоо гурван сөрөг агуулга<sup>68</sup> бүхий бодомж асуухад эцэг эхчүүд дунджаар 0.9 (нийт бодомжийн 30%)-тай нь санал нийлэхгүй байгаа бол хүүхдүүд дунджаар 1.1 (нийт бодомжийн 37%)-тай нь санал нийлэхгүй байгаагаар илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл эцэг эх, хүүхдүүдийн аль алинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-т өртөх эрсдэлийг бодитоор үнэлэх хандлага төдийлөн бүрдээгүй байна.

Эцэг эх, хүүхдүүдийн 90 гаруй хувь нь эцэг эхийн хараа хяналт сул, эмзэг ядуу өрхөд амьдардаг, бэлгийн харилцаанд эрт орсон хүүхдүүдийг л ХХГХ-ийн хохирогч болно гэсэн бодолтой байна. Энэ нь эргээд ХХГХ-т өртөх эрсдэлийг дутуу үнэлдэг, уг асуудал өөрт болон гэр бүлийн гишүүдэд нь тохиолдохгүй гэсэн хандлагатайг харуулж байгаа юм (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх хандлага тодорхойлох бодомжууд

Төрөл	Бодомж	Санал нийлж буй (%)		Санал нийлэхгүй хувь (%)		
		Эцэг эх	Хүүхэд	Эцэг эх	Хүүхэд	
Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ	Хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-т зөвхөн эмэгтэй хүүхдүүд л өртдөг.	24	16	76	84	
	Эцэг эхийн хараа хяналт сул, эмзэг ядуу өрхийн хүүхдүүд л ХХГХ-т өртдөг.	93	91	6	9	
	Биеэ үнэлдэг, эрт бэлгийн харилцаанд орсон, хүүхдүүд л ХХГХ-т өртдөг.	92	81	5	18	
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж оноо <sup>(c)</sup>				0.9	1.1
	Нийт бодомжоос санал нийлээгүй дундаж хувь				30	37


Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)  
Тэмдэглэгээ: <sup>(c)</sup> боломжит дээд оноо=3

<sup>68</sup> Сөрөг агуулга бүхий бодомжтой санал нийлэхгүй бол хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн эрсдэлийг үнэн зөвөөр үнэлэх хандлагатай гэж үзнэ.

### 3.1.4 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зан үйл, дадал

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлөөс хамаараад эцэг эх, хүүхдүүдийн зан үйлд бага зэргийн ялгаа байна. Эцэг эх, хүүхдүүдийн аль аль нь бэлгийн мөлжлөг болон ХХГХ-т албадан хөдөлмөр эрхлэлтээс илүү ач холбогдол өгч байна. Тодруулбал, хүүхдийг албадан хөдөлмөрийн хохирогч болсныг мэдвэл эцэг эхийн 69%, хүүхдүүдийн 52% нь энэ талаар зохих газар нь мэдэгдэнэ гэж хариулсан бол энэ хувь бэлгийн мөлжлөг болон ХХГХ-ийн хувьд ойролцоогоор 20-иос (эцэг эхийн хувьд) 30%-иар (хүүхдийн хувьд) өсжээ.

Нөгөөтээгүүр ойролцоогоор гурван эцэг эх тутмын нэг, хоёр хүүхэд тутмын нэг албадан хөдөлмөрийн хохирогч болсон хүүхдийг мэдээлэхдээ эргэлзсэн, мэдээлэх шаардлагагүй хэмээн үзэж байгаа нь ХАХЭ-ийн талаарх дадал, зан үйл төдийлөн хангалттай биш байгааг харуулж байна. Харин бэлгийн мөлжлөгийн хувьд эцэг эхчүүдийн 14%, хүүхдүүдийн 19%, ХХГХ-ийн хувьд эцэг эхчүүдийн 13%, хүүхдүүдийн 16% хохирогчийг мэдээлэх талаар эргэлзсэн, мэдээлэх шаардлагагүй хэмээн үзэж байна. Энэ нь бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хохирогчдод туслах зан үйл эцэг эх, хүүхдийн олонход байгааг харуулж байна.



Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)

Хохирогчийн талаар мэдээлэхдээ гэмт хэргийн төрлөөс хамаараад хэнд түрүүлж мэдэгдэх нь мөн л ялгаатай байна. ХАХЭ-ийн хувьд судалгаанд оролцогчдын олонх хохирогчийг эцэг эх асран хамгаалагчдад нь мэдэгдэнэ гэсэн бол бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн тухайд цагдаад илүүтэй мэдэгдэнэ гэж хариулжээ. Иймд эцэг эхчүүдийн хувьд гэмт хэргийн үр дагавраас нь хамаараад ялгаатай хариу үйлдэл үзүүлэх хандлага ажиглагдаж байна.



Хүснэгт 24. Гэмт хэргийн хохирогчийн талаар мэдэгдэх гол талууд, хамгийн олон санал авсан эрэмбээр

Хамгийн олон санал авсан эрэмбээр	Эцэг эх		Хүүхэд	
	ХАХЭ	Бэлгийн мөлжлөг ба ХХГХ	ХАХЭ	Бэлгийн мөлжлөг ба ХХГХ
I	Эцэг эх, асран хамгаалагч	Цагдаа	Эцэг эх, асран хамгаалагч	Эцэг эх, асран хамгаалагч
II	Хүүхдийн тусламжийн 108 утас	Эцэг эх, асран хамгаалагч	Ангийн багш	Цагдаа
III	Цагдаа	Хүүхдийн тусламжийн 108 утас	Хүүхдийн тусламжийн 108 утас	Хүүхдийн тусламжийн 108 утас

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)

Эцэг эхчүүдийн дийлэнх нь албадан хөдөлмөр эрхлэлт (92%), бэлгийн мөлжлөг (97%), хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ээс (95%) урьдчилан сэргийлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцож байгаагүй аж. Ийм төрлийн ажиллагаанд оролцсон цөөн хэдэн эцэг эх хүүхдийн сургууль, хороо, цагдаагаас зохион байгуулсан сургалтад ихэвчлэн суусан байна. Эцэг эхчүүд энэ төрлийн гэмт хэргээс хүүхдээ хамгаалахын тулд хараа хяналтаа сайжруулах, хүүхэдтэйгээ нээлттэй ярилцаж ойлголцох, найз нөхдийг нь таньж мэддэг байхыг чухалчилж байна.

Эцэг эхтэй харьцуулахад хүүхдүүдийн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох явдал нь арай илүү байна. Тухайлбал, хүүхдүүдийн 10% нь албадан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой, 19% нь бэлгийн мөлжлөгтэй холбоотой, 10% нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй холбоотой сургалт үйл ажиллагаанд оролцож байжээ. Эдгээр хүүхдүүд цагдаагийн байгууллага, энэ чиглэлийн ТББ, сургуулийн зүгээс зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан байна.

### 3.1.5 Мэдээллийн эх сурвалжууд

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг эцэг эхчүүд зурагт, нийгмийн сүлжээнээс, харин хүүхдүүд нийгмийн сүлжээ, хичээлийн хөтөлбөрөөс голдуу авч байна. Эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг гэмт хэргийн төрлөөс үл хамааран зурагтаас (60 гаруй хувь), нийгмийн сүлжээнээс (60 орчим хувь), найз нөхдөөсөө (15 гаруй хувь) авдаг аж. Түүнчлэн 10 гаруй хувь нь бусад эх сурвалжаас буюу хорооны нийгмийн ажилтан, цагдаа, хүүхдийнхээ сургууль дээр зохион байгуулагддаг үйл ажиллагаануудаас энэ талаарх мэдээллийг авч байжээ (Зураг 27).

Хүүхдүүдийн хувьд гол мэдээллийн эх сурвалжаар нийгмийн сүлжээг нэрлэсэн байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 60 орчим хувь нь ХАХЭ, бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг нийгмийн сүлжээнээс авдаг гэжээ. ХАХЭ, бэлгийн мөлжлөгийн хувьд хичээлийн хөтөлбөр, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн тухайд зурагтын мэдээ дараагийн гол мэдээллийн эх сурвалжаар эрэмбэлэгджээ. ХАХЭ-ийн талаарх мэдээллийг нийгэм судлал, иргэний боловсролын хичээлээс, бэлгийн мөлжлөгийн талаарх мэдээллийг эрүүл мэнд, биологийн хичээлээс голдуу авдаг гэжээ. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдээллийг иргэний ёс зүйн боловсрол, нийгэм судлал хичээлээс авсан хэмээн хариулжээ. Нийт хүүхдүүдийн 17 орчим хувь нь бусад мэдээллийн эх сурвалжаас буюу эцэг эх, найз нөхөд, багш, эргэн тойрны хүмүүсийн ярианаас энэ талаарх мэдээллийг авч байжээ (Зураг 28).

Зураг 27. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авдаг эх сурвалжууд, эцэг эхийн хувьд



Зураг 28. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авдаг эх сурвалжууд, хүүхдүүдийн хувьд



Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Хүүхдийн асуумж (n=204)

Нөгөө талаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.6-д оюутан, сурагчдад хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар таниулах, ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах талаар тусгасан байдаг. Хэдийгээр ЕБС-ийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох сэдвүүдийг насны онцлогт тохируулан тодорхой хичээлүүдэд тусгасан ч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийг танин мэдэх, урьдчилан сэргийлэх талаар тухайлсан бүлэг сэдэв аль нэг хичээлд хараахан тусгагдаагүй байна. Холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр салбар бүрийн тухайлсан сэдвийг ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт багтаах нь цаг хугацаа болоод нөөцийн хувьд хязгаарлагдмал байдаг. Иймд тохиолдол шинжлэх замаар аливаа гэмт хэргийн төрөл, хэлбэрийг ялган таних агуулгыг ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгадаг талаар дурдаж байв.

#### Шигтгээ 16

... Тусгайлсан хүн худалдаалах гэмт хэргийн эсвэл бусад гэмт хэргүүдийн агуулгыг нэг бүрчлэн ЕБС-ийн сургалтын агуулгад тусгана гэхээр сургалтын цаг хүрэлцдэггүй. Иймд багш нар ерөнхий ойлголт мэдлэгээ өгөөд, дараа нь тохиолдол шинжлэх, жишээ тайлбарлах замаар тухайн хэргийг задалж, таниулдаг. Тухайлбал, авто тээврийн осол, хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлуудыг авч үзэх замаар тэдгээрийн төрөл, хэлбэрийг таниулна гэсэн санаа юм.

Боловсролын салбарын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагын хэсгээс

## 3.2 Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн ойлголт, мэдлэг

Төслийн суурь шалгуур үзүүлэлтийг тодорхойлох зорилтын хүрээнд төслийн зорилтот орон нутагт амьдарч буй эцэг эхчүүдийн хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэгийг тодруулсан.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль 4.1.1-4.1.6-д эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тодорхойлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг нарийвчлан тусгасан юм. Тус хуульд тусгаснаар, “эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг” эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд хэмээн тодорхойлсон байна. Чухамхүү дээр дурдсан эрсдэлт нөхцөл бол хүүхдийг аюултай, хамгаалагдаагүй орчин нөхцөлд байгааг илтгэн харуулах гол үзүүлэлт бөгөөд хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэг, аюулгүй хамгаалагдсан байдлын талаарх санал бодол, хэрэв хүүхэд эрсдэлт нөхцөлд амьдарч буй тохиолдолд хэн хамгаалах, хэрхэн хамгаалах, ямар хариу үйлчилгээ үзүүлэх талаар эцэг эхийн ойлголт, мэдлэгийг энд авч үзлээ.

**Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний талаарх мэдлэг, ойлголт:** Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг тодорхойлох асуултад судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 1/3 нь буюу 33.8% нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний талаар мэднэ гэж хариулсан бол 25% буюу дөрвөн эцэг эх тутмын нэг нь ерөнхийд нь сонсож байсан буюу сайн мэдэхгүй гэсэн хариулт өгчээ (Зураг 29).



Эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэгийг зорилтот ба зорилтот бус өрхөөр харьцуулж үзэхэд хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийн хувьд мэдэгдэхүйц ялгаа байна. Тухайлбал зорилтот 73 өрхийн 31.5% нь Сайн мэднэ, 35.6% нь дунд зэрэг, 32.9% нь Сайн мэдэхгүй гэсэн хариулт өгсөн бол, зорилтот бус өрхийн (n=131) 35.1% нь Сайн мэднэ, 44.3% нь дунд зэрэг мэднэ, 20.6% нь Сайн мэдэхгүй (12.3 хувиар илүү) гэсэн хариултыг өгсөн байна. Зорилтот ба зорилтот бус өрхийн хариултыг дундаж үзүүлэлтийн ялгаанд тулгуурлан харьцуулж үзсэнээр хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн мэдлэгт мэдэгдэхүйц ялгаа байгааг тодорхой харж болно.

Хүснэгт 25-өөс үзэхэд зорилтот өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийн дундаж (2.97) ерөнхий дундажаас 0.14 пунктээр, зорилтот бус өрхийн эцэг эхийн мэдлэг (3.19)-ийн дундаж үзүүлэлтээс 0.21 пунктээр тус тус бага байгааг харж болно.

Дээрх үр дүнг нарийвчлан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийн<sup>69</sup> талаар эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголттой байдлыг тодруулахад өмнөх үнэлгээнээс илүү тааруу үр дүнг харуулж байв. Хүснэгт 26-аас үзэхэд судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийг мэдэх байдлын дундаж 10.7% буюу нэн доогуур түвшинд байна.

**Хүснэгт 26. Эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийн талаарх мэдээлэлтэй байдал**

Үйлчилгээний төрлүүд	Сонсож байсан		Сайн мэднэ		Мэдэхгүй	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1. Хүүхэд хамгааллын зөрчилтэй холбоотой мэдээлэл хүлээн авах, кейсийг илрүүлэх, шалгах	53	26.0	24	11.8	127	62.3
2. Хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх	39	19.1	17	8.3	148	72.5
3. Түр хамгаалах, аюулгүй байдлыг хангах	89	43.6	38	18.6	77	37.7
4. Дэмжих, холбон зуучлах	43	21.1	13	6.4	148	72.5
5. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ	75	36.8	23	11.3	106	52.0
6. Гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээ	59	28.9	16	7.8	129	63.2
<b>Нийлбэрийн дундаж</b>	<b>59.7</b>	<b>29.3%</b>	<b>21.8</b>	<b>10.7%</b>	<b>122.5</b>	<b>60%</b>

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204)

Хариултын дунджийг тооцож үзэхэд хариулт өгсөн 3 өрх тутмын 2 нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийг мэдэхгүй байна. Тэр дундаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, дэмжих, холбон зуучлах үйлчилгээний талаар мэдэхгүй гэх хариулт илүү өндөр хувьтай (72.5%) байна.

Дээрх үр дүнгээр хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төрлүүдийн талаарх мэдлэг, ойлголт тун хангалтгүй байгаа боловч эцэг эхчүүдийн хувьд шаардлагатай нөхцөлд бусдын дэмжлэггүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг холбогдох газарт хандан өөрсдөө авч чадна гэж хариулах эцэг эхийн хувь үүнээс бага зэрэг өндөр байв. Тодруулбал, судалгаанд хамрагдсан нийт 204 өрхөөс 134 (65.7%) өрхийн эцэг эхчүүд хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө хандаад авч чадна гэж хариулсан бөгөөд үүнийг зорилтот ба зорилтот бус өрхөөр ялган авч үзэхэд 48 өрх буюу 35.8% нь зорилтот өрх, 131 өрх буюу 64.2% нь зорилтот бус өрхүүд байна. Тус хариултыг байршлаар харьцуулж үзэхэд хот, хөдөөд ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө авч чадна гэж хотын дүүргийн өрхийн 67.9%, сум, орон нутгийн өрхийн 32.1% нь тус тус хариулсан болно.

**Хүснэгт 27. Хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө авч чадна гэсэн хариулт/зорилтот өрхөөр**

	Тийм		Зорилтот өрх эсэх		Нийт
			Тийм	Үгүй	
Хүүхэд хамгааллын үйлчилгээг гаднын ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө авч чадна.	Тийм	тоо	48	86	134
		хувь	35.8%	64.2%	100.0%
	Үгүй	тоо	25	41	66
		хувь	37.9%	62.1%	100.0%
	Мэдэхгүй	тоо	0	4	4
		хувь	0.0%	100.0%	100.0%
Нийт	тоо	73	131	204	
	хувь	35.8%	64.2%	100.0	

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204)

Өрхийн асуумжид тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр өөрсдөө хандаж авах зорилтот өрхийн нөхцөл байдлыг үнэлэхэд суурь үзүүлэлтийн түвшин 35.8%-тай байна.

<sup>69</sup> Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа юм” 2016 оны 2 сарын 5-нд батлагдсан Хүүхэд хамгааллын хуулийн 2016/ 4.1.6-р зүйл

Тэдгээр эцэг эхчүүдээс шаардлагатай нөхцөлд нэн тэргүүнд хэнд эсвэл ямар байгууллагад хандаж хүүхэд хамгааллын үйлчилгээ авахыг тодруулахад дийлэнх нь нэн тэргүүнд цагдаа (57.8%) болон Хүүхдийн тусламжийн 108 утсанд (53.4%) мэдэгдэнэ гэж хариулсан байна (Зураг 30).

**Зураг 30. Хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учирсан нөхцөл байдлыг мэдвэл, хаана, хэнд хандаж хүүхэд хамгааллын туслалцаа авах талаар**



Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204), Тайлбар: Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хариултыг гурав хүртэлх сонголтын боломжтойгоор давхардсан хариултыг тооцсон тул хариултын нийлбэр 100%-тай тэнцэхгүй болно.

**Амьдарч буй орон нутгийнхаа хүүхэд хамгааллын нөхцөл байдлын талаарх мэдээлэлтэй байдал:** Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн ойлголт мэдлэгийг тодорхойлох судалгааны дараагийн үндсэн асуулт бол гэр бүлийн орчинд таны хүүхэд хэр зэрэг аюулгүй, хамгаалагдсан гэж үздэг болохыг тодруулсан. Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 65.2% нь хүүхэд амьдарч байгаа орон нутаг, гэр бүлдээ хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрээс хамгаалагдсан, аюулгүй гэж үзсэн бол 27% нь зарим талаар хамгаалагдсан, 7.8% хамгаалагдаагүй, аюултай нөхцөлд амьдардаг гэж хариулжээ. Уг үр дүнг хот, хөдөө болон зорилтот, зорилтот бус өрхөөр ялган [Зураг 31](#)-д харууллаа.

Зураг 31. Амьдарч буй орчинд хүүхэд тань хэр аюулгүй, хамгаалагдсан гэж үзэх вэ?/байршил, өрхийн байдлаар



Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204)

Дээрх үр дүнгээс үзэхэд амьдарч буй байршлаас хамаарч хүүхдийн аюулгүй, хамгаалагдсан байдлын талаарх эцэг эхчүүдийн санал бодолд ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, сум, орон нутагт амьдарч буй өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн аюулгүй байдал хангагдсан гэж хариулсан байр суурь илүү өндөр хувьтай (9.8%-иар илүү) байгаа бөгөөд эсрэг тохиолдолд хамгаалагдаагүй, аюултай нөхцөлд амьдарч байгаа гэсэн хариулт хот, дүүрэгт амьдарч буй өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хувьд илүү өндөр (2.3%) байна.

Тухайн зурагт харуулснаар сум орон нутагт зорилтот өрхийн эцэг эхийн зүгээс хүүхдээ хамгаалагдсан, аюулгүй орчинд амьдарч байгаа гэж үзсэн хувь бага, гэхдээ дүүрэг/хот сууринд амьдарч зорилтот ба зорилтот бус өрхийн эцэг эхийн санал бодлоос аль алианаас нь илүү өндөр хувьтай байна. Хамгаалагдаагүй аюултай гэж үзсэн хувь хэмжээ зорилтот өрхүүдийн хувьд мөн өндөр байгаа нь орлого бага, эмзэг бүлгийн өрхүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх, анхаарах, чадавхжуулах нь нэн чухал болохыг давхар харуулж буй хэрэг юм.

Хүүхэд хамгааллын тухай хуульд (2-р бүлэг) гэр бүл, нийгэм, боловсролын салбар, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл цахим орчин болон олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ зэрэг таван чиглэлд хүүхдийг хамгаалах талаар нарийвчлан зааж өгсөн. Үүний дагуу судалгаанд хамрагдсан өрхийн эцэг эхээс хэрэв хүүхдийн амьдарч буй орчинд аюул эрсдэл бий гэж үзэж байгаа бол дараах орчны алинд нь илүү эрсдэлтэй болох талаар тодруулахад дийлэнх нь хариулт өгөөгүй эсвэл хариулахаас татгалзсан ба хариулт өгсөн эцэг эхийн дийлэнх нь цахим орчинд (18%) болон амьдарч буй гудамж талбайд (18%) эрсдэлд орох магадлал өндөр байдаг гэж хариулжээ (Хүснэгт 28).

Хүснэгт 28. Орчны эрсдлийн түвшин, %

Орчин	Бага	Их	Хариулахаас татгалзсан	Нийт
Гэр бүлийн орчинд	31.9	2.9	65.8	100%
Сургуулийн орчинд	19.1	15.7	65.2	100%
Амьдарч буй гудамж талбайд	16.7	18.1	65.2	100%
Интернэт, цахим орчинд	16.7	18.1	65.2	100%
Бусад/олон нийт г.м/	21.6	9.8	68.6	100%

Эх сурвалж: Өрхийн асуумж (n=204)

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.8-д зааснаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, оюун санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг тооцохоор заасан. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд таны амьдарч буй сум, хороонд эрх нь зөрчигдсөн болон хүчирхийлэлд ямар нэг хэлбэрээр өртсөн, аюултай нөхцөлд байгаа хүүхдүүд байгаа эсэх талаар тодруулсан. Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын үзсэнээр хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн хүүхэд байдаг гэж 14.7%, гэмт хэрэг зөрчлийн хохирогч болсон



хүүхэд байдаг гэж 12.7%, хурдны морь хөлсөөр унуулдаг 12.3%, сургуулиас завсардуулж, ажиллуулж байгаа хүүхэд байдаг гэж 7.8% нь хариулжээ (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Амьдарч буй орон нутагт нь эрх нь зөрчигдсөн, аюултай нөхцөлд амьдарч буй хүүхдүүд байдаг эсэх, %

	Байршил	Байхгүй		Байгаа		Мэдэхгүй	
		Зорилтот	Зорилтот бус	Зорилтот	Зорилтот бус	Зорилтот	Зорилтот бус
1. Хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн	Хот	75.9	81.4	13.0	8.1	11.1	10.5
	Хөдөө	68.4	57.8	21.1	26.7	10.5	15.6
	Нийт	73.5 (150)		<b>14.7 (n=30)</b>		11.8 (24)	
2. Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон	Хот	75.9	83.7	11.1	5.8	13.0	10.5
	Хөдөө	84.2	62.2	15.8	26.7	0.0	11.1
	Нийт	77.0 (157)		<b>12.7 (n=26)</b>		10.3 (10.3)	
3. Гэрээсээ хөөгдсөн, зугтсан	Хот	90.7	89.5	7.4	4.7	1.9	5.8
	Хөдөө	89.5	77.8	10.5	4.4	0.0	17.8
	Нийт	87.3 (178)		<b>5.9 (n=12)</b>		6.9 (14)	
4. Сургуулиас нь завсардуулж ажиллуулж байгаа	Хот	83.3	93.0	13.0	2.3	3.7	4.7
	Хөдөө	89.5	71.1	5.3	13.3	5.3	15.6
	Нийт	85.3 (174)		<b>7.8 (n=16)</b>		6.9 (14)	
5. Хүүхдээрээ албадан хөдөлмөр эрхлүүлдэг	Хот	88.9	93.0	5.6	2.3	5.6	4.7
	Хөдөө	100.0	88.9	0.0	4.4	0.0	6.7
	Нийт	91.7 (187)		<b>3.4 (n=7)</b>		4.9 (10)	
6. Хүүхдээрээ гуйлга гуйлгадаг	Хот	90.7	95.3	3.7	1.2	5.6	3.5
	Хөдөө	100.0	95.6	0.0	0.0	0.0	4.4
	Нийт	94.6 (193)		<b>1.5 (n=3)</b>		3.9 (8)	
7. Хүүхдийн биеийг нь үнэлүүлсэн	Хот	92.6	94.2	1.9	1.2	5.6	4.7
	Хөдөө	100.0	91.1	0.0	0.0	0.0	8.9
	Нийт	93.6 (191)		<b>1.0 (n=2)</b>		5.4 (11)	
8. Хурдны морь хөлсөөр унуулдаг	Хот	87.0	88.4	11.1	4.7	1.9	7.0
	Хөдөө	78.9	64.4	21.1	24.4	0.0	11.1
	Нийт	81.9 (167)		<b>12.3 (n=25)</b>		5.9(12)	

Хүснэгт 29-ээс үзэхэд хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлийн хохирогч болох явдал хот, хөдөө аль алинд байгаа боловч байршлын онцлогтой холбоотойгоор хүчирхийллийн тохиолдол болон хурдны морь хөлсөөр унуулах явдал хөдөө, орон нутагт өндөр хувьтай байгаа гэж зорилтот бус өрхийн эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдсэн юм. Тэрчлэн хотод амьдарч буй зорилтот өрхийн эцэг эх, асран хамгаалагчид хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн, сургуулиас нь завсардуулж, ажиллуулах тохиолдол байдаг гэж 13% нь тэмдэглэжээ.

## ДҮГНЭЛТ

Өмнөх бүлгүүдэд дурдсан судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх (1) тогтолцооны нөхцөл байдал болон (2) ХХГХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, зан үйл гэсэн хоёр үндсэн бүлгийн хүрээнд дараах гол дүгнэлтүүдийг хийж байна:

### НЭГ. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ:

#### 1.1 Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд тогтолцооны оролцогч байгууллагуудын авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дийлэнх нь төрийн албан хаагчдад чиглэсэн ХХГХ, албадан хөдөлмөр, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн асуудлаар олон улсын туршлага судлах, мэдээлэл зөвлөгөө өгөх, чадавх бэхжүүлэх сургалт, олон нийт рүү чиглэсэн нөлөөлөл, сурталчилгаа хэлбэрээр хэрэгжиж байна. Талуудын оролцоог авч үзвэл, энэ чиглэлд төр, төрийн бус, ОУБ-уудын оролцоо харилцан ижил түвшинд байгаа боловч авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоо дутмаг, нэгдсэн удирдлага зохион байгуулалтгүй, хоорондын хамтын ажиллагаа хангалттай түвшинд явагдаж чадахгүй байна.
- Олон улсын байгууллагуудын хувьд зөвхөн хууль эрх зүйн орчныг сайжруулахад анхаарч иржээ. Энэ нь нэг талаас санхүүжилтийн боломж болон төсөл хөтөлбөрүүд хумигдаж байгаа, нөгөө талаар төсөл хөтөлбөрөө өөрсдөө хэрэгжүүлэх болсон нь цаашдын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болохоор байна. Учир нь ТББ-уудын хувьд тогтвортой төсөв санхүү дутмаг, ихэвчлэн төсөл хөтөлбөр хэлбэрээр санхүүжилт босгодог тул ОУБ-ын санхүүжилтээс “хараат” байдалтай байна.
- Хүүхдийг ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх ТББ-уудын үйл ажиллагааг авч үзэхэд иргэд, олон нийтэд илүү хүртээмжтэй, тодорхой, шинэлэг арга барилтай байгаа нь урьдчилан сэргийлэх чиглэлээр үзүүлж буй олон тооны үйл ажиллагаанаас харагдаж байсан юм.
- Сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг үйлдэж буй ХХГХ-тэй тэмцэх төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлж, тогтолцоо харьцангуй сайжирч байгаа боловч мэргэшсэн хүний нөөцийг бий болгох, чадавхжуулах, санхүүжилтийн уян хатан бодлого, үр дүнтэй хамтын ажиллагаа дутмаг хэвээр байна. Мөн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд үнэлгээ хийх, хэмжих ажил хэрэгждэггүй байдал ажиглагдав. Тодруулбал энэ төрлийн ажлыг хэдэн хүнд, хичнээн удаагийн сургалт зохион байгуулсан эсэх явцын тоон шалгуураар хэмжихэд хүрч буй нь эцсийн үр дүнг үнэлж, туршлага сургамжаа эргэн дүгнэж чадахгүй байх дутагдалтай байна.
- ХХГХ-ийг таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллийг бэлтгэх, тархаахдаа иргэдийн бүлгийн онцлог, тусгай хэрэгцээ зэргийг харгалзах байдал хангалтгүй байна. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэр дундаа сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд бэрхшээлийнхээ онцлогоос шалтгаалан бүх төрлийн мэдээ мэдээллээс хоцрох эрсдэл өндөр, улмаар мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан гэмт хэргийн хохирогч болох, хохирсон ч тусламж дэмжлэг авч чадахгүй байх тохиолдлууд гарч байна.

#### 1.2 Хохирогч хамгааллын чиглэлээр:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалал, тэр дундаа хохирогч хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Монгол Улс нь олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээний хэм хэмжээнд нийцүүлэх ажил хангалттай хийгдсэн. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг үнэ төлбөргүй байна гэж заасан хэдий ч энэ хэрэгждэггүй. Тус хуулийг даган гарах “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хохирогчийн

нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, “Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох” аргачлал хоёр өнөөг хүртэл гаргаагүй байна.

- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэсэн тодорхойлолтын агуулга, хийдлийн зөрүүг арилгах шаардлагатай байна.** 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хохирогч гэдгийг тусгайлан анх удаа хуульчилсан. Энэ нь бусад эрх зүйн баримт бичигт тусгагдсанаас илүү өргөн хүрээнд тодорхойлогдсон байна. Тухайлбал, хохирогчоор тогтоогдсоноос үл хамааран ХХГХ-т хэрэгт өртсөн хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн нь хохирогчдод ээлтэй зохицуулалт гэж үзэж болно. Гэхдээ хамгаалалтад орж чадахгүй хохирогчид байсаар байна.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээнд хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг тусгайлан зохицуулах хэрэгцээ үүсжээ.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд 5 төрлийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх зохицуулалттай. Гэсэн хэдий ч эдгээр үйлчилгээг өнөөг хүртэл ТББ-ууд, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хохирогч нарт үйлчилгээ үзүүлж байна. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь анхан шат, нөхөн сэргээх, холбон зуучлах гэсэн үйлчилгээний төрөлтэй байна. Нөхөн сэргээх үйлчилгээг Талита Ази, ХЭҮТ, ХТЭТ зэрэг байгууллага үзүүлдэг ба дэргэдээ нэг хоногоос гурван жил хүртэл байрлуулдаг хамгаалах байр ажиллуулдаг байна. Харин эдгээр байгууллагуудад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд үзүүлэх үйлчилгээний зохицуулалт хангалтгүй байлаа.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын нийтлэг стандартыг шинэчлэн сайжруулах шаардлага бий болжээ.** 2013 онд батлагдсан стандарт нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний орчин, чанарыг тогтоосон хэдий ч стандартыг хамрах хүрээ нь зөвхөн төрийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагад үйлчлэх хязгаарлагдмал хүрээнд зохицуулагджээ. Тиймээс стандартын хамрах хүрээг өргөтгөх, мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах, түүнд үзүүлэх үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн стандартыг сайжруулах хэрэгцээ үүссэн байна.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал нь хүүхдэд ээлтэй бус байна.** ХХГХ-ийн улмаас бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, хохирогч хамгааллын тогтолцоо хангалтгүй байна. Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ хэрэгжиж байгаа хэдий ч энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүүхэд хамгаалал, үйлчилгээ байхгүйн зэрэгцээ түүнд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд мэргэжлийн бус байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдийг эрүүл мэндийн байгууллагад хандуулах тохиолдолд нарийн мэргэжлийн үйлчилгээ хэрэгцээтэй тул тэдгээр нь бүгд үнэ төлбөртэй байдаг байна. Тухайлбал, дотуур үзлэг, оношилгоо, сэтгэл зүйн заслын үйлчилгээ гэх мэт.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, илрүүлэх ажиллагаанд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хүний нөөц бэлтгэгдээгүй байна.** Үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай уулзахад дийлэнх нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, таньж тогтооход хүндрэлтэй байдаг ба хохирогчийг илрүүлэх чиглэлээр тусгайлсан сургалтад хамрагдаж байгаагүй байна. Тиймээс хохирогчийг илрүүлэх, таньж тогтоох арга зүйн сургалтад хамруулах шаардлагатай байлаа.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд шаардлагатай, дэмжлэг тусалцаанд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөл тусгай бие даасан хүүхдийн төрөлжсөн хамгаалах байрыг санал болгохын зэрэгцээ урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ үүссэн байна.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхэдтэй ажиллахад урт хугацаа буюу гурваас дээш жил шаардлагатай байдаг. Урт хугацааны үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага байхгүйтэй адил байна.

- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах хэрэгцээ үүссэн байна. Одоогоор үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнууд мэргэжлийн бус, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчгүй байгууллага байсаар байна. Орон нутагт ажиллаж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд мэргэжлийн бус учраас хүүхэд хамгаалал тэр дундаа үйлчилгээний асуудал орхигдох, хяналтгүй байна. Үйлчилгээ үзүүлэгч ТББ-аас төрийн байгууллага руу шилжүүлсэн кейсийн шийдвэрлэлт, эргэх холбоо байдаггүй.

### 1.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:

- Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг болон хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн гаралт өсөхийн зэрэгцээ хохирогч хүүхдийн тоо мөн тогтвортойгоор өсөх хандлагатай байна. Ялангуяа хүн худалдаалах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэгт хүүхэд хохирох явдал нэлээдгүй байна.
- Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ-ийн зохицуулалт нь Палермогийн протоколын тодорхойлолттой агуулгын хувьд нийцсэн боловч Эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан. Тодруулбал, Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр болох бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, хүний цус, эс, эд эрхтнийг хууль бусаар авах, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд худалдах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг үйлдлийг давхардуулан хуульчилсан нь мөрдөн шалгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших боломжийг бий болгосон гэж дүгнэж байна.
- Төлбөрийн чадваргүй насанд хүрээгүй хохирогч өмгөөллийн туслалцаа авч чадахгүй нөхцөл байна. Монгол Улс төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргасан боловч өнөөдрийг хүртэл төлбөрийн чадваргүй хохирогч, ялангуяа хохирогч хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалтгүй байсаар байна.
- Цагдаагийн байгууллагын эрүүгийн болон мөрдөн байцаах албаны бүтцэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх нэгж байгуулагдсан ч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хариуцсан албан тушаалтан байхгүй байна. Цагдаагийн байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх чиглэлээр тус тус нэг нэгж бие даан үйл ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай байна. Гэвч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад ийм албан тушаалтан байхгүй байна.

### 1.4 Хамтын ажиллагааны чиглэлээр:

- Судалгаанд хамрагдсан төр, төрийн бус, олон улсын байгууллагуудын хувьд хамтын ажиллагааны зарим тогтсон хэлбэрүүд хэдийнээ бий болсон ч хангалттай хэмжээнд биш байна. Нийт судалгаанд хамрагдсан байгууллагын 36% нь хамтран ажиллахдаа харилцан ойлголцлын санамж бичгийн үндсэн дээр хоорондоо хамтарч ажилладаг бол 60% нь ямар нэг гэрээ, санамж бичиг үйлддэггүй байна.
- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлд бүх талуудын хамтран ажиллах сонирхол, санаачилга сайн бөгөөд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд талуудын хамтын ажиллагаа харьцангуй сайн байна. Төр, төрийн бус, ОУБ-ын төлөөллөөс ХХГХ-тэй тэмцэхэд чиглэсэн ажлуудаас ямар төрлийн ажлуудад хамтын ажиллагаа илүү идэвхтэй явагддаг талаар

тодруулахад бүх талуудын хувьд урьдчилан сэргийлэх чиглэлийн хамтын ажиллагааг эерэгээр үнэлсэн юм.

- Харин эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хохирогч байж болзошгүй хүүхдийг эрт илрүүлэх чиглэлд талуудын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Төр, ТББ хоорондын хамтын ажиллагааны хувьд байгууллагуудын мэдээлээ солилцох, харилцан уялдаатай ажиллах байдал сул байна.
- ОУБ-ын хувьд хохирогчийг хамгаалах болон хохирогчид нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг бусад төр, ТББ-аас доогуур үнэлгээ өгсөн байна. Энэ нь хамтын ажиллагааны механизм бүрдээгүй, хууль тогтоомж болон хэрэг илрүүлэлт хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл хангалтгүй зэрэгтэй холбоотой байна.
- Түүнчлэн хамтран ажиллахад төрийн бус байгууллага бэрхшээл багатай байхад төрийн байгууллагатай ажиллахад олон талын хүндрэл учирдаг болохыг тэмдэглэжээ. Үүнийг төрийн институцийн шаталсан бүтэц болох процесстой холбон тайлбарлаж байна.
- Хохирогчийг хамгаалах талаарх хууль тогтоомж иргэд олон нийт, хуульчдын хувьд нэг мөр болоогүй, мэдээлэл ил тод биш байгаа нь байгууллага хоорондын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

## **ХОЁР. ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛ**

### **2.1 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн мэдлэг, ойлголт:**

- Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг дунд түвшинд байна. Судалгаанд хамрагдсан эцэг эх, хүүхдүүдийн талаас дээш хувь хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх, түүний хэлбэрийн талаар ойлголт бага байсан. Эцэг эхийн ХАХЭ-ийн талаарх мэдлэгийн түвшин тэдний байршлаас хамаарч зөрүүтэй байгаа бөгөөд хотын эцэг эхчүүд орон нутгийн эцэг эхчүүдээс илүү мэдээлэлтэй байна. Эцэг эх, хүүхдүүдийн олонх хүүхдийн хөдөлмөр эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн насны талаар ташаа мэдээлэлтэй байна.
- Хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх, түүний илрэх хэлбэрүүдийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг хангалтгүй буюу муу түвшинд байна. Эцэг эхчүүдийн 45%, хүүхдүүдийн 40% бэлгийн мөлжлөг, түүний хэлбэрийн талаар ойлголтгүй байгаагаа илэрхийлсэн. Эцэг эхийн энэ талаарх мэдлэг тэдний хүйс, байршлаас хамаарч ялгаатай байгаа бол хүүхдүүдийн хувьд наснаас хамаарч мэдлэгийн зөрүү байна. Тодруулбал, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгийн талаарх мэдлэг арай илүү байгаа бол хотын эцэг эхчүүд хөдөөгийн эцэг эхчүүдээс мэдээлэл сайтай байна. Эцэг эх, хүүхдүүдийн дунд нийтлэг ажиглагдсан асуудал бол бэлгийн мөлжлөгийг хүчиндэх гэмт хэрэг, биеэ үнэлэхтэй адилтгаж ойлгох явдал байна. Түүнчлэн бэлгийн мөлжлөгийг ХХГХ-д хамрагдахгүй гэж олонх нь үзэж байна.
- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдүүдийн мэдлэг дунд түвшинд байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 61%, хүүхдүүдийн 49% хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийн талаар ойлголтгүй гэж хариулсан.

### **2.2 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн хандлага:**

- Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эцэг эхчүүдийн хандлага сайн, харин хүүхдүүдийн хандлага дунд түвшинд байна. Эцэг эхчүүд хүүхдээр албадан хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжихгүй байгаа бол хүүхдүүдийн хандлага эцэг эхээс өөр байна. Хүүхдүүд хөдөлмөрийн насанд хүрсэн эсэхээс үл хамааран хичээлийнхээ хажуугаар ажил хийх сонирхолтой байна. Дөрвөн хүүхэд тутмын нэг нь эрсдэлтэй байсан ч, шаардлага

гарвал эцэг эхэд мэдэгдэлгүйгээр ажил хийнэ гэдгээ илэрхийлсэн. Нөгөөтээгүүр хүүхдүүд амьдарч буй газар, орчинд нь албадан хөдөлмөр эрхлэх эрсдэл байхгүй гэж боддог нь албадан хөдөлмөрийн талаарх эрсдэлийг бодитоор үнэлж чадахгүй байгааг харуулж байна.

- **Бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эцэг эх, хүүхдүүдийн хандлага хангалтгүй (муу) байна.** Эцэг эх, хүүхдүүдийн аль аль нь тодорхой бүлэгт хамаарагдах хэсэг хүмүүсийг л бэлгийн мөлжлөгт илүү өртөх эрсдэлтэй гэсэн итгэл үнэмшилтэй байна. Тодруулбал, эцэг эхийн хараа хяналт сул, эмзэг ядуу өрхөд амьдардаг, биеэ үнэлдэг хүн л бэлгийн мөлжлөгт өртдөг гэж үзэж байна.
- **Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, хүүхдүүдийн хандлагыг хангалтгүй (муу) байна.** Эцэг эх, хүүхдүүдийн олонх ХХГХ-т мөн л тодорхой бүлэг хүмүүсийг өртдөг гэсэн хандлагатай байна.

### 2.3 Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх эцэг эх, хүүхдийн зан үйл:

- **Хүүхдийн албадан хөдөлмөрлүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эцэг эх, хүүхдүүдийн зан үйл дунд түвшинд, харин бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн хувьд сайн гэж дүгнэж болохоор байна.** Эцэг эх, хүүхдүүдийн аль аль нь бэлгийн мөлжлөг болон ХХГХ-т албадан хөдөлмөр эрхлэлтээс илүү ач холбогдол өгч, хариу үйлдэл үзүүлэхээ илэрхийлжээ.

### 2.4 Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн мэдлэг ойлголт

- **Төслийн зорилтот орон нутаг дахь эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголт-(33.8%) хангалтгүй байгаагаас хамаарч шаардлагатай нөхцөлд бусдын дэмжлэггүйгээр тусламж дэмжлэг авах чадвартай зорилтот өрхийн тоо, хэмжээ мөн доогуур түвшинд байна.** Судалгаанд хамрагдсан зорилтот өрхийн ердөө 35.8% буюу гурван өрх тутмын нэг нь бусдын дэмжлэггүйгээр шаардлагатай нөхцөлд хүүхэд хамгааллын үйлчилгээг өөрсдөө хандаж авч чадна гэж үзсэн байна.
- **Зорилтот ба зорилтот бус өрхийн хариулыг дундаж үзүүлэлтийн ялгаанд тулгуурлан харьцуулж үзсэнээр хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн мэдлэгт мэдэгдэхүйц ялгаа байна.** Тухайлбал, зорилтот өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийн дундаж (2.97) ерөнхий дунджаас (0.14) пунктээр, зорилтот бус өрхийн эцэг эхийн мэдлэг (3.19)- ийн дундаж үзүүлэлтээс (0.21) пунктээр тус тус бага байна.
- **Эцэг эхчүүд гэр бүлийн орчинг хамгийн эрсдэл багатай эсрэгээр цахим орчин болон амьдарч буй гудамж талбайг хүүхдийн аюулгүй байдалд хамгийн эрсдэлтэй орчинд тооцож байна.** Энэ үзүүлэлтэд байршлын ялгаа ажиглагдсан ба сум, орон нутагт амьдарч буй өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн аюулгүй байдал хангагдсан гэж хариулсан байр суурь илүү өндөр хувьтай (9.8%-иар илүү) байгаа бөгөөд эсрэг тохиолдолд хамгаалагдаагүй, аюултай нөхцөлд амьдарч байгаа гэсэн хариулт хот, дүүрэгт амьдарч буй өрхийн эцэг эх, асран хамгаалагчдын хувьд илүү өндөр (2.3%) байна.
- **Ерөнхийд нь авч үзэхэд хүүхдийн эрхийн талаар амьдарч буй орон нутагт гарсан зөрчлийн талаар зорилтот өрхийн эцэг эхийн мэдээлэх байдал зорилтот бус өрхийн эцэг эхийн мэдээлэх байдлаас харьцангуй доогуур байгаа болно.** Хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учирсан тохиолдолд цагдаад хандаж туслалцаа авна (57.8%), хүүхдийн тусламжийн 108 утсанд хандаж туслалцаа авна (53.4%) зэрэг хариулт хамгийн өндөр хувьтай байна. Үүний хамт эцэг эх асран хамгаалагчдад (25.5%), баг, хорооны нийгмийн ажилтан (23.0), сургуулийн нийгмийн ажилтанд (19.1%) хандаж хүүхэд хамгааллын туслалцаа авахаа илэрхийлсэн байна. Тус хариултын дотор хамаатан садандаа хандах (8.8%), найз нөхөд хамт олондоо (2.0), хөрш саахалт айлд (1.5) тус тус хандана гэх мэт буруу хариулыг өгсөн байв.
- **Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг мэдэх байдлын дундаж (10.7%) буюу нэн доогуур түвшинд байна.** Мөн дэмжих холбон зуучлах



мэднэ (6.4%), мэдэхгүй (72.5%) хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх мэднэ (8.3%), мэдэхгүй (72.5%) гэр бүлд нь эргэн нэгтгэх мэднэ (7.8%), мэдэхгүй (63.2%) зэрэг хариу үйлчилгээний талаарх мэдлэг, ойлголт ихээхэн доогуур байна.

## 2.5. Төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн суурь шалгуур үзүүлэлт

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн урьдчилан сэргийлэх болон хохирогч хамгаалал бүлгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход:

- (1) Хохирогч хамгааллын бүлгийн хилийн хяналт, шалгалтаар илэрсэн ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоо (2) Хилийн хяналт шалгалтаар илэрч үйлчилгээний байгууллагад холбон зуучилсан ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй хүүхдийн тоо албан ёсоор бүртгэгдээгүй байна. Хил хамгаалах албаны албан хаагчдад ХХГХ-тэй тэмцэх талаар сургалт ордог хэдий ч бодит байдалд төдийлөн энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал үүсдэггүй гэдгийг ганцаарчилсан ярилцлагын үеэр мөн дурдаж байсан. Хэрвээ энэ төрлийн сэжигтэй тохиолдол илэрвэл цагдаагийн байгууллагад дамжуулах үүргийг хүлээдэг баг ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, эрт илрүүлэх, цааш холбогдох байгууллагад холбон зуучлах чиглэлээрх зохицуулалт зөвхөн хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмаар хязгаарлагдаж байна.
- Хохирогч хамгаалал, ХХГХ-ийн хохирогчид чиглэсэн үйлчилгээний хувьд тогтмол байдлаар үйлчилгээ үзүүлж байгаа нь Талита Ази, ХТЭТ, ХЭҮТ ТББ-ууд байна. Эдгээр байгууллагын хамгаалах байранд сүүлийн 4 жилийн хугацаанд урт болон богино хугацаанд үйлчилгээ авсан хохирогчдын тоонд үндэслэн суурь судалгааны хохирогч хамгааллын бүлгийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Ингэхдээ урт болон богино хугацааны үйлчилгээг Стандартчилал хэмжил зүйн газраас гаргасан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартыг удирдлага болгон ажилласан. Үүнээс харахад (3) Урт хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан 15 хүүхэд, (4) Богино хугацааны хохирогч хамгааллын үйлчилгээ авсан 55 хүүхэд байна. Гэвч урт хугацааны хамгааллын үйлчилгээ үзүүлдэг нь зөвхөн Талита Ази ТББ байгаа нь богино хугацааны хамгааллын үйлчилгээ авсан хохирогчийн тоо урт хугацааны хамгааллын үйлчилгээ авсан хохирогчдын тооноос гурав дахин байна.
- Судалгаанд хамрагдсан нийт өрхийн (n=204) эцэг эхчүүдийн 65.7% нь хүүхэд хамгааллын үйлчилгээг гадны ямар нэг дэмжлэггүйгээр авч чадна гэж хариулсан бөгөөд үүнээс зорилтот өрхийг тусгайлан авч үзэхэд ердөө 35.8% нь дээрх хариултыг өгсөн байна. Харин зорилтот бус өрхийн эцэг эхчүүдийн өгсөн хариулт үүнээс бараг хоёр дахин өндөр буюу 64.2%-тай байгаа юм. Иймд зорилтот өрхийн эцэг эхчүүдэд зориулж хүүхэд хамгааллын үйлчилгээг хэрхэн, хаанаас авах талаарх мэдлэг, ойлголт болон хандлагыг дээшлүүлэхэд төслийн хүрээнд тусгайлан анхаарах шаардлагатай болохыг судалгааны дүн илтгэн харуулж байна.

Судалгааны гол дүгнэлтэд үндэслэн хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлд дараах зөвлөмжийг санал болгож байна.

### **Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:**

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгааг хийх замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдийг уялдуулах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг илүү хохирогч төвтэй хандлагад үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх;
- Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлж буйг илрүүлэхэд анхаарлаа хандуулах, түүнтэй холбоотой эрх зүйн орчин сайжруулах ажлыг эхлүүлэх,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартыг судалгааны үр дүнд үндэслэн шинэчлэх талаар холбогдох байгууллагад нь мэдэгдэх.

### **Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- Иргэд олон нийтийг хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, ойлголт мэдлэгийг дээшлүүлэхийн тулд сургалт болон нөлөөллийн ажлуудад хамруулах, соён гэгээрүүлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад төслийн үйл ажиллагааг чиглүүлэх;
- Төслийн хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ИНБ-ын сайн туршлагыг сурталчлах, туршлага хуваалцах сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ыг чадавхжуулж, улмаар төрийн байгууллагатай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд тогтмол, төлөвлөгөөт мониторинг үнэлгээ хийх аргачлалын талаар холбогдох төрийн ба ТББ-уудад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;

### **Хохирогч хамгааллын чиглэлээр:**

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хохирогч хамгааллын үйлчилгээнд хамруулах зохицуулалтыг тусгах;
- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх удирдамж боловсруулан батлах, хэрэгжилтийг хангах;
- Хохирогчийг илрүүлэх, таньж тогтоох, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг таниулах зорилгоор хүүхэд хамгааллын оролцогч талуудын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургах тогтолцоог бий болгох;
- Хохирогч хамгааллын үйлчилгээнд зориулсан санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгах, батлуулах;
- Хүүхдэд зориулсан төрөлжсөн, нас харгалзахгүй, тусгай хэрэгцээт хүнийг байрлуулах боломжтой хамгаалах байрыг бий болгох.

### **Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:**

- Хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч тал болох эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүн худалдаалах болон хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэжлийн мэдлэг олгох сургалтыг тасралтгүй зохион байгуулах;
- Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар хүний наймааны төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан байдлыг засаж, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын дагуу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байх нөхцөлийг хангах чиглэлээр эрх бүхий байгууллагад нь зөвлөмж хүргүүлэх;
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг яаралтай боловсруулан батлах талаар эрх бүхий байгууллагад зөвлөмж хүргүүлэх;
- Төлбөрийн чадваргүй насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлүүлэх эрхийг баталгаатай хангах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар эрх бүхий байгууллагад нь зөвлөмж хүргүүлэх;

#### **Хамтын ажиллагааны чиглэлээр:**

- Төрийн байгууллагын хамтын ажиллагааны чиг үүргийг тодорхой болгож, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх: ямар асуудлыг шийдвэрлэхэд, чухам аль түвшинд, төрийн ямар байгууллага, хэрхэн хамтарч ажиллах ёстойг нарийвчлан журамлах (журмын төсөл боловсруулах)
- Төр, ТББ хооронд салбар дундын мэдээлэл солилцох сүлжээг бий болгох замаар нэгдсэн ойлголттой болгох, уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, оролцогч байгууллагууд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааны гүйцэтгэлээ жил бүр үнэлж хэвших;

#### **Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх, сурталчлах, ялангуяа зорилтот бүлгийн өрхөд (ажилгүй, орлогогүй, ядуу, олон хүүхэдтэй, эмзэг г.м) хүрч ажиллах, мэдээллээр хангах, нөлөөллийн стратеги боловсруулах;
- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэхдээ эцэг эх, асран хамгаалагчдад зөвхөн урьдчилан сэргийлэх төдийгүй хариу үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ойлголтыг хамтад нь цогц хэлбэрээр хүргэх, мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах, цахим сурталчилгаа явуулах, аян, нөлөөллийн арга хэмжээг явуулахдаа тухайн чиглэлээр туршлагатай, чадавхтай ТББ-уудын давуу талд тулгуурлан төслийн хүрээнд хамтарч ажиллах.

## Хавсралт 1. Хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, тэдний үзүүлж буй үйлчилгээ

- **Анбаунд Монгол ТББ** нь сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр түлхүү ажиллахын зэрэгцээ хохирогч хамгаалал, хохирогч нарт анхан шатны үйлчилгээ үзүүлдэг байна. Хамгаалах байр шаардлагатай тохиолдол үйлчилгээ үзүүлэгч өөр байгууллага руу шилжүүлдэг.
- **Иргэдэд туслах хүний эрхийн төв** нь хууль зүйн туслалцаа, зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ илүүтэй үзүүлдэг байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд 20 орчим хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс тав орчим нь насанд хүрээгүй хүүхэд эзэлсэн.
- **Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ** нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод кейс менежментийн үйлчилгээний тогтолцоогоор хохирогч төвтэй үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна. Сэтгэл зүйн болон хууль зүйн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг. 2017-2021 оны байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн 3 хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, засал, болон бусад үйлчилгээг үзүүлсэн туршлагатай.
- **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг Үндэсний сүлжээ** нь хүн худалдаалах гэмт хэргийн улмаас бэлгийн мөлжлөгт өртсөн нэг үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн байгуулагдсан цагаас эхлэн албадан хөдөлмөрт өртсөн хохирогч хүүхдэд жил бүр 40 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байлаа. Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэх жагсаалтыг 2016 онд шинэчлэн батлуулахад нөлөөллийн ажил хийсэн байна.
- **Хүүхэд хамгааллын Үндэсний сүлжээ** нь хүүхэд хамгааллын чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллахдаа бодлогын орчинд нөлөөллийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулсан байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг боловсруулахаас эхлээд батлуулах үйл явцад ажилласан. Сүүлийн гурван жилийн хугацаанд ХХГХ-т өртсөн нэг хүүхдийг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна.
- **Хүчирхийллийн эсрэг үндэсний төв** нь 20 орчим хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн түүнчлэн хохирогчдод аюулгүй байдлыг хамгаалалт, эрүүл мэндийн үйлчилгээ, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн туслалцаа, дэмжлэгт хамруулах, боловсролыг тасралтгүй хөгжүүлэх үйлчилгээ, орон гэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлдэг байна.
- **Талита-Ази ТББ** нь удаан хугацаагаар хамгаалах байр ажиллуулахын зэрэгцээ сэтгэл заслын цогц үйлчилгээ үзүүлдэг байна. Талита-Ази ТББ нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг урт хугацаанд хамгаалах байранд байрлуулдаг ба нэг дор эмэгтэй 4, эрэгтэй 2 үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай. Сүүлийн гурван жилийн байдлаар ХХГХ-т өртсөн 26 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн ба дээд тал нь нэг хохирогчийг гурван жилийн хугацаатай байрлуулж байжээ<sup>70</sup>. Цар тахал гарсан цагаас эхлэн хүүхэд, эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн тоо эрс өссөн дүнтэй байна. Тухайлбал он гарснаас хойш, 108-ын хамгаалах байранд нийт 50 орчим дуудлага ирсний 90 гаруй хувь нь бэлгийн хүчирхийллийн хохирогчид байсан бөгөөд, зөвхөн гэр бүлийн хүрээнд гарсан хэргүүд хамаарч байна. Улмаар, энэ оны эхний саруудын байдлаар нэг цэгийн үйлчилгээ болон түр хамгаалах байруудаар үйлчлүүлсэн хүмүүсийн тоо бусад үеийнхтэй харьцуулахад 87%-аар өссөн бөгөөд энэхүү нөхцөл

<sup>70</sup>Талита Ази ТББ нь 2013 оноос хойш үйл ажиллагаагаа 8 дахь жилдээ явуулж байна. Энэ хугацаанд нийт 39 хохирогчид туслалцаа үзүүлсний 9 нь ГБХ-ийн хохирогч, 30 нь ХХГХ-ийн хохирогч байна. Талита Ази ТББ-аас 2021/06/07-ны байдлаар авсан мэдээлэл.

байдалтай уялдуулан төслийн дэмжлэгтэйгээр зөвхөн охидыг хамгаалах байраа яаралтай өргөжүүлэн, хөвгүүдийн хамгаалах байрыг Талита байгууллагын нөөцөд суурилан ажиллуулахаар болсон.

- **Лантуу дохио ТББ** нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд туслалцаа үзүүлж байсан. Харин ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлж байсан туршлага байхгүй. Ид шидийн орон 1, 2 гэсэн хамгаалах байр ажиллуулдаг. Ид шидийн орон 1 нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг ба 20 хүүхэд байрлуулах багтаамжтай, хөл хорио тогтоосон үеэс эхлэн цэцэрлэгийн үйлчилгээг хаагаад 40 хүүхдийн ортойгоор үйл ажиллагаа явуулж байна. Ид шидийн орон 2 нь амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд хөгжлийн чиглэлээр сургалт, хүмүүжлийн үйлчилгээ үзүүлдэг.
- **Хүйсийн тэгш эрх төв ТББ** нь ХХГХ-тэй тэмцэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тогтвортойгоор ажиллаж байгаа байгууллага юм. Анхан шатны туслалцаанд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн үйлчилгээ, ахуй хэрэглээ байдаг бол нөхөн сэргээх үйлчилгээнд нь сэтгэл засал, өмгөөллийн туслалцаа, мэргэжлийн баримжаа олгох сургалт зэрэг багтдаг байна. 2007 оноос эхлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилго бүхий хоёр хамгаалах байрыг Улаанбаатар хот болон Замын Үүд сумд ажиллуулдаг байна. Хилийн чанадад ХХГХ-т өртсөн хохирогчдыг эх нутаг нь аюулгүйгээр эргүүлэн авчрах ажлын олон улсын болон төрийн байгууллагатай хамтран ажилладаг байна.
- **Гүүд Нэйборс ОУТББ** нь сүүлийн 2 жилийн хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаагүй харин бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ руу холбон зуучилдаг.
- **ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээ** нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд туслалцаа үзүүлдэг олон улсын байгууллагын харьяа байгууллага. Гэхдээ бид шууд санхүүжилт байдаггүй. Төсөв санхүүгээ өөрсдөө төсөл бичих замаар босгодог. Жил бүрийн 7 дугаар сарын 30 нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Хөх зүрхний аяныг 2013 оноос эхлэн зохион байгуулдаг болсон. Сүүлийн хоёр жил хүн худалдаалахтай тэмцэх Дэд зөвлөлөөс аян тэмдэглэн өнгөрүүлэх санхүүжилтийг тэндерээр авч хэрэгжүүлсэн байдаг. Илүүтэй урьчилан сэргийлэх ажил болох сурталчилгаа, сургалт зохион байгуулдаг.
- **Гэмтэл согог судлалын үндэсний төв дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн** хувьд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд туслалцаа үзүүлдэг ба хүнд, ноцтой хэргүүд дээр мэргэжлийн байгууллагууд болох Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ, Гүнж төвтэй хамтран ажилладаг байна. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаагүй.
- **Өмнөговь аймгийн Түр хамгаалах байрны** хувьд 2019 онд байгуулагдсан ба одоогийн байдлаар нийт 100 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Энд бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд багтана. ХХГХ-т өртсөн хүүхэд үйлчилгээ үзүүлж байгаагүй байна.
- **Дорноговь аймгийн Түр хамгаалах байр**<sup>71</sup> хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хоёр хохирогчийг цагдаагийн байгууллагаас хүлээн авч Замын Үүд сум дахь ГБХЗГ-ын дэргэдэх Түр хамгаалах байранд байрлуулсан. Тэдгээр хохирогчдод нийгмийн халамжийн болон бусад үйлчилгээ үзүүлсэн.

---

<sup>71</sup> Сайншанд нэг, Замын үүд суманд нэг Түр хамгаалах байр ажиллаж байна.

## Хавсралт 2. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, түүний төрөл, хэлбэр, хүний нөөц, санхүүжилт, цаашид нэн шаардлагатай үйлчилгээний нэгтгэл

№	Байгууллагын нэрс	Насанд хүрээгүй хохирогч /2017-2021/	Үйлчилгээний төрөл, хэлбэр	Үйлчилгээний үе шат	Холбон зуучлах	Хүний нөөц	Санхүүжилт	Цаашид шаардлагатай үйлчилгээ
1	Гүүд нэйборс ОУТББ	10 кейс	Сэтгэл зүйн зөвлөгөө, засал	→ Илрүүлэх → Нөхцөл байдлын үнэлгээ хийх → Холбон зуучлах → Гэр бүлд нэгтгэх	Хөөрхөн зүрх ТББ  Хамтарсан баг	5 сэтгэл зүйч ажилладаг	ОУБ	Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ
2	Анбаунд Монгол ТББ		→ Анхан шатны туслалцаа → Түрээсийн байр → Аюулгүй газраас хангах → Хоол хүнс → Хувцас → Гэр бүл рүү буцаах	→ Илрүүлэх → Холбон зуучлах → Гэр бүлд нэгтгэх	Цагдаагийн байгууллага  Хүйсийн тэш эрх төв		ОУБ	Нөхөн сэргээх, сэргээн засах үйлчилгээ Гэр бүл нь нэгтгэх Хүүхдэд зориулсан төрөлжсөн хамгаалах байр чухал.
3	Иргэдэд туслах хүний эрхийн төв	10 хэргийн 3-5 насанд хүрээгүй хохирогч байдаг. Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн.	→ Хууль зүйн туслалцаа → Өмгөөллийн үйлчилгээ		→ Хүйсийн тэгш эрх төв → Хөөрхөн зүрх → Хүчирхийллийн эсрэг үндэсний төв → Талита-Ази ТББ	Хуульч, өмгөөлөгч	ОУБ	
4	Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ	3 хүүхэд үйлчилгээ үзүүлсэн.	Сэтгэл зүйн зөвлөгөө, засал  Бусад	Кейс менежментийн үйлчилгээний тогтолцоогоор үйлчилгээгээ үе шаттайгаар үзүүлдэг.	→ Хүйсийн тэгш эрх төв → Ид шидийн орон → Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Мэргэшсэн сэтгэл зүйч	Төрийн байгууллага ОУБ	Хамгааллын тогтолцоог нарийвчлан гаргах хэрэгтэй. Мэргэжлийн хандлагыг өөрчлөх
5	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээ	1 кейс	Сэтгэл зүйн үйлчилгээ, засал	→ Холбон зуучлах			ОУБ	



6	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ	1 кейс	→ Гэр худалдан авч өгөх	→ Холбон зуучлах →	→ Талита – Ази ТББ	Нийгмийн ажилтан	ОУБ	
7	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Жилд 4-5 хүүхэд гэхээр 20 орчим хүүхэд	→ Өмгөөллийн үйлчилгээ → Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ → Эрүүл мэндийн үйлчилгээ → Боловсролыг тасралтгүй хөгжүүлэх үйлчилгээ → Орон гэртэй болоход дэмжлэг үзүүлэх	→ Хохирогчийг хүлээн авна → Бүртгэл хөтөлнө. Үйлчлүүлэгчдээ файл үүсгэнэ.		Мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, өмгөөлөгчтэй.	Төрийн байгууллага ОУБ	Төрөлжсөн хамгаалах байр хэрэгтэй. Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг тусад нь байрлуулах хэрэгтэй. Тэд рүү чиглэсэн үйлчилгээ хүртэл өөр байдаг.
8	Лантуу дохио ТББ	ХХГХ-т өртсөн хүүхэд үйлчилгээ үзүүлээгүй. Бэлгийн хүчирхийлэл, ГБХ-д өртсөн 240 орчим хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн.	→ Хамгаалан байрлуулах → Сэтгэл зүйн зөвлөгөө → Боловсролын үйлчилгээ → Нийгмийн ажил үйлчилгээ → Эрүүл мэндийн үйлчилгээ	→ Илрүүлэх → Нөхцөл байдлыг үнэлгээ → гэр бүлд нэгтгэх		Хамгааллын баг нь эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зохицуулагч гэсэн бүрэлдэхүүнтэй.	Улсын төсөв ОУБ	→ Урт хугацааны нөхөн сэргээх → Халамжийн үйлчилгээ → Хамгааллын үйлчилгээ → Нөхөн сэргээх үйлчилгээ
9	Талита Ази	26 хүүхэд	→ Хамгаалах байранд байрлуулах → Нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ	→ Кейс менежмент	Цагдаа Тагнуул	Нийгмийн ажилтан Сэтгэл зүйч	ОУБ	→ Салбар дундын мэдээлэл солилцоог сайжруулах → Богино хугацааны түр хамгаалах байр → Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ
10	ХТЭТ	30 хүүхэд	→ Анхан шатны туслалцаа → Нөхөн сэргээх үйлчилгээ	→ Илрүүлэх → Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр → Холбон зуучлах	Цагдаагийн байгууллага	Нийгмийн ажилтан Сэтгэл зүйч	Төрийн байгууллага ОУБ	Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ

			<ul style="list-style-type: none"> <li>→ Эх оронд эргүүлэн авчрах</li> <li>→ 2 төрлийн хамгаалах байр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Гэр бүлд нэгтгэх</li> </ul>				
11	ГССҮТ-НЦҮТ	Сүүлийн дөрвөн жилд 80 болсон байна, ноднин 120 байсан тэгэхээр дунджаар 400 байх гэж бодож байна, тоолоогүй. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	<ul style="list-style-type: none"> <li>→ 24-72 цаг байрлуулдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Хохирогч ирлээ шүүх эмнэлэгт хандаад гэмтлийн гаралтай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд хорооны хамтарсан багийг дууддаг.</li> <li>→ Хорооны хамтарсан багийн ирээд уулздаг.</li> <li>→ Нөхцөл байдлын үнэлгээ хийдэг.</li> <li>→ Холбон зуучлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Хүчирхийллийн эсрэг үндэсний төв</li> <li>→ Хөөрхөн зүрх ТББ</li> <li>→ Гүнж төв</li> </ul>		Улсын төсөв ОУБ	Сэтгэцийн эмчилгээ Амиа хорлолт нэмэгдэж байна. Өсвөр насныхан их байна. долоо хоногт 3-4 тохиолдол тогтмол ирдэг болсон.
12	Өмнөговь аймгийн Түр хамгаалах байр	100 гаруй хүүхэд үйлчилгээ үзүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн тоо	<ul style="list-style-type: none"> <li>→ Сэтгэл зүйн зөвлөгөө</li> <li>→ Эрх зүйн зөвлөгөө</li> <li>→ Нийгмийн халамжийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Илрүүлэх үйлчилгээ</li> <li>→ Нөхцөл байдлын үнэлгээ</li> <li>→ Холбон зуучлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Цагдаагийн байгууллага</li> </ul>	Нийгмийн ажилтан	Улсын төсөв ОУБ	Сэтгэл зүйн зөвлөгөө, засал
13	Дорноговь аймгийн Түр хамгаалах байр	2 хүүхэд Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхэд	<ul style="list-style-type: none"> <li>→ Сэтгэл зүйн зөвлөгөө</li> <li>→ Нийгмийн халамжийн үйлчилгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Илрүүлэх үйлчилгээ</li> <li>→ Нөхцөл байдлын үнэлгээ</li> <li>→ Холбон зуучлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Үжин хүүхэд хөгжлийн төв</li> <li>→ Ид шидийн орон</li> <li>→ Эрүүл мэндийн газар</li> </ul>	2 нийгмийн ажилтантай	Улсын төсөв Орон нутгийн төсөв ОУБ	Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ Мэргэжлийн сэтгэл зүйч, НА
14	НҮБ-ын ОУШХБ	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг, Мөн Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг буцаадаг.	<ul style="list-style-type: none"> <li>→ Олон улсын байгууллагын баримтлагдаг баримт бичгийг ашигладаг.</li> <li>→ Эх нутагт нь эргүүлэн авчрах, буцаах үйлчилгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Илрүүлэх үйлчилгээ</li> <li>→ Нөхцөл байдлын үнэлгээ</li> <li>→ Холбон зуучлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Талита Ази</li> <li>→ Хүйсийн тэгш эрх эрх төв</li> <li>→ Экпат үндэсний сүлжээ</li> </ul>		ОУБ	Үйлчилгээний байгууллагын хамтын ажиллагаа  Улсын төсөвт санхүүжилт суулгах, батлах

			<ul style="list-style-type: none"> <li>→ Эргэн амжилттай суурьших хөтөлбөрт хамруулдаг.</li> <li>→ Тэтгэлэг олгодог</li> </ul>					
15	ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээ	<p>Жил 20 хүүхэд Нийт 80 хүүхэд Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, өртөх эрсдэл өндөр хүүхдүүдэд байдаг.</p> <p>Эрэгтэй хүүхэд авдаггүй.</p>	<ul style="list-style-type: none"> <li>→ Зөвлөгөө өгөх</li> <li>→ Сургалтад хамруулах</li> <li>→ Дэмжих бүлэг хичээллүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Илрүүлэх үйлчилгээ</li> <li>→ Нөхцөл байдлын үнэлгээ</li> <li>→ Холбон зуучлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Төрийн бус байгууллага</li> <li>→ Цагдаагийн байгууллага</li> </ul>	Нийгмийн ажилтантай	ОУБ Төрийн байгууллага	<p>Хохирогчийг таньж тогтооход мэргэжилтнүүдийг сургах сургалт зохион байгуулах</p> <p>Сурталчилгааг Улаанбаатар хот гадна орон нутагт зохион байгуулах</p> <p>Технологийн шийдлийг ашиглан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх</p> <p>Хамтын ажиллагааг сайжруулах</p> <p>Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ илүү төрөлжих хээргтэй.</p>

### Хавсралт 3. Хүний наймаатай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт

#	Гэрээ конвенцын нэр	Батлагдсан	Хүчин төгөлдөр болсон	Монгол Улс нэгдэн орсон
1.	Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахыг хориглох тухай олон улсын конвенц	1921.09.30	<b>1950.04.24</b>	
2.	Боолын худалдаа, боолчлолыг хориглох тухай конвенц	1926.09.25	<b>1927.03.09</b>	
3.	Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29-р конвенц	1930.06.28	1932.05.01	2005.03.15
4.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1945-06-26	1945-10-24	1961-10-27
5.	Хүн худалдаалах болон мөлжих зорилгоор бусдын биеийг үнэлүүлэхийг хориглох тухай конвенц	1949.12.02	1951.07.25	
6.	Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц	1956.09.07	1957.04.30	1968.10.31
7.	Албадан хөдөлмөрийг устгах тухай ОУХБ-ын 105-р конвенц	1957.06.25	1959.01.17	2005.03.15
8.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1979.12.18	1981.09.03	1981.07.20
9.	Хүүхдийн эрхийн тухай конвенц	1989.11.20	1990.09.02	1990.01.26
10.	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц	1993.05.29	1995.05.01	2000.04.25
11.	Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм	1998.07.18	2002.07.01	2002.04.05
12.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182-р конвенц	1999.06.17	2000.11.19	2001.02.26
13.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц	2000.11.15	2003.09.29	2008.05.16
14.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	2000.11.15	2003.12.25	2008.05.16
15.	Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол	2000.05.25	2002.01.18	2001.11.12

## Хавсралт 4. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа<sup>72</sup>

Нэр	Үйл ажиллагаа
ХЗДХЯ-ГХУСАЗЗАА	<ul style="list-style-type: none"> <li>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрт хохирогчийн нас, хүйсээс үл хамаарах шаардлагатай бүх тусламж, үйлчилгээг холбогдох байгууллагуудад үзүүлэх, уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</li> <li>Салбар дундын хамтын ажиллагаа, уялдааг зохицуулах, нэгдсэн тайлан, төлөвлөгөөг боловсруулж холбогдох талуудад танилцуулдаг.</li> <li>ХЗДХ-ийн сайд, БСШУС-ын сайдын 2017 оны А/253, А/252 дугаар хамтарсан тушаалаар ЕБС-ийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сайн дурын үйл ажиллагааны журам баталж, хэрэгжилтийг хангаж ажилладаг.</li> <li>ГХУСАЗЗ-ийн ажлын албанаас энэ төрлийн хэрэгтэй тэмцэх, таслан сэргийлэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий алба хаагчдад зориулсан сургалтууд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</li> </ul>
ГХЯ-ны Консулын газар	<ul style="list-style-type: none"> <li>Хар тамхи зөөвөрлөх, ХХГХ-тэй тэмцэх асуудалтай холбоотой тайланг жил бүр ГХУСАЗЗАА-д тайлагнах, хамтарч ажиллах мэдээлэл солилцож ажилладаг.</li> <li>Насанд хүрээгүй хүүхдийг ХХГХ-т өртөх, нэн ялангуяа бэлгийн мөлжлөгт өртөх, албадан хөдөлмөр эрхлүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, өртөж буй учир шалтгааныг олж тогтоох гэх мэт чиглэлээр бусад яамд, холбогдох төлөөлөгчийн газруудтай хамтран ажилладаг.</li> <li>ХХГХ-тэй тэмцэх Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Монгол Улсын иргэдийг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, хохирогчийг тогтоох, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хохирогчид тодорхой хэмжээнд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг.</li> <li>Бусад улс орноос хохирогчийг авахдаа хоёр талын улсын элчин сайдын яам, хууль хүчний байгууллага, холбогдох байгууллагуудтай дипломат шугамаар хамтран ажилладаг.</li> </ul>
ХНХЯ	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн мөлжлөг, урьдчилан сэргийлэхтэй холбоотой, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх арга хэмжээ авах талаар тусгасан.</li> <li>Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэхэд хүсэлтийн дагуу судалж, үрчлэлтийн зөвлөлөөр хянаж эцэслээд ГИХГ-руу шилжүүлж ажилладаг.</li> </ul>
БШУЯ	<ul style="list-style-type: none"> <li>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/253, А/252 дугаар хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сайн дурын "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалт, чадавхжуулах, сургуулийн эргүүлийн үйл ажиллагаатай уялдуулах, бүлгэмийн үйл ажиллагааны журмыг баталсан. Ингэснээр хүүхдийн үе тэнгийн зөрчил, хэрэг, хүүхдүүд бие биенээ уруу татах, урьдчилан сэргийлэх, эрх зүйн хэм хэмжээний талаар мэдлэг олж авах боломж бүрдэж байгаа нь цаашид гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад ач холбогдолтой гэж үзэж байна.</li> <li>ЕБС-ын дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, аливаа төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох сэдвүүдийг насны онцлогт тохируулан тодорхой хичээлүүдэд тусгасан байна.</li> </ul>
ЭМЯ	<ul style="list-style-type: none"> <li>ГССҮТ-өө түшиглээд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажилладаг</li> </ul>
ХХЕГ-Хилийн шалган нэвтрүүлэх алба	<ul style="list-style-type: none"> <li>Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал А/49: Хүүхдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам</li> <li>Хилийн шалган нэвтрүүлэх журмыг тус тус баримталж ажилладаг</li> </ul>

<sup>72</sup> Уг бүртгэл нь ярилцлагын мэдээлэлд үндэслэсэн ерөнхий үйл ажиллагааны чиглэл бөгөөд тухайн байгууллагын хэрэгжүүлсэн бүх ажлыг илэрхийлэхгүй болно.

ГИХГ	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд үрчлэлтийн асуудлыг ХХГХ-ийн асуудалтай холбож авч үздэг учир Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ талаарх тоо, мэдээ, баримтыг гаргаж өгдөг</li> <li>• Хүүхэд худалдаалахтай тэмцэх чиглэлд Үрчлэлтийн дараах хяналтыг журмын дагуу хэрэгжүүлж тухайн эх эсвэл тухайн улсын нийгмийн ажилтнаар бэлтгүүлж тайлан хүлээж авдаг.</li> </ul>
МХЕГ	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн албадан, тэвчишгүй хөдөлмөрийн асуудалд хяналт тавьж ажилладаг</li> <li>• ХХГХ, албадан хөдөлмөр, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн асуудлаар ХТЭТ-тэй хамтран төрийн албан хаагч (хөдөлмөрийн байцаагч) нарын дунд нэг өдрийн сургалт зохион байгуулсан.</li> <li>• 2018 онд Стандарт хэмжил зүйн газартай хамтран “Морь унаач хүүхдийн хамгаалах хэрэгсэл”-д стандарт тогтоосон.</li> <li>• ААН-үүдэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хяналт шалгалт хийж зөрчлийг илрүүлж шийдвэрлэдэг.</li> <li>• Хилээр эд, эрхтэн гаргаж байгаа асуудалд хяналт тавьж ажилладаг.</li> <li>• 2018 онд албан бус секторт Хүүхдийн хөдөлмөрийн тандалт судалгаа хийсэн.</li> </ul>
ГБХЗХГ	<ul style="list-style-type: none"> <li>• ГБХЗХГ-ын харьяа 108 Хүүхдийн тусламжийн утасны дуудлагын үйлчилгээний төвийг хариуцан ажилладаг.</li> <li>• 108 Хүүхдийн тусламжийн утасны дуудлагад бүртгэгдсэн холбогдох кейсүүдийг цагдаа руу холбон зуучилдаг.</li> <li>• Түр хамгаалах байруудыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилладаг.</li> <li>• Харилцаа холбоо зохицуулах хороо, Харилцаа холбоо мэдээлэл технологийн газартай хамтран хамтарсан тушаалаар 2018 онд “Цахим орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох” 3 талын хамтарсан тушаалыг баталсан. Энэ хүрээнд нэлээн олон талуудыг оролцуулсан төлөвлөлт хийж, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар урьдчилан сэргийлэх, нөгөө талаас цахим орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэгтэй холбоотой томоохон судалгаануудыг холбогдох хууль зүйн салбарын байгууллагууд нь хийх, хэрэглэгчийн шүүлт программыг хэрэглээнд нэвтрүүлэх, үндэсний хот сайтыг хөгжүүлэх ажлууд хийгдсэн байна.</li> <li>• Цахим орчин дахь хэвлэл мэдээллийн чиглэлд сэтгүүлчдийг хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулах, мэдээ нийтлэл бичих, хүүхдийн эрх зөрчигдөх, хохирогчийг мэдээллийн нууцлал алдагдсан байдалтай тавих асуудлыг бууруулах ажлуудыг 2018 оноос НҮБ-ын Хүүхдийн сан, ДЗМОУБ, Японы Хүүхдийг Ивээх Сан, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.</li> <li>• Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээг илүү мэргэжлийн үйлчилгээтэй уялдуулсан байхаар сайжруулах, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээг хуульчилж өгөх тал дээр саналаа хүргүүлсэн.</li> <li>• Таван аймгийн хилийн боомттой “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр хэрэгжүүлэх санаачлагыг эхлүүлсэн.</li> <li>• 2019-2020 оны хооронд “Эрх үүргийн оролцоо” амьдрах ухааны 12 багц гарын авлагыг Европын холбоо, ОУХБ-тай хамтран шинэчлэн боловсруулсан. Энэхүү гарын авлага нь ХХГХ, хүүхдийн хөдөлмөр мөлжлөгтэй холбоотой модулиудыг багтаасан бөгөөд энэ хүрээнд 60 гаруй сургагч багшийг бэлтгэсэн. Тус гарын авлагаар хүүхдийн зуслан, хүүхдийн ордон, гэр бүлийн зөвлөгөө өгөх төвүүд, залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүүхэд залуучууд, гэр бүлийг чадавхжуулах ажлыг хийсэн.</li> <li>• Хүүхдийн хөгжил, хамгааллын Үндэсний хөтөлбөрийн 2 дугаар шатны төлөвлөгөөнд ОУШХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, ОУХБ, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-тай хамтран орон нутагт ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд, сурагчид, багш, төрийн болон ТББ-уудыг чадавхжуулах ажил хийгдэж байна.</li> <li>• Замын-Үүдэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.</li> </ul>



## Хавсралт 5. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ОУБ-ын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа<sup>73</sup>

Нэр	Үйл ажиллагаа
Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)	<ul style="list-style-type: none"> <li>2021 оны 3 сараас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага хамтран “Мөрөөдлийн шүхэр” ХХГХ, бэлгийн мөлжлөгийн талаар ойлголт мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх үндэсний мэдээллийн аян</li> </ul>
НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн болон ТББ-ын урьдчилан сэргийлэх чиглэлийн төслүүд, сургалт, сурталчилгааны ажлуудад техникийн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, санхүүжүүлэх</li> <li>2018 оноос хойш “We protect” төслийг хэрэгжүүлэхэд МУ-ын засгийн газарт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. “We protect” үндэсний загвар нь 1.Бодлого засаглал, 2.Хуулийн хэрэгжилт 3.Хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдал. 4.Нийгмийн хүчин зүйл, 5.Хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, 6.Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа гэсэн зургаан зүйлтэй цогц бүтцийн зураглал гаргаад ажиллаж байна.</li> </ul>
ОУХБ (ILO)	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн харилцааны суурь 8 конвенцыг соёрхон батлуулсан ба үүнээс хоёр нь албадан хөдөлмөртэй холбоотой байна</li> <li>Олон улсын шүүхийн практикийг хэрэгжүүлэх</li> <li>Техникийн зөвлөгөө өгөх, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулах</li> <li>Модуль сургалтын хөтөлбөр боловсруулах</li> <li>Сэтгүүлчид, хүүхдийн эрхийн байцаагч зэрэг мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтууд зохион байгуулах</li> <li>Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтийг Монгол хэл дээр орчуулан гаргасан</li> <li>ОУХБ-ын 3R (rights, responsibilities and representation) буюу орон нутагт нь хүүхэд залуучуудыг хэрхэн хүнд хөдөлмөрөөс салгах талаар олон улсын модулийг Монголд нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.</li> </ul>
Дэлхийн Зөн Монгол ОУБ (World Vision International Mongolia)	<ul style="list-style-type: none"> <li>1998-2017 оны хооронд ДЗМОУБ нь Хүүхэд Хөгжил Хамгаалал Хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн болон гудамжны хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нийгэмшүүлэх, хөгжүүлэх, амьдрах ухаанд сургах чиглэлээр төсөл хэрэгжүүлж байсан.</li> <li>2014 оны 3 сараас Хүүхдийн төлөө үндэсний газар, Мобиком корпораци, Дэлхийн зөн Монгол ОУБ хамтран “Хүүхдийн тусламжийн утас 108” төслийг хэрэгжүүлсэн.</li> <li>ДЗМОУБ нь 2023 он гэхэд хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаагаараа дамжуулан 500,000 хүүхэд, ялангуяа хүнд нөхцөлд амьдарч байгаа 140,000 хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрахын төлөө зорин ажиллаж байна.</li> <li>2020 оноос эхлэн Европын холбооны санхүүжилтээр “Time’s up –Sexual Violence Against Children project” төслийг хэрэгжүүлж байна.</li> </ul>
Гүүд Нэйборс ОУТББ (Good neighbours)	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр болон Гэрээр зочлох үйл ажиллагаа, бусад хөтөлбөрүүдийн хүрээнд зорилтот орон нутгийн хүүхдүүдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд холбон зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.</li> <li>Цахим хуудсаар дамжуулж ХХГХ, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрөөс сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.</li> </ul>
Азийн сан (The Asia Foundation)	<ul style="list-style-type: none"> <li>АНУ-ын Засгийн газрын санхүүжилтээр 2017-2019 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “хүн худалдаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлага төлөвшүүлэх” сургалтаар нийслэл, аймгийн цагдаа, прокурор, шүүгч,</li> </ul>

<sup>73</sup> Уг бүртгэл нь ярилцлагын мэдээлэлд үндэслэсэн ерөнхий үйл ажиллагааны чиглэл бөгөөд тухайн байгууллагын хэрэгжүүлсэн бүх ажлыг илэрхийлэхгүй болно.

	<p>хил хамгаалах, иргэн, харьяатын алба хаагчдын хамтарсан сургалтуудыг зохион байгуулсан ба үүнд төрийн байгууллагын 700 гаруй албан хаагч хамрагдсан.</p>
<p>Японы Хүүхдийг Ивээх Сан (Save the Children Japan)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, боловсролыг дэмжих, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой байдлын чиглэлээр судалгаа, мэдээ мэдээлэл, зөвлөгөө, сургалт, нөлөөллийн ажлын чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.</li> <li>• 2015 оноос эхлэн Хүүхэд хамгааллын төвийг ажиллуулж эхэлсэн бөгөөд Хүүхдийн эрх, нөлөөллийн ажлын чиглэлээр хамтарсан багаар хэрхэн ажиллах, нийгмийн ажилтнуудад чиглэсэн кейс менежментийн үйлчилгээг хэрхэн, яаж үзүүлэх талаар арга зүйн чадавхжуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг.</li> </ul>

## Хавсралт 6. Хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-ын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа<sup>74</sup>

Нэр	Үйл ажиллагаа
Анбаунд Монгол ТББ	<ul style="list-style-type: none"> <li>“Дамжин өнгөрөх ажиглалт” төслийн хүрээнд Замын-Үүдийн хилээр гадаад улс уруу гарч буй эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг илрүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, хилийн шалган нэвтрүүлэхтэй хамтарч ажилладаг.</li> <li>Порнографын эсрэг, эрэлтийн эсрэг үйл ажиллагаа, аян зохион байгуулдаг. Тухайлбал цахим орчинд ХХГХ, тэр дундаа бэлгийн мөлжлөгийн эрэлтийн талаар урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээдэг</li> <li>Эрсдэлд байгаа хүүхдийг хамгаалах, төрийн байгууллагад холбон зуучлах, хамтрах</li> <li>Сурагч, оюутан залуучуудад чиглэсэн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах</li> <li>“Миний хотод биш” аянг зохион байгуулж, мэдээллийн платформ хөгжүүлсэн</li> </ul>
Талита Ази	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд төр, төрийн бус байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулсан /кейс менежмент, хамгаалах байрны менежмент, сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээ г.м</li> </ul>
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>Хүчирхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сургалт, аян, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх</li> <li>Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг үндэсний арга хэмжээ зохион байгуулах</li> <li>Миний биеийн халдашгүй орон зай хүүхэд хамгаалах картан тоглоом</li> <li>Өмгөөлөгч, мөрдөн байцаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой анимэйшн, брошюр, гарын авлага боловсруулж, түгээх</li> </ul>
Хүйсийн тэгш эрх төв	<ul style="list-style-type: none"> <li>Сургалт, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.</li> <li>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх кампанит аян арга хэмжээ зохион байгуулсан.</li> <li>Цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарт сургалт явуулсан, гарын авлага гаргасан. Сэтгүүлч нарыг сургасан.</li> <li>Судалгаа хийсэн.</li> <li>Зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг.</li> <li>Гадаад улс уруу зорчиж буй охид, эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх мэдээлэл өгдөг.</li> <li>ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сэрэмжлүүлэх зорилгоор хохирогчийн түүхээр баримтат кино, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтийн хүргэсэн.</li> </ul>
Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ	<ul style="list-style-type: none"> <li>“Хүчирхэг охид-Хүчирхэг улс” хөтөлбөр хэрэгжүүлж, болзооны бэлгийн хүчирхийлэл, ураг төрлийн, цахим, нийтийн гудамж талбайд зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг таниулах анимейшнуудыг бүтээсэн.</li> <li>Мөн бэлгийн хүчирхийллийг охидод таниулж мэдүүлэх урьдчилан сэргийлэхээр гар утасны аппликейшн хөгжүүлж, сайжруулах ажлууд явж байна</li> <li>2015 оноос хойш цахим гэмт хэргийн кейсүүд их ирсэн учир энэ чиглэлээр 2016 оноос хойш өнөөг хүртэл үндэсний хэмжээнд хүүхдүүдэд сургалт хийсэн. Цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар ЕБС-ийн 20,000 гаруй сурагчдад сургалт зохион байгуулсан.</li> </ul>
Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ	<ul style="list-style-type: none"> <li>ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сэрэмжлүүлэх зорилгоор хохирогчийн түүхээр баримтат кино, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтийн хүргэсэн.</li> <li>Өсвөр үеийнхний биеэ үнэлэлтийн талаар тоон судалгаа гүйцэтгэсэн</li> <li>Авто радиотой хамтарч таксины жолооч нарт насанд хүрээгүй хүүхдийг зуучлахгүй байх, тийм тохиолдолд мэдээлэхийг уриалсан радиогийн цуврал контент хийсэн</li> <li>Сэтгэл зүй, нийгмийн ажил хууль зүйн болон өмгөөллийн зөвлөгөө, үйлчилгээг тогтмол үзүүлэх</li> <li>Хууль зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн сэжигтэн, хохирогч, гэрч хүүхдүүдийн эрхийн асуудлаар хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтарч ажилладаг.</li> <li>Хэсгийн ахлагч, багийн дарга нарыг сургах</li> </ul>

<sup>74</sup> Уг бүртгэл нь ярилцлагын мэдээлэлд үндэслэсэн ерөнхий үйл ажиллагааны чиглэл бөгөөд тухайн байгууллагын хэрэгжүүлсэн бүх ажлыг илэрхийлэхгүй болно.

	<ul style="list-style-type: none"> <li>• Хөршийн холбоо, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, тэгээд баг хороон дээрээ хүүхдийн эрсдэлийг тогтоолгох судалгаа, эрсдэлийн үнэлгээний баазыг бий болгох талаар сүүлийн 2018-2020 онд үүнд илүү их чиглэж ажилласан.</li> </ul>
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний сүлжээ	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эрх ашгийг хамгаалах,</li> <li>• Олон улсын туршлага судлах</li> <li>• Насанд хүрээгүй хүнээр эрхлүүлэхийг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинээр батлуулсан/2016</li> <li>• Олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа/Харандааны адал явдал, видео контент бэлтгэсэн</li> </ul>
ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээ	<ul style="list-style-type: none"> <li>• Хүн худалдаалахтай тэмцэх Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажилладаг.</li> <li>• 2013 оноос эхлэн Хөх зүрхний аянг зохион байгуулж байна.</li> <li>• Үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж байсан туршлагатай.</li> <li>• Хүн худалдаалах гэмт хэрэг, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой болох сургалт, судалгаа хийдэг.</li> <li>• Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд 80 хүүхдэд туслалцаа үзүүлсэн байна. Эдгээр хүүхдүүд нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид байсан.</li> <li>• Төрийн болон бусад байгууллагын сургалтуудад сургагч багшаар ажиллаж байсан.</li> </ul>

## Хавсралт 7. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтын асуулт, бодомжуудад зөв хариулсан хувь

#	Бодомж	Зөв хариулсан хувь	
		Эцэг эх (n=204)	Хүүхэд(n=204)
<b>I Албадан хөдөлмөр эрхлэлт</b>			
1.1	Монгол Улсад хэдэн наснаас эхлэн хүүхэд хөдөлмөр эрхлэхийг хуулиар хүлээн зөвшөөрдөг вэ? Зөв хариулсан хувь	14.7	22.6
1.2	“Бичиг баримт, цалингаар нь барьцаалж анх тохирсноосоо өөр чиг үүргийг гүйцэтгүүлэх” нь албадан хөдөлмөрт тооцогдоно гэдэгтэй санал нийлж буй хувь	74.02	73.04
1.3	“Ямар ч ажил хийлгэсэн бай хүүхдэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн л бол албадан хөдөлмөр гэж үзнэ” гэдэгтэй санал нийлж буй хувь	91.67	86.76
1.4	“Ямар ч ажил хийлгэсэн бай хүүхдээр ажил хийлгээд тохирсон цалин хөлсөө олгоогүй л бол албадан хөдөлмөр гэж гэж үзнэ” гэдэгтэй санал нийлж буй хувь	92.16	82.84
1.5	“Ямар ч ажил хийлгэсэн, насанд хүрээгүй л бол албадан хөдөлмөр гэж үзнэ” гэдэгтэй санал нийлэхгүй хувь	14.71	16.18
<b>II Бэлгийн мөлжлөг</b>			
2.1	“Эмзэг ядуу байдлыг нь далимдуулан охидын биеийг нь үнэлүүлж, ашиг олох” гэдгийг бэлгийн мөлжлөг мөн хэмээн зөв тодорхойлсон хувь	11.76	9.80
2.2	“Хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглаж буй видео бичлэгээ интернэтээр борлуулж, ашиг олох” гэдгийг бэлгийн мөлжлөг мөн хэмээн зөв тодорхойлсон хувь	2.94	5.88
2.3	“Бэлгийн мөлжлөг нь хүн худалдаалах гэмт хэргээс ялгаатай, өөр ойлголт” гэдэгтэй санал нийлэхгүй хувь	50.00	34.31
2.4	“Бэлгийн мөлжлөг нь хүчиндэх гэмт хэргээс ялгаатай, өөр ойлголт” гэдэгтэй санал нийлж буй хувь	37.75	36.27
2.5	“Бэлгийн мөлжлөг нь биеэ үнэлэлтээс ялгаатай, өөр ойлголт” гэдэгтэй санал нийлж буй хувь	50.00	47.06
<b>III Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ</b>			
3.1	“Хүчээр бэлгийн харилцаанд орох” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарахгүй хэмээн тодорхойлсон хувь	22.06	32.84
3.2	“Бусадтай бэлгийн харилцаанд хүчээр оруулж, ашиг олох” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарна хэмээн тодорхойлсон хувь	87.75	88.73
3.3	“Ажил хийлгээд цалин хөлсөө тохирсон хугацаанд нь өгөлгүй хойшлуулах” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарахгүй хэмээн тодорхойлсон хувь	43.14	63.24
3.4	“Хүүхдээр гуйлга гуйлгуулж, олсон мөнгийг нь хураан авах” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарна хэмээн тодорхойлсон хувь	73.04	60.29
3.5	“Бэлгийн харилцаанд орж буй, бичлэгээ интернэтээр дамжуулж зарж борлуулж, ашиг олох” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарна хэмээн тодорхойлсон хувь	84.31	83.82
3.6	“Хулгайлж авч яваад эд эрхтнийг нь зарах” нь хүүхдийн эсрэг үйлдсэн ХХГХ-т хамаарна хэмээн тодорхойлсон хувь	98.04	97.06